



НЭЭЛТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ХЭСГИЙН ХЭРЭГЖИЛТ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ХЭСГИЙН ХЭРЭГЖИЛТ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны багийн бүрэлдэхүүн:

Судлаач Г.Оюунболд (LL.M.)

Судлаач Э.Ганцэцэг (LL.M.)

Судлаач П.Намуун (LL.M.)

Улаанбаатар хот

2022 он

ННА 67.3
ДАА 340.009
О-634

ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН
ЗАРИМ ЗҮЙЛ, ХЭСГИЙН ХЭРЭГЖИЛТ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны багийн бүрэлдэхүүн:

Судлаач Г.Оюунболд (LL.M.)

Судлаач Э.Ганцэцэг (LL.M.)

Судлаач П.Намуун (LL.M.)

© Нээлттэй Нийгэм Форум, 2022 он

Уг тайланг ашиглахдаа эх сурвалжийг дурдана уу.

Хаяг: Монгол Улс

Улаанбаатар хот-14240

Сүхбаатар дүүрэг

Жамьян гүний гудамж-5/1

Утас: 976-76113207

Факс: 976-11-324857

Вэб: <http://www.forum.mn>

И-мэйл: osf@forum.mn

ISBN 978-9919-9926-2-0

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	6
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ	7
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	8
НЭГ. УДИРТГАЛ	9
1.1. Судалгааны ажлын үндэслэл, шаардлага	9
1.2. Судалгааны ажлын зорилго, зорилт	10
1.3. Судалгааны хамрах хүрээ, арга зүй	10
1.4. Судлагдсан байдлын тойм	15
ХОЁР. СУДАЛГААНЫ ДҮН	22
2.1. Эрх зүйн орчин	22
2.1.1. Монгол Улсын Үндсэн хууль	22
2.1.2. Хууль тогтоомж болон эрх зүйн бусад зохицуулалт	22
2.1.3. Цагдаагийн албаны тухай хуулиар зохицуулсан тодорхой ажиллагааны талаарх цагдаагийн алба хаагчдын мэдлэг, хандлага	24
2.2. Цагдаагийн албаны тухай хуулиар зохицуулсан тодорхой ажиллагаа тус бүрийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ	35
2.2.1. Шаардлага тавих	35
2.2.2. Тайлбар авах	41
2.2.3. Хүний бичиг баримт шалгах	44
2.2.4. Түр саатуулах	51
2.2.5. Хуулийн этгээдийн баримт бичиг шалгах	53
2.2.6. Орон байр, бусад газарт нэвтрэн орох	56
2.2.7. Үзлэг хийх	60
2.2.8. Эд зүйл, баримт бичиг түр хураан авах	63
2.2.9. Тээврийн хэрэгслийг зогсоож шалгах	67
2.2.10. Согтуурсан, мансуурсан байдлыг шалгах	71

ГУРАВ. ДҮГНЭЛТ	74
ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ	78
Хавсралт 1. Цагдаагийн алба хаагчдаас авсан санал асуулгын хариулт	82
Хавсралт 2. Иргэдээс авсан санал асуулгын хариулт	156

ӨМНӨХ ҮГ

Монгол Улс дэлхий нийтийн чиг хандлагыг баримтлан олон нийтэд түшиглэсэн цагдаагийн шинэчлэлийг шат дараатай хэрэгжүүлж ирсэн бөгөөд энэ хүрээнд Цагдаагийн албаны тухай хууль 2013, 2017 онд тус тус шинэчлэгдсэн билээ. Нээлттэй Нийгэм Форум нь шинэ тутам байгуулагдсан бүтцийн дүрэм, журмыг боловсруулах, алба хаагчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах, гадаадад мэргэжил дээшлүүлэх сургалтад шинэ тутам үүсэж буй асуудал хариуцсан зарим ажилтныг хамруулах зэрэгт техникийн туслалцаа үзүүлж ирлээ. Үүний зэрэгцээ олон улсад хэрэглэгддэг арга зүйг ашиглан цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээ, үйл ажиллагааны тодорхой чиглэлүүдээр хөндлөнгийн цуврал мониторинг, цагдаагийн албаны дүрэм журам, ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхэд нийцсэн эсэх зэрэгт дүн шинжилгээ хийж, шинэчлэлийн үйл явцыг баримт судалгаа, мэдээллээр хангахыг зорилоо.

Бид энэ удаа Цагдаагийн албаны тухай хуулийн тодорхой ажиллагаа явуулах зохицуулалтын хэрэгжилтэд үнэлгээ хийж, тулгамдсан асуудлуудыг тодруулах судалгааны ажлыг судлаач Г.Оюунболд, Э.Ганцэцэг, П.Намуун нарын гүйцэтгэсэнээр Та бүхэнд хүргэж байна. Тус судалгааны тайланд тодорхой ажиллагааг нарийвчлан зохицуулж буй зарим дүрэм журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр журам боловсруулах, цагдаагийн алба хаагчийн сургалтын чанар, үр нөлөөг дээшлүүлэх, давтамж, үргэлжлэх хугацааг нь нэмэгдүүлэх зэрэг санал зөвлөмж дэвшүүлсэн байна. Мөн цагдаагийн алба хаагч, иргэдийн дунд үл ойлголцол, маргаан ихээр гарч байгаа болохыг аль аль талын санал, байр суурь баталж буйг цаашид анхаарах шаардлагатай юм.

Нээлттэй Нийгэм Форум нь манай улсад өрнөж буй эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг бодлогын судалгаа, мониторингоор дэмжихийг зорьж ирсэн бөгөөд эдүгээ 30 орчим судалгаа олны хүртээл болоод байна. Мөн бид дээрх судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулах, бодлого, шийдвэрт тусгуулах зорилгоор цуврал хэлэлцүүлэг эхлүүлээд байгаа бөгөөд хэлэлцүүлгийн видеог Та бүхэн манай цахим хуудас, нийгмийн сүлжээнээс олж үзэх боломжтойг дуулгахад таатай байна.

ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх хууль
ЦАтХ	Цагдаагийн албаны тухай хууль
ЦБҮАЖ	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний Комисс
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
УДШ	Улсын Дээд шүүх
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
ТББ	Төрийн бус байгууллага

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Судалгаанд оролцсон иргэдийн насны ангилал

Хүснэгт 2. Судалгаанд оролцсон иргэдийн хүйс

Хүснэгт 3. Судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдын нас

Хүснэгт 4. Судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдын хүйс

Хүснэгт 5. Судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдын ажилласан жил

Хүснэгт 6. Судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдын цолны зэрэглэл

Хүснэгт 7. Судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдын ажиллаж буй чиглэл

Хүснэгт 8. Журам болон хуулийн заалтын харьцуулалт

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Цагдаагийн албаны тухай хуульд заасан тодорхой ажиллагааг хэрэгжүүлэх 10 заалтыг ямар зорилгоор хэрэглэдэг вэ?

График 2. Хуульд заасан тодорхой ажиллагаа нь өдөр тутмын хэвшмэл үйл ажиллагаа мөн эсэх

График 3. Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа төрөл бүрийн аян, нөлөөллийн арга хэмжээ нь дээрх тодорхой ажиллагааг хэрэгжүүлэхэд ямар нөлөө үзүүлдэг вэ?

График 4. Удирдах албан тушаалтнаас тухайн өдөрт шийдвэрлэх ёстой баримт бичиг, шалгах тээврийн хэрэгслийн тоо, торгуулийн хэмжээг тогтоож өгдөг эсэх

График 5. Тодорхой ажиллагааг хэрэгжүүлэх үед түгээмэл тохиолддог бэрхшээл болон иргэдийн хандлага

График 6. Цагдаагийн албаны тухай хуульд заасан тодорхой ажиллагааг гэмт хэрэг, зөрчил илрүүлэх, таслан зогсооход ашигладаг эсэх

График 7. Аливаа нөлөөллийн аян, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ямар үр нөлөө үзүүлдэг болох

График 8. Цагдаагийн алба хаагч ямар тохиолдолд бичиг баримт шалгах, түр саатуулах, тээврийн хэрэгслийг зогсоож шалгах арга хэмжээ авдаг болох

График 9. ЦЕГ-ын 102 тусгай дугаарт ирсэн гомдол, мэдээллийн судалгаа

НЭГ. УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн заасан. Энэ хүрээнд 2012 оноос эхэлсэн цагдаагийн байгууллага, хууль сахиулах ажиллагааны эрх зүйн шинэтгэл үндсэндээ 2017 он хүртэл үргэлжилж, Цагдаагийн албаны тухай хуулийг хоёр ч удаа шинэчлэн найруулж баталсан.

Цагдаагийн албаны тухай хуулийг 2017 оны 2 дугаар сард баталж мөн оны 3 дугаар сараас даган мөрдөж эхэлсэн бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “...хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасан нь тус хуулийн зарим зүйл, заалтад үнэлгээ хийх үндэслэл болсон.

Цагдаагийн албаны тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтэд үнэлгээ хийхдээ цагдаагийн алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд нэг талаас иргэд болон цагдаагийн алба хаагчдын хооронд үүсэж буй үл ойлголцол, түүний шалтгаан нөхцөл, нөгөө талаас цагдаагийн алба хаагчийн зүгээс тодорхой үйл ажиллагаа явуулж, хууль хэрэглэхдээ хүний эрх зөрчиж буй эсэхийг судлан тодорхойлох нь ач холбогдолтой гэж үзлээ.

1.1. Судалгааны ажлын үндэслэл, шаардлага

Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хүний халдашгүй эрхийг хязгаарлах тодорхой төрлийн арга хэмжээг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Цагдаагийн албаны тухай хуулиудаар тус тус зохицуулсан. Иргэд, олон нийтийн зүгээс цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, зарим төрлийн арга хэмжээнд

шүүмжлэлтэй хандаж, улмаар хүний эрхэд халддаг, хүний эрх зөрчдөг гэсэн үзэл, хандлага давамгайлах болсон. Харин хууль сахиулагчдын хувьд иргэд, олон нийтийн дунд хуулийг үгүйсгэх үзэл газар авч, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зориуд саатуулсан, цагдаагийн алба хаагчийн эсрэг чиглэсэн, үүний улмаас албаны нэр хүндэд халдсан үйлдэл нэмэгдсэн гэсэн байр суурьтай байна. Иймд хөндлөнгийн байр сууринаас асуудлыг судалж, нотолгоонд суурилсан дүгнэлт хийн, асуудлыг шийдвэрлэх арга зам санал болгох зорилгоор энэ судалгааг хийж гүйцэтгэв.

1.2. Судалгааны ажлын зорилго, зорилт

Цагдаагийн албаны тухай хууль дахь хүний эрхийг хязгаарлах (тодорхой арга хэмжээ)-аар зохицуулсан зарим заалтыг (тус хуулийн Дөрөвдүгээр бүлгийн 23 дугаар зүйл. Шаардлага тавих, 24 дүгээр зүйл. Тайлбар авах, 25 дугаар зүйл. Хүний бичиг баримт шалгах, 26 дугаар зүйл. Түр саатуулах, 27 дугаар зүйл. Хуулийн этгээдийн баримт бичиг шалгах, 28 дугаар зүйл. Орон байр, бусад газарт нэвтрэн орох, 29 дүгээр зүйл. Үзлэг хийх, 30 дугаар зүйл. Эд зүйл, баримт бичиг түр хураан авах, 31 дүгээр зүйл. Тээврийн хэрэгслийг зогсоож шалгах, 32 дугаар зүйл. Согтуурсан, мансуурсан байдлыг шалгах) хэрэгжүүлэх явцад хүний эрхийн зөрчил гарч байгаа эсэхийг тодорхойлоход оршино.

1.3. Судалгааны хамрах хүрээ, арга зүй

Судалгааг хийхдээ Цагдаагийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш буюу 2017 оны 2 дугаар сарын 9-нөөс 2021 он хүртэлх 4 жилийн хугацаанд цагдаагийн алба хаагчаас хэрэгжүүлдэг тодорхой ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийг тоон болон чанарын судалгааны арга ашиглан гүйцэтгэлээ. Энэ хүрээнд Цагдаагийн албаны тухай хуулийн 23-32 дугаар зүйлийн хэрэгжилтийг цагдаагийн байгууллагаас гаргадаг албан ёсны тоон мэдээлэлд тулгуурлан үнэлэв. Мөн тухайн зүйл, хэсэгтэй холбоотой Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, эрх зүйн бусад баримт бичиг болон эрх нь зөрчигдсөн тухай иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийн шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийлээ. Судалгааны түүвэрт дээрх хуулийн заалтуудыг өдөр тутмынхаа ажилд түлхүү хэрэгжүүлдэг цагдаагийн алба хаагчдыг хамруулахыг эрмэлзсэн.

Цагдаагийн албаны тухай хуульд хэрэгжилтийн үнэлгээ хийхдээ Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд заасны дагуу судалгааны ажил төлөвлөж, уг аргачлалын 3.7 дугаар зүйлд заасан аргуудаас ашиглан мэдээлэл цуглуулж ажилласан. Мөн цуглуулсан мэдээлэлдээ тулгуурлан хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэхдээ аргачлалын:

- 5.1 дүгээр зүйлд зааснаар тогтоосон шалгуур үзүүлэлт болон харьцуулах хэлбэрийг ашиглан цуглуулсан мэдээллийг үнэлэх;
- 5.2 дугаар зүйлд зааснаар цуглуулсан мэдээлэл нь бодитой, хангалттай эсэх, зайлшгүй шаардлагатай, эсхүл хамааралтай эсэхийг үнэлэх;
- 5.3 дугаар зүйлд зааснаар хууль тогтоомж хэрэгцээ, шаардлага, зорилготойгоо нийцэж байгаа эсэхийг судалж, мэдээллийг задлан шинжилсний үндсэн дээр тоон болон чанарын үнэлэлт өгөх;
- 5.4 дүгээр зүйлд зааснаар үнэлгээг илэрхийлсэн дүгнэлт гаргах аргуудыг тус тус ашигласан.

Үүний зэрэгцээ хууль зүйн судалгааны бусад тодорхой аргууд ашигласан бөгөөд судалгааны явцад хүний эрхийн зөрчил болон хууль хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэх, асуудлыг тодруулах нөхцөл байдал шинээр илэрсэн тул тоон болон чанарын судалгааны аргыг түлхүү ашиглаж дүгнэлт хийлээ.

Судалгааны санал асуулгад 1035 цагдаагийн алба хаагч хамрагдсан бөгөөд энэ нь цагдаагийн байгууллагын алба хаагчдын 10 орчим хувийг эзэлж байна. Дээр дурдсанаар нийтийн хэв журам хамгаалах болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр ажилладаг алба хаагчид түлхүү оролцсон. Ярилцлагад цагдаагийн 100 алба хаагч, удирдах албан тушаалтнууд хамрагдсан нь хангалттай төлөөлөл хэмээн үзсэн.

Цагдаагийн алба хаагчдаас нийт 8 асуулттай, дэлгэрэнгүй тайлбарлан бичиж хариулах боломжтой санал асуулгыг 3 сарын хугацаанд хүлээн авах үеэр дээр дурдсан 1035 алба хаагч хамрагдсан бөгөөд санал асуулга нь дараах асуултуудаас бүрдсэн. Үүнд:

- Цагдаагийн албаны тухай хуульд заасан тодорхой ажиллагаа хэрэгжүүлэхтэй холбоотой (24 дүгээр зүйл. Тайлбар авах, 25 дугаар

зүйл. Хүний бичиг баримт шалгах, 26 дугаар зүйл. Түр саатуулах, 27 дугаар зүйл. Хуулийн этгээдийн баримт бичиг шалгах, 28 дугаар зүйл. Орон байр, бусад газарт нэвтрэн орох, 29 дүгээр зүйл. Үзлэг хийх, 30 дугаар зүйл. Эд зүйл, баримт бичиг түр хураан авах, 31 дүгээр зүйл. Тээврийн хэрэгслийг зогсоож шалгах, 32 дугаар зүйл. Согтуурсан, мансуурсан байдлыг шалгах) зохицуулалтыг ямар зорилгоор хэрэглэдэг болох;

- Дээрх тодорхой ажиллагааг хэрэгжүүлэх нь өдөр тутмын хэвшмэл үйл ажиллагаа мөн эсэх;
- Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа төрөл бүрийн аян, нөлөөллийн арга хэмжээ нь дээрх тодорхой ажиллагааг хэрэгжүүлэхэд ямар нөлөө үзүүлдэг болох;
- Удирдлагаас бичиг баримт, тээврийн хэрэгсэл зэргийг шалгах, торгох тоо хэмжээ тогтоож өгдөг эсэх;
- Хуульд заасан тодорхой ажиллагааг хэрэгжүүлэх үед түгээмэл тохиолддог бэрхшээл болон иргэдийн хандлага;
- Дээрх арга хэмжээг гэмт хэрэг, зөрчил илрүүлэх, таслан зогсооход ашигладаг эсэх;
- Дүрэм зөрчөөгүй тээврийн хэрэгслийг ямар үндэслэл, шалтгаанаар зогсоож шалгадаг болох (зөвхөн Тээврийн цагдаагийн албаны алба хаагчдад);
- Зөрчил гаргаагүй иргэн, хуулийн этгээдийн бичиг баримтыг ямар үндэслэл, шалтгаанаар шалгадаг болох (Зөвхөн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн алба хаагчдад).

Мөн “Цагдаагийн албаны тухай хуульд заасан тодорхой ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг хэрэгжүүлж буй өнөөгийн нөхцөл байдал, анхаарах зүйл, тулгамдсан асуудал” сэдвийн хүрээнд 100 цагдаагийн алба хаагчтай ярилцлага хийсэн.

Түүнчлэн санал асуулгын зарын дагуу Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хэрэгт холбогдон шалгагдаж буй, Цагдаагийн албаны тухай хуулиар өөрийнх нь эрх ашиг хөндөгдсөн гэж үзсэн 153 иргэн судалгаанд хамрагдсан. Эдгээр иргэн хувийн мэдээллээ өгөхөөс татгалзсан, өгөх дургүй байсан тул зөвхөн насны ангилал, хүйсийн мэдээлэл орууллаа. Судалгаанд хамрагдсан иргэдийн 3 хүн тутмын нэг нь 31-36 насны иргэд

байна. Иргэдээс дараах асуултын хүрээнд судалгаа авсан:

- Цагдаагийн алба хаагч хуульд заасан тодорхой ажиллагаа хэрэгжүүлэхдээ үндэслэл, шалтгаанаа тодорхой тайлбарладаг эсэх;
- Тодорхой бус байдлаар саатуулсны дараа гэмт хэрэг, зөрчилд буруутгахыг оролдсон, эсхүл шийтгэл оногдуулсан эсэх;
- Ямар ч үндэслэлгүйгээр тээврийн хэрэгслийг зогсоож, бичиг баримт хурааж, түр саатуулсан үед танд учирсан хохирол, эсхүл дарамт шахалт нь таны эрхийг зөрчсөн эсэх;
- Зөрчигдсөн эрхээ хамгаалуулах, сэргээлгэхээр төрийн болон төрийн бус байгууллагад хандан, гомдол хүсэлт гаргаж байсан эсэх;
- Таны бодлоор цагдаагийн алба хаагч тодорхой ажиллагаа хэрэгжүүлэх үндэслэлгүй үед хэрэглэж, хүний эрх зөрчиж байгаа шалтгаан нөхцөл нь юу болох;
- Хэрэгжүүлэх үндэслэл байхгүй үед тодорхой ажиллагаа явуулж байгаа нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилго агуулдаг гэдэгтэй санал нийлэх эсэх;
- Цагдаагийн алба хаагч ямар тохиолдолд бичиг баримт шалгах, түр саатуулах, тээврийн хэрэгслийг зогсоож шалгах арга хэмжээг түлхүү хэрэглэдэг болох.

Хүснэгт 1. Судалгаанд оролцсон иргэдийн насны ангилал

Нас	Тоо	Хувиар
19-25	27	18%
26-30	39	25%
31-36	54	35%
37-42	15	10%
42-оос дээш	18	12%

Хүснэгт 2. Судалгаанд оролцсон иргэдийн хүйс

Хүйс	Тоо	Хувиар
Эрэгтэй	122	79.7%
Эмэгтэй	31	20.3%

Хүснэгт 3. Судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдын нас

Нас	Тоо	Хувиар
19-25	194	18.7%
26-30	251	24.3%
31-36	352	34%
37-42	171	16.5%
42-оос дээш	67	6.5%

Хүснэгт 4. Судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдын хүйс

Хүйс	Тоо	Хувиар
Эрэгтэй	881	85.1%
Эмэгтэй	154	14.9%

Хүснэгт 5. Судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдын ажилласан жил

Ажилласан жил	Тоо	Хувиар
1-5	414	40%
6-10	211	20.4%
11-16	256	24.7%
16-20	114	11%
21-ээс дээш	40	3.9%

Хүснэгт 6. Судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдын цолны зэрэглэл

Цолны зэрэглэл	Тоо	Хувиар
Ахлагч бүрэлдэхүүн	541	52%
Дунд офицер	385	37%
Ахлах офицер	109	11%

Хүснэгт 7. Судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдын ажиллаж буй чиглэл

Ажиллаж буй чиглэл	Тоо	Хувиар
Нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр	699	67%
Замын хөдөлгөөн зохицуулах чиглэлээр	133	13%
Бусад	203	20%

Уг судалгааг нийтэд хүртээмжтэй, ойлгомжтой байлгах үүднээс энэ чиглэлээр хийсэн бусад судалгааны тайлангийн бүтцэд өмнө нь төдий л ашиглаж байгаагүй зураглал ашиглаж тайланг боловсрууллаа. Судалгааны тайлан нь судлагдсан байдлын тойм, эрх зүйн орчин, социологийн

судалгааны дүн, тодорхой ажиллагаа бүрд хийсэн дүн шинжилгээ, үндсэн дүгнэлт, санал зөвлөмж гэсэн бүтэцтэй. Өөрөөр хэлбэл, Цагдаагийн албаны тухай хуулийн 23-32 дугаар зүйлд заасан тодорхой ажиллагаа бүрд дүн шинжилгээ хийснээрээ хүний эрхийн зөрчил бий болоход хүргэж буй ажиллагааг тодорхой харуулах ач холбогдолтой гэж үзсэн.

1.4. Судлагдсан байдлын тойм

Цагдаагийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш хэрэглэгчийн үнэлгээний тайлан, ажил дүгнэх үзүүлэлт нь хүний эрхийн зарчимд нийцсэн эсэх талаар судалгааны хэд хэдэн ажил хийгдсэн байх бөгөөд эдгээр судалгаанд Цагдаагийн албаны тухай хуульд заасан тодорхой үйл ажиллагаа явуулахдаа хүний эрх зөрчдөг, ямар үндэслэл, шалтгаанаар явуулж байгаагаар тайлбарладаггүйгээс харилцааны шинжтэй зөрчлүүд гардаг тухай дүгнэсэн байдаг. Үүнтэй холбоотойгоор өмнө хийгдсэн таван төрлийн судалгааны тоймыг дор дурдлаа:

1. Цагдаагийн байгууллага: Хэрэглэгчийн үнэлгээ - 2017¹

Энэхүү судалгааг иргэн, алба хаагч, хамтран ажилладаг байгууллага гэсэн 3 бүлэгт хувааж, аймаг, нийслэлийн 810 иргэн, 402 алба хаагч, 10 байгууллагын 291 төлөөлөл оролцуулан судалсан байна. Ингэхдээ судалгаанд хамрагдсан иргэдийн хүйс, гэр бүлийн байдал, нас, боловсролын байдал, гэр бүлийн гишүүдийн орлого, орон сууцны төрөл, нутаг дэвсгэр, бүсчлэл гэх мэт олон хүчин зүйлийн мэдээллийг маш өргөн хүрээнд гарган өгчээ. Судалгааны асуулгыг олон улсын жишигт нийцүүлэн, бусад улсад түгээмэл хэрэглэгддэг аргачлалд тулгуурлан боловсруулж, үр дүнг нь улсын хэмжээнд, бүс, Улаанбаатар хотын дүүрэг, аймаг тус бүрээр гаргаж нэгтгэн дүгнэсэн байна.

- **Иргэдийн сэтгэл ханамжийг тодорхойлох** зорилгоор цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг 5 бүлэгт багтах 32 асуултын хүрээнд тодорхойлохыг зорьсон бөгөөд үүнд:
 - Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэг - дунд зэрэг (3.4 хувь);

¹ Б.Энхболд, Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, П.Мөнхтуяа, Г.Золзаяа, Ш.Баярдулам. Цагдаагийн байгууллага: Хэрэглэгчийн үнэлгээ – 2017. Нээлттэй Нийгэм Форум, УБ., 2018. https://forum.mn/index.php?sel=project&menu_id=554&obj_id=5478

- Хууль ёсны зарчмын хэрэгжилт - дунд зэрэг (3.11 хувь);
- Орон нутгийн аюулгүй байдал - дунд зэрэг (3.08 хувь);
- Алба хаагчийн ёс зүй - сэтгэл ханамжгүй (2.96 хувь);
- Гэмт хэргээс түгших хандлага - Иргэдийн 71.9 хувь нь түгшдэг гэж хариулжээ. Иргэдийн түгших мэдрэмж өндөр байх тусам цагдааг үнэлэх иргэдийн сэтгэл ханамж буурдаг.
- **Алба хаагчдын сэтгэл ханамжийг тодорхойлох** зорилгоор 7 бүлгийн 28 асуултаар үнэлж үзэхэд 3.52 хувьтай буюу дунд зэрэг гэсэн үнэлгээ өгсөн байна. 3-4 хүн тутмын нэг нь ажил албандаа сэтгэл хангалуун бус байгааг энэхүү судалгаагаар тогтоожээ.
- **Хамтран ажилладаг байгууллагын үнэлгээг** тодорхойлохдоо 5 бүлэг 11 асуултаар 332 хүнээс санал авсан ба хамтран ажиллахад шуурхай, итгэлтэй, хариуцлагатай, хялбар гэсэн эерэг санал дийлэнх нь байна. Мөн ёс зүй, харилцаа, хандлагын доголдолтой, дээрэнгүй, соёлгүй, ялгаварлаж харилцдаг, хүнд сурталтай, албан бичгийн хариу удаан, мэргэжлийн мэдлэг чадвар дутуу гэх шүүмж хэлжээ. Хамтран ажилладаг байгууллагын хувьд “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ил тод бөгөөд эргэлзээгүй байдаг” гэсэн асуултад сэтгэл ханамжийн хамгийн бага үнэлгээ өгсөн байна.

2. Цагдаагийн албаны үйл ажиллагааны журам хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх - 2020²

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны 258 журмын 60 гаруйд нь хүний эрхийг хангах, хамгаалах заалт тусгасан байгааг уг судалгаагаар тогтоожээ. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам (ЦБҮАЖ) нь хүний эрхэд нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийхдээ судалгааны ажилд өргөн хэрэглэгддэг тоон болон чанарын судалгааны загвар, арга зүйг хослуулж онол, эрх зүйн зохицуулалт, гадаад, дотоодын судлаачдын бүтээл, судалгааг харьцуулан судаллаа. Мөн хууль тогтоомж, үйл ажиллагааны журмуудад тодорхой шалгуур, үзүүлэлт тогтоон түүвэрлэн судлах, сонгосон баримт бичигт дүн шинжилгээ хийх, өөрсдийн хийсэн дүн шинжилгээг магадлан шалгахын тулд экспертүүд болон янз бүрийн түвшний алба хаагчидтай уулзаж ярилцах фокус ярилцлагын

² Д.Эрдэнэбаатар, Ю.Бадамханд, Д.Булган. Цагдаагийн албаны үйл ажиллагааны журам хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх – 2020. Нээлттэй Нийгэм Форум, УБ., 2020. http://forum.mn/res_mat/2020/Tsagdaagiinalbaniiuilajillagaaniiuram.pdf

арга ашиглалаа. Хууль тогтоомж, хүний эрхийн хэм хэмжээнд бүрэн нийцүүлэх үүднээс нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах шаардлагатай 87 журам байна гэж дүгнэжээ. Нийтлэг зөрчлийн хувьд хууль тогтоомжид байхгүй нэр томъёо хэрэглэсэн, эсхүл хууль тогтоомжийг хуулбарлан давтах явдал илүү ажиглагдсан байна. Мөн журмын зорилгоо бүрэн хангаагүй буюу цагдаагийн алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг сахин хамгаалахад зайлшгүй шаардлагатай үйл ажиллагааны дэс дарааллыг нарийвчлан журамлаагүй, хэт ерөнхий байдлаар боловсруулсан журмууд байгаад шүүмжлэлтэй ханджээ.

3. Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд нийцэж буй эсэх - 2020³

Institute for Economics and Peace (IEP), International Police Science Association (IPSA), UN Office of the High Commissioner for Human Rights зэрэг олон улсын байгууллагаас гаргасан “*World internal security and police index*”, “*The assessing the performance index*”-ийг орчуулан, цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх шалгуур үзүүлэлтэд тусгавал зохих үзүүлэлт боловсруулан гаргасан байна. Цагдаагийн алба хаагчийн ажил дүгнэх үзүүлэлт нь хүний эрхийн зарчимд нийцэж байгаа эсэх, ажлыг бодитой дүгнэх арга хэлбэр, шалгуур шаардлага болж чадаж байгаа эсэхийг харьцуулан судлах, үр дүнг нь тодорхойлох зорилгоор тусгайлан бэлтгэсэн анкетын асуултын дагуу Улаанбаатар хотын дүүргүүдийн цагдаагийн хэлтэс, тасгийн болон орон нутаг (нийт 19 аймаг)-ийн цагдаагийн газар, хэлтсийн алба хаагчдаас асуулга авч, үр дүнг нь нэгтгэн гаргажээ. Түүнчлэн тоон судалгаагаар төдий л илрүүлэх боломжгүй асуудлыг тодруулах, алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг бодитой үнэлэх зорилгоор ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын аргыг мөн ашигласан байна. Мөн удирдах болон гүйцэтгэх албан тушаалын 15 хүнтэй чөлөөт ярилцлага хийжээ. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмуудаас хүний эрхтэй шууд болон дам байдлаар уялдаж буй 134 журмыг Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрхийн заалтуудтай харьцуулан судалсан байна. Үүнээс гадна санамсаргүй

³ Д.Эрдэнэбаатар, М.Эрдэнэбаяр, Г.Бямбадорж, Ч.Доржсүрэн, А.Батсайхан. Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд нийцэж буй эсэх - 2020, Нээлттэй Нийгэм Форум, УБ., 2020.

https://forum.mn/res_mat/2021/RS_10.pdf

түүврийн арга ашиглан цагдаагийн байгууллагад ажиллаж буй бүх шатны алба хаагчдын бүлэг үүсгэн, фокус ярилцлагад хамруулжээ. Цагдаагийн алба хаагч тус бүрээр дүн шинжилгээ хийсэн байх бөгөөд үүнд:

1. Эргүүлийн цагдаа (28 үзүүлэлт);
2. Эргүүлийн офицер (26 үзүүлэлт + ажлын онцлогоос шалтгаалан 3 үзүүлэлт);
3. Зохицуулагч цагдаа (38 үзүүлэлт);
4. Хэсгийн байцаагч (40 үзүүлэлт);
5. Мөрдөгч (4 удаа, 7 хоног бүр 13 үзүүлэлт);
6. Олон нийтийн цагдаа (11 үзүүлэлт) гэсэн албан тушаалтнуудын ажил дүгнэх үзүүлэлтийг тус бүрд нь дүгнэжээ.

Түүврийн аргаар сонгосон цагдаагийн 311 алба хаагчаас ажил дүгнэх үзүүлэлтийн талаар судалгаа авсан байх бөгөөд албан тушаалын зэрэглэл, ажилласан жил, насны ангилал, хүйс, дүгнэж буй хугацааны интервалыг мөн оруулжээ. Судалгаанд оролцогчдын 96 нь буюу 31 хувь нь "Алба хаагчийн ажлын чанарыг тооцдоггүй" гэж хариулсан нь алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд зохион байгуулж буй ажил, арга хэмжээний чанар, үр дүнг үл харгалзан, тоон үзүүлэлтээр дүгнэх хандлага давамгайл байгааг илтгэнэ. Мөн судалгаанд оролцогчдын 18 хувь буюу 55 алба хаагч "Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгтэйгээ нийцдэггүй" гэж хариулснаас үзэхэд ажил дүгнэх үзүүлэлтийг боловсруулахдаа ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгтэй нь уялдуулдаггүй, ихэнх тохиолдолд уг тодорхойлолтод тусгасан чиг үүргээс өөр ажил үүрэг гүйцэтгүүлж байгааг илтгэн харуулж байна гэж дүгнэжээ.

4. Цагдаагийн алба хаагч бүх нийтийн бэлэн байдлын үед мөрдөж ажиллах хууль, дүрэм, журмын хэрэгжиж буй байдал⁴

Уг судалгааны ажлын хүрээнд албаны эх сурвалжаас холбогдох тоо баримт, тайлан, судалгаа шинжилгээний тайлан гаргуулж авах, нийтэд нээлттэй эх сурвалжаас эрх зүйн баримт бичиг, эрх бүхий байгууллага,

⁴ Ж.Ганбаатар, Б.Доржзаяа, Л.Нямдаваа. Цагдаагийн байгууллага, алба хаагч "Бүх нийтийн бэлэн байдал"-ын үед мөрдөж ажиллах хууль, дүрэм, журмын хэрэгжиж буй байдал. Нээлттэй Нийгэм Форум, УБ., 2020.

https://forum.mn/res_mat/2021/RS_16%20Police%20Rules%20in%20Emergency%20Situation.pdf

албан тушаалтнаас гаргасан шийдвэрүүдийг цуглуулах, ангилах, тэдгээрт тоон болон чанарын судалгааны арга зүйг хослуулж, хууль тогтоомж, дүрэм журмуудын онол, эрх зүйн үндэслэл, бүрдэл, уялдаа холбоо зэргийг тодорхойлох, харьцуулах замаар хууль зүйн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган, түүнийгээ санал асуулгын дүнгээр шинжлэн баталгаажуулах аргачлалаар судалгааны ажил хийжээ. Коронавируст (COVID-19) цар тахлын улмаас бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин, хорио цээрийн дэглэм тогтоосон үед цагдаагийн байгууллага, алба хаагчийн эрх үүргийг тодорхойлсон хууль, эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх, цар тахалтай тэмцэх ажлыг зохицуулж байгаа хууль, эрх зүйн акт, бүх нийтийн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, “хөл хорио”, “хорио цээрийн дэглэм”, “хязгаарлалтын дэглэм”-ийн тухай ойлголт, эрх зүйн зохицуулалт, хэрэгжиж буй байдал, цагдаагийн байгууллагын үүрэг, оролцоонд дүн шинжилгээ хийх, бүх нийтийн бэлэн байдлын үед цагдаагийн алба хаагч тодорхой үйл ажиллагаа явуулах, албадлага хэрэглэх эрх зүйн үндэслэлийг тогтоох зорилгоор уг судалгааг хийсэн байна. Судалгааны санал асуулгад 8 нэгжийн 1065 алба хаагч хамрагдсан бөгөөд тэдний 63.6 хувь нь “Иргэд Засгийн газар, Онцгой комиссоос гаргасан шийдвэрийг дагаж мөрдөхгүй байна” гэжээ. Ийнхүү хариулсан алба хаагчдын 64,5 хувь нь “Иргэд хэл амаар доромжлон алба хаагчаас тавьсан шаардлагыг эсэргүүцэх хэлбэрийг дийлэнхдээ гаргадаг” гэж хариулжээ. Алба хаагчдын 62.7 хувь нь “үүрэг гүйцэтгэх аюулгүй байдлын баталгаа бага буюу халдвар авах эрсдэл бүхий” гэж тодорхойлсон бол 71.3 хувь нь “Халдвар хамгааллын хувцас, хэрэгсэл дутагдалтай байгаа ба хүрэлцээтэй хэмжээгээр олгох шаардлагатай”, 89.3 хувь нь “Урамшуулал олгохгүй байгаа ба урамшуулал олгох шаардлагатай” гэж үзжээ. Мөн судалгаагаар цар тахлын үед хориглосон, хязгаарласан хэм хэмжээг тодорхой зааж өгөөгүй, эрх бүхий албан тушаалтны шийдвэр тодорхой бус, зарим журам гараагүйгээс хууль сахиулах ажиллагааг тодорхойгүй болгож, иргэд, цагдаагийн алба хаагчдын харилцаанд сөргөөр нөлөөлсөн хэмээн дүгнэжээ.

5. Хэрэглэгчийн үнэлгээ - 2020

Уг судалгаагаар цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, түүний чанар, хүртээмж, энэ талаарх иргэдийн сэтгэл ханамж ямар байгааг тодорхойлохын тулд анкетын санал асуулгыг мэргэжлийн түвшинд

бэлтгэн дүгнэжээ. Ингэхдээ цагдаагийн байгууллагын судлаачдын хүчийг ашиглахын зэрэгцээ мэргэжлийн судалгааны ажилтантай гэрээ байгуулан тоон судалгааг анкетын аргаар, чанарын судалгааг анкет ярилцлагын аргаар гүйцэтгэж, суурь судалгааны хүрээнд бичиг баримтын хоёр төрлийн судалгаа хийсэн байна. Хэрэглэгчийн үнэлгээний анкетын судалгаанд 389 иргэн хамрагджээ. Цагдаагийн байгууллагын харьяа байгууллагын төлөөлөл, хуульчдаас авах асуулгад 95 хүн оролцсон. Мөн экспертийн түвшинд 3 судлаач, үүнээс Ph.D зэрэгтэй 2, төрийн албаны удирдах болон ахлах ажилтан, иргэд, нийт 8 хүнтэй ярилцлага хийх замаар чанарын судалгаа авсан байна. Цагдаагийн байгууллагын цахим хуудсанд шинжилгээ хийж, иргэд мэдээлэл авах боломжоор хангагдсан эсэхийг судалж, цаашид авах арга хэмжээний зөвлөмж гаргажээ. Судалгаанд оролцогчдын 68 хувь нь иргэн, 32 хувь нь төрийн албан хаагч байна. Цагдаагийн байгууллага болон түүний харьяа байгууллагын үйл ажиллагаанд өгсөн ерөнхий сэтгэл ханамж, иргэдийн оролцоо, аюулгүй байдал, шударга ёсны талаарх үнэлгээ гэсэн хэсгийг бүхэлд нь дүгнэж үзвэл энэ үнэлгээ “хангалттай” хэмжээнд буюу нийт 70%-ийн онооноос 67.7% гэсэн үнэлгээ авч байна. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, орчин нөхцөл, төрийн албан хаагчийн харилцааны соёл, ёс зүйн талаарх үнэлгээ, цагдаагийн байгууллагын үйлчилгээний орчин, нөхцөлийн нийлбэр дүн хамгийн өндөр буюу 3.9 гэсэн үзүүлэлттэй гарчээ. Төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмж, харилцаа, ёс зүй, орчин нөхцөлийг үнэлүүлэхээр 18 асуулт тавихад ганцхан “Байгууллагын гадна болон доторх таних тэмдэг, тэмдэглэгээ харагдахуйц ойлгомжтой байдал”-д иргэдийн сэтгэл ханамж дунджаас дээгүүр үзүүлэлттэй гарсан нь нийт 30%-ийн онооноос 26.8%-ийн үнэлгээ авч байна. Төрийн байгууллагын талаарх мэдээлэл авдаг, эсвэл авахыг хүсэж буй сувгуудтай холбоотой сэтгэл ханамжийн байдлын тухай асуултад судалгаанд хамрагдсан иргэдийн 47% нь цахим хаягуудаас, 35% нь телевизээс мэдээлэл авсан байна. Иргэд төрийн байгууллагын мэдээллийг цахим орчин буюу цахим хуудас, телевизийн сувгаар хүлээн авч байгаа бөгөөд энэ хоёр сувгаар авах хүсэлтэй байна. Мөн төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааг мэдээлэл авах нэг суваг гэдгийг иргэд хүлээн зөвшөөрчээ. Эдгээрээс дүгнэж үзвэл салбарын нийт үйл ажиллагаа болон үйлчилгээний чанар, хүртээмжийн үнэлгээ $67.7\% + 26.8\% = 94.5\%$ болж байна. Цагдаагийн байгууллагын 2020 оны үйл ажиллагаанд хийсэн

хэрэглэгчийн үнэлгээгээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, орчин нөхцөл, алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн үнэлгээний нэгдсэн дүн 94.5% буюу 4.7 гэсэн оноотой байна.

Дээрх судалгаануудаас дүгнэхэд цагдаагийн албаны үйл ажиллагаатай холбоотой судалгаа, шинжилгээ давтамжтай хийгдэж, тус салбарт тулгамдаж буй асуудал, хүний эрхийн зөрчил үүсгэж болзошгүй шалтгаан, нөхцөлийг арилгах үүднээс удаа дараа тодорхой санал, зөвлөмж өгч байжээ. Цагдаагийн байгууллага эдгээр судалгааны үр дүнг хүлээн авч, санал, зөвлөмжийг нь үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, хэрэгжүүлэх боломжтой тохиолдолд ЦБҮАЖ-д өөрчлөлт оруулах, алба нэгжүүдэд зөвлөмж хүргүүлэх байдлаар ажилладаг талаар дурдсан. Харин цаашид ийнхүү зөвлөмж хүлээн авсан, түүнийг хэрэгжүүлсэн эсэх талаараа судалгааны байгууллага болон олон нийтэд мэдээлж байх нь зүйтэй гэж үзлээ.

ХОЁР. СУДАЛГААНЫ ДҮН

2.1. Эрх зүйн орчин

2.1.1. Монгол Улсын Үндсэн хууль

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт “... халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” хэмээн заасан нь иргэний эрхэд аливаа хэлбэрээр, халдах, хохирол учруулахаас урьдчилан сэргийлсэн, хориглосон эрх зүйн гол зохицуулалт юм.

Үндсэн хуулийн энэхүү заалтын агуулга, зарчим нь үндсэндээ хууль сахиулах байгууллагын аливаа үйл ажиллагаа хүний эрх зөрчихгүй, хуулийн дагуу явагдах ёстой болохыг тогтоосон хэрэг билээ. Үүний зэрэгцээ бусад хууль Үндсэн хуулиас давсан эрх, хүчин чадалгүй гэдгийг энд дурдах нь зүйтэй.

2.1.2. Хууль тогтоомж болон эрх зүйн бусад зохицуулалт

Монгол Улсын Эрүүгийн хууль: Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлд “Хууль сахиулагчийг эсэргүүцэх” гэмт хэргийг зүйлчилсэн. Энэ нь цагдаагийн алба хаагчийн хууль зүйн баталгааны нэг хэлбэр бөгөөд энэ гэмт хэрэгт “хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн” тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан. Энэ нь Цагдаагийн албаны тухай хуулийн 23-32 дугаар зүйлд заасан тодорхой ажиллагааг цагдаагийн алба хаагчаас хэрэгжүүлэх үед иргэн эсэргүүцэл үзүүлсэн,

цагдаагийн алба хаагчид халдсан гэж үзвэл хариуцлага хүлээлгэх зохицуулалт, эрх зүйн баталгаа болж байна.

Харин Эрүүгийн хуулийн 13.8 дугаар зүйл. Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах гэмт хэргийн 13.8.3-т “Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж орон байранд, гадна талаас орон байрны доторх орчны гэрэл зураг авсан, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийсэн бол” хэмээн зүйлчилсэн нь цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ хүний эрх зөрчиж болзошгүй тохиолдлыг тусгасан. Мөн Эрүүгийн хуулийн 13.9 дүгээр зүйл. Хууль бусаар баривчлах, саатуулах гэмт хэрэгт “Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж хүний эрх чөлөөнд халдсан, баривчилсан, саатуулсан бол”, 21.12 дугаар зүйл. Эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт “Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол” хэмээн тус тус зүйлчилсэн нь цагдаагийн алба хаагч Цагдаагийн албаны тухай хуульд заасан эрх, үүргийн хүрээнд тодорхой ажиллагаа явуулахдаа хүний эрх зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэслэл болж байна.

Зөрчлийн тухай хууль: Тус хуулийн 15.2 дугаар зүйл. Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах зөрчилд “хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүй байхыг уриалсан, төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд нь саад учруулсан, төрийн албан хаагчийг хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцсэн, эсхүл доромжилсон” үйлдлийг тусгаж, үүнд хариуцлага хүлээлгэхээр заасан. Харин Зөрчлийн тухай хуулийн 6.22 дугаар зүйл. Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх зөрчил үйлдсэн бол эрх бүхий албан тушаалтан, цагдаагийн алба хаагчид хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэслэл болох юм.

Цагдаагийн албаны тухай хууль: Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 онд батлагдаж, тухайн ондоо хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд цагдаагийн алба хаагчийн тодорхой ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож өгсөн.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам (ЦБҮАЖ):

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам нь цагдаагийн алба хаагчийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн акт бөгөөд заавал дагаж мөрдөх шинжтэй баримт бичиг юм. Цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд дүрэм, журам, заавар баталж, мөрдүүлж ирсэн бөгөөд эдгээр дүрэм, журмыг системчилж, кодчилох ажлыг 2008 оноос эхлүүлж⁵ 2011 онд эмхэтгэн, цаашид тухай бүрд нь нэмэлт, өөрчлөлт оруулж ирсэн. 2021 оны байдлаар цагдаагийн алба хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа нийт 9 бүлэг 258 журам ашиглаж байна.

Тус судалгааны хүрээнд Цагдаагийн албаны тухай хуулийн дөрөвдүгээр бүлэгт заасан тодорхой ажиллагаа явуулахад баримталж буй үйл ажиллагааны журмуудад баримт бичгийн дүн шинжилгээ хийлээ.

2.1.3. Цагдаагийн албаны тухай хуулиар зохицуулсан тодорхой ажиллагааны талаарх цагдаагийн алба хаагчдын мэдлэг, хандлага

Цагдаагийн алба хаагч болон иргэдээс авсан асуулгын судалгааны эхэнд тодорхой ажиллагаатай холбоотой ерөнхий асуултад хариулт авах замаар энэ талаарх тэдний мэдлэг, хандлагыг тандсан болно.

График 1. Цагдаагийн албаны тухай хуульд заасан тодорхой ажиллагааг хэрэгжүүлэх 10 заалтыг ямар зорилгоор хэрэглэдэг вэ?



Уг асуултад тодорхой ажиллагааг шууд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий 879 алба хаагч буюу нийтийн хэв журам хамгаалах, замын хөдөлгөөний аюулгүй

⁵ Д.Эрдэнэбаатар, Ю.Бадамханд, Д.Булган. Цагдаагийн албаны үйл ажиллагааны журам хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх – 2020. Нээлттэй Нийгэм Форум, УБ., 2020. http://forum.mn/res_mat/2020/Tsagdaagiinalbaniiuilajillagaaniijuram.pdf


байдлыг хангах чиглэлээр ажилладаг алба хаагчдын хариултыг түүвэрлэн авав. Сонирхолтой нь, судалгаанд оролцсон алба хаагчдын 11 хувь нь Цагдаагийн албаны тухай хуульд заасан 10 төрлийн тодорхой ажиллагааг гэмт хэрэг илрүүлэх зорилгоор (119), эсхүл үндэслэл бүхий сэжигтэй тохиолдолд (25) хэрэглэдэг гэж хариулсан нь эдгээр арга хэмжээний үндсэн зорилгын талаар өөр өөр ойлголттой байгааг харуулж байна.

Иргэдийн хувьд тухайн арга хэмжээг “албадлагын арга хэмжээ” буюу хүний эрхэд халддаг ажиллагаа гэж 80 хувь нь үзжээ. Цагдаагийн албаны нэр хүнд илэрхий доошилж, олон нийттэй харилцах тал дээр байнга зөрчил гаргах болсон гэж судалгаанд хамрагдсан иргэдийн 72 хувь нь үзсэн байна. Энэ нь Ковид-19 цар тахлын үед хөл хорио тогтоосон, үйл ажиллагаанд нь хязгаарлалт ихээр тавьсантай холбоотойгоор иргэд, цагдаагийн алба хаагчдын хооронд үл ойлголцол, зөрчил удаа дараа үүссэнтэй холбоотой байж болох юм.

Цагдаагийн албаны тухай хуульд заасан 10 төрлийн тодорхой арга хэмжээг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэдэг бол гэмт хэрэг, зөрчил гаргасан тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан албадлагын бусад арга хэмжээ авахаар зохицуулсан.


Хуульд заасан 10 төрлийн тодорхой ажиллагаа нь өдөр тутмын хэвшмэл үйл ажиллагаа мөн эсэхийг цагдаагийн алба хаагчдаас лавлахад 786 нь мөн, 171 нь үгүй, 55 нь заримдаа, 33 нь хариулах шаардлагагүй гэжээ.

График 2. Хуульд заасан тодорхой ажиллагаа нь өдөр тутмын хэвшмэл үйл ажиллагаа мөн эсэх



Эндээс дүгнэхэд Цагдаагийн албаны тухай хуулийн 23-32 дугаар зүйлд заасан арга хэмжээг түгээмэл авдаг бөгөөд алба хаагчдын үйл ажиллагааны чиглэл буюу хариуцсан ажил, албан тушаалаас хамаарч хэрэглэх шалтгаан нь өөр өөр байна.

График 3. Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа төрөл бүрийн аян, нөлөөллийн арга хэмжээ нь дээрх тодорхой ажиллагааг хэрэгжүүлэхэд ямар нөлөө үзүүлдэг вэ?



Аян, нөлөөллийн аливаа арга хэмжээ нь алба хаагчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж, үндсэн ажилдаа анхаарах, хуулиар олгосон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь саад учруулдаг гэж үздэг алба хаагчид нийт судалгаанд оролцогчдын 42.5 хувийг эзэлж байна. Анхаарал татсан нэг асуудал бол цагдаагийн албанаас байнга, эсхүл тодорхой давтамжтай зохион байгуулдаг урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхдээ шаардлага тавих, түр саатуулах, тээврийн хэрэгслийг зогсоож шалгах, согтуурлын зэрэг тогтоох, бичиг баримт шалгах, үзлэг хийх тодорхой ажиллагааг түгээмэл ашигладаг ажээ. Тиймээс иргэд эдгээр аяныг эрхэд нь халддаг, тодорхой үндэслэлгүйгээр тодорхой ажиллагаа явуулдаг гэж дүгнэдэг байна.

Жишээ 1. Иргэн Д.

Дүрмээрээ ямар нэг зөрчил гаргаагүй явж байхад тээврийн хэрэгслийг зогсоож “дүрмээрээ” гэл үү нэг аяны нэр хэлээд шалгасан. Тэгээд шалгаж, шалгаж тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалтай холбоотой зөрчил олоод торгосон. Гол нь заавал зөрчил олох гэж хайгаад байгаад бухимдаж байна. Ингээд тухайн алба хаагчтай маргасны төлөө “Төрийн албан хаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй” гэсэн шалтгаанаар зөрчлийн хэрэг нээж ахин торгосон. Үүнд би маш их стресстэж, олон хоногийн ажил, цагаа алдсан. Иймэрхүү аян нэртэй арга хэмжээ нь үндсэндээ зөрчил хайсан, иргэдийг хардаж сэрдсэн хандлагаар явагддагт нь дургүй хүрдэг. Уг нь анхааруулаад “Энэ зөрчлөө арилгаарай!” гэдэг ч юм уу байдлаар явуулж болох л байсан.


Удирдах албан тушаалтнаас тухайн өдөрт шийдвэрлэх ёстой баримт бичиг, шалгах тээврийн хэрэгслийн тоо, торгуулийн хэмжээг тогтоож өгдөг эсэхийг лавлахад 639 алба хаагч хариулахаас татгалзсан, 171 нь тийм, 7 нь заримдаа, 15 нь сарын ажил дүгнэх үзүүлэлт болдог хэмээн хариулжээ. Харин 203 алба хаагч тухайн асуудалд хамааралгүй гэж хариулсан байна.

График 4. Удирдах албан тушаалтнаас тухайн өдөрт шийдвэрлэх ёстой баримт бичиг, шалгах тээврийн хэрэгслийн тоо, торгуулийн хэмжээг тогтоож өгдөг эсэх



Судалгааны явцад нэг сар орчмын хугацаанд *facebook*, *twitter*-г байршуулсан 8500 орчим пост, контентод анализ хийсэн. Энэхүү ажиглалтаас үзэхэд пост, шэйр, комментын 75 хувьд “Цагдаагийн алба хаагчид торгуулийн лимит тогтоож, түүгээр ажлыг нь дүгнэдгээс иргэдийг торгож шийтгэх ажиллагаанд орж байна” гэсэн үзэл бодол, дүгнэлт давамгайлж байна. Дээрх асуултад цагдаагийн алба хаагчдын 61.7 хувь нь хариулахаас татгалзсан бөгөөд харин уг асуултад хариулсан цагдаагийн алба хаагчид бүгд “тийм” гэж хариулжээ.

График 5. Тодорхой ажиллагааг хэрэгжүүлэх үед түгээмэл тохиолддог бэрхшээл болон иргэдийн хандлага



Цагдаагийн алба хаагчид “Цагдаагийн байгууллага, цагдаагийн алба хаагчийн нэр хүнд унаж байгаа нь алба хаагчийг хамгаалах тогтолцоо, эрх зүйн орчин дутмаг байдагтай холбоотой”⁶ гэж дүгнэсэн байна. Энэ чиглэлээр өмнө хийгдсэн судалгааны санал дүгнэлтээс⁷ харахад цагдаагийн алба хаагчийн ур чадвар, хандлага чухал нөлөөтэй болох нь илт байна. Нөгөө талаас тухайн арга хэмжээг авч буй эрх зүйн үндэслэлийг урьдчилан тайлбарласан тохиолдолд гаргах гомдол нь тайлбарлаагүй тохиолдолд гаргах гомдлоос даруй арав дахин бага байгаа нь үүнийг нотолж байна.⁸

Хүний эрхийн зөрчлийн үндсэн шалтгааныг иргэдтэй харилцах үйл явц буюу цагдаагийн алба хаагч, иргэн хоёрын анхны уулзалт, харилцаа, шийдвэр гаргалтаас шалтгаалж байна гэж үзсэн.⁹ Харин цагдаагийн алба хаагчид хууль, журам тодорхойгүй байгаа нь иргэд цагдаагийн алба хаагчдад таагүй хандахад шууд нөлөөлдөг гэж үзжээ. Сонирхолтой нь, иргэд яагаад цагдаагийн алба хаагчдад таагүй ханддаг талаар ямар нэг төсөөлөл, судалгаа байхгүй байна. Өмнө нь хэрэгжсэн “Цагдаа, олон

⁶ Судалгаанд хамрагдсан 1035 алба хаагчийн хариултад тухайн судалгааны асуултаас гадна өөрийн үзэл бодлыг бичсэн хариулт нийт 980 байсан бөгөөд үүний 893 буюу нийт судалгаанд оролцогчдын 86.2 хувь, нэмэлт хариулт бичсэн алба хаагчдын 91.1 хувь нь дээрх хариултыг өөрсдөө сайн дураараа бичиж ирүүлснийг энд онцолж байна.

⁷ Судлагдсан байдлын тоймоос үзнэ үү.

⁸ Судалгаанд хамрагдсан иргэдийн 21 нь эрх ашиг зөрчигдсөн гэж үзэн цагдаагийн байгууллагын дээд шатны удирдах албан тушаалтанд гомдол гаргаж, тайлбар хүсжээ.

⁹ Сүүлийн гурван жил (2018-2021 он)-ийн хугацаанд Цагдаагийн ерөнхий газрын 102 тусгай дугаарт ирсэн цагдаагийн алба хаагчидтай холбоотой гомдол, мэдээллийн судалгаа.

нийтийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийн үр дүн, сургамжид тулгуурлан цагдаагийн менежмент, олон нийтийн хамтын ажиллагааг хөгжүүлэх тал дээр нарийвчилсан судалгааны ажил хийх нь зүйтэй гэж үзлээ.

Цагдаагийн албаны тухай хуульд заасан тодорхой арга хэмжээг гэмт хэрэг, зөрчил илрүүлэх, таслан зогсооход ашигладаг хэмээн асуулгад оролцсон цагдаагийн нийт алба хаагчийн 90 хувь буюу 934 нь хариулжээ.


График 6. Цагдаагийн албаны тухай хуульд заасан тодорхой ажиллагааг гэмт хэрэг, зөрчил илрүүлэх, таслан зогсооход ашигладаг эсэх



Тодорхой ажиллагааг хэрэгжүүлэх нь гэмт хэрэг, зөрчил илрүүлэхэд өндөр ач холбогдолтой гэж тэд дүгнэсэн ч “Илрүүлэлтэд илүү анхаарч, урьдчилан сэргийлэх арга, ажиллагааг сайжруулах тал дээр анхаарахгүй, ач холбогдол өгөхгүй, төрөл бүрийн аян, арга хэмжээ нь бодит үр дүнгүй байна” гэсэн шүүмж мөн хэлсэн байна. Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээнээс үзвэл албан үүргээ гүйцэтгэж байх үедээ 10 тохиолдлын хоёрт гэмт хэрэг, зөрчил илрүүлсэн байх бөгөөд ингэхдээ дээрх тодорхой ажиллагааг хэрэгжүүлжээ. Тухайн тодорхой ажиллагаа урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ, таслан зогсоох чиг үүрэг гүйцэтгэдэг болохыг энэ баримт харуулж байна.

Аливаа нөлөөллийн аян, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд эерэг нөлөө үзүүлдэг гэж судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдын дийлэнх нь буюу 79 хувь нь үзжээ.

График 7. Аливаа нөлөөллийн аян, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ямар үр нөлөө үзүүлдэг болох



Судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдын дийлэнх нь “шаардлага тавих”, “тээврийн хэрэгсэл зогсоож шалгах” арга хэмжээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд өндөр ач холбогдолтой гэж үзсэн байна. Цагдаагийн алба хаагч ямар тохиолдолд бичиг баримт шалгах, түр саатуулах, тээврийн хэрэгслийг зогсоож шалгах зэрэг ажиллагааг хэрэгжүүлж байгаа болохыг тээврийн цагдаагийн албаны харьяалалд ажилладаг 133 алба хаагчаас лавлахад 70 алба хаагч доорх графикт заасан хариулт өгсөн болно.

График 8. Цагдаагийн алба хаагч ямар тохиолдолд бичиг баримт шалгах, түр саатуулах, тээврийн хэрэгслийг зогсоож шалгах арга хэмжээ авдаг болох



Дээрх дүгнэлт нь цагдаагийн 1035 алба хаагчаас авсан судалгааны хариулт тус бүрийг нэг бүрчлэн уншиж, харьцуулсан ерөнхий үнэлгээ бөгөөд дараагийн хэсэгт Цагдаагийн албаны тухай хуулийн 23-32 дугаар зүйлд заасан тодорхой ажиллагаа бүрээр авч үзнэ.

Цагдаагийн алба хаагчдын өөрсдийх нь үнэлгээ, иргэдээс авсан судалгааны дүгнэлт, тоон мэдээ, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, хуулийн хэрэглээ нь хүний эрх зөрчихөд нөлөөлж байгаа эсэхийг тодорхой ажиллагаа тус бүрээр тодорхойлохыг эрмэлзэв.

Хүснэгт 8. Журам болон хуулийн заалтын харьцуулалт

Д/д	Тодорхой ажиллагаа	Түүний агуулга	Хуулийн заалт	ЦБҮАЖ
1.	Шаардлага тавих	Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа нь хуульд зааснаар 4 төрлийн шаардлага тавих бөгөөд уг шаардлагыг тухайн хүн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй.	23.1 Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зөрчлийг арилгуулах, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх зорилгоор хүн, хуулийн этгээдэд тодорхой үйлдлээс татгалзах, эсхүл үйлдэл хийх шаардлага тавьж болно.	Тусгайлан гаргасан журам байхгүй. Код-921 буюу Албан үүрэг гүйцэтгэх үед алба хаагч хүнтэй харилцах, биеэ авч явах байдал гэсэн журамд заасан нийтлэг шаардлагыг даган мөрдөж байна.
2.	Тайлбар авах	Тухайн гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл өгч чадна гэсэн хангалттай үндэслэл байгаа тохиолдолд хэрэгждэг.	24.1 Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл өгч чадна гэсэн хангалттай үндэслэл байгаа тохиолдолд хүнээс тайлбар авна.	Код-218 буюу Иргэн, албан тушаалтнаас тайлбар авах, гаргуулах журам
3.	Хүний бичиг баримт шалгах	Хуульд заасан үндэслэл бүхий 10 тохиолдолд цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа нь хүний бичиг баримтыг шалгаж, шаардлагатай тохиолдолд уг зүйлд заасан тодорхой ажиллагааг үргэлжлүүлэн явуулна.	25.1 Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа дараах тохиолдолд хүний нэр, хаяг, тодорхой үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг тодруулах зорилгоор бичиг баримтыг шалгана.	Код-214 буюу Бичиг баримтыг үзэж шалгах журам

Хүснэгт 8-ын үргэлжлэл

4.	Түр саатуулах	Сэжиг бүхий үндэслэл байгаа тохиолдолд зөвхөн цагдаагийн алба хаагчийн хэрэгжүүлж болох тодорхой ажиллагаа.	26.1 Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа хүний нэр, хаягийг тодруулах, гэмт хэрэг, зөрчилд холбогдуулан шалгах, албадан саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоох зорилгоор хүнийг 6 цаг хүртэл хугацаагаар түр саатуулж болно.	Код-225 буюу Түр саатуулах журам
5.	Хуулийн этгээдийн баримт бичиг шалгах	Хуулийн этгээдийн бичиг баримтыг шалгах нь тухайн явуулж байгаа үйл ажиллагааны зөвшөөрөл, хууль тогтоомжоор хориглосон бусад асуудал байгаа эсэхийг тодруулах зорилготой байна.	27.1 Цагдаагийн алба хаагч дараах тохиолдолд хуулийн этгээдийн бүртгэл, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, холбогдох бусад баримт бичгийг шалгана.	Код-921 буюу Албан үүрэг гүйцэтгэх үед алба хаагч хүнтэй харилцах, биеэ авч явах байдал гэсэн журамд заасан нийтлэг шаардлагыг дагаж мөрдөх нь тодорхой байна.
6.	Орон байр, бусад газарт нэвтрэн орох	Цагдаагийн алба хаагч нь оршин суугч, эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр тухайн орон байр, бусад газарт нэвтрэн орох 4 тохиолдлыг ЦАТХ-д тусгасан.	28.1 Цагдаагийн алба хаагч хуулиар харьяалуулсан гэмт хэрэг, зөрчил, тэдгээрийн талаарх гомдол, мэдээллийг шалгахдаа бусдын орон байр, тээврийн хэрэгсэл, ажлын байр, агуулах сав, эзэмшил газарт нэвтрэн орох, ач холбогдол бүхий баримт, мэдээллийг гаргуулан авах эрхтэй.	Код-222 буюу Байгууллага, иргэний орон байранд нэвтрэн орох журам

Хүснэгт 8-ын үргэлжлэл

7.	Үзлэг хийх	Хүний биед зөвхөн прокурорын зөвшөөрлөөр үзлэг хийх бөгөөд гарцаагүй үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд хэрэгжүүлнэ.	29.1 Цагдаагийн алба хаагч энэ хуульд заасан үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд хүний бие, тээврийн хэрэгсэлд үзлэг хийнэ.	Код-215 буюу Хүний бие, тээврийн хэрэгсэл, ачаа тээшинд үзлэг хийх журам
8.	Эд зүйл, баримт бичиг түр хураан авах	Цагдаагийн алба хаагч нь шаардлагатай тохиолдолд шүүхийн зөвшөөрөлгүйгээр эд зүйл, баримт бичиг зэргийг хураан авахыг зөвшөөрсөн эрх зүйн зохицуулалт юм.	30.1 Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ үүрэн холбооны хэрэгсэл, бусад шаардлагатай эд зүйл, тээврийн хэрэгсэл, цахим төхөөрөмж, баримт бичгийг шүүхийн зөвшөөрөлгүйгээр түр хураан авч болно.	Код-217 буюу Эд зүйл, тээврийн хэрэгсэл, баримт бичиг түр хураан авах журам
9.	Тээрийн хэрэгслийг зогсоож шалгах	Цагдаагийн алба хаагч нь тээврийн хэрэгслийг зогсоож шалгах 11 төрлийн үндэслэлийг хуульчилж өгсөн бөгөөд тээврийн хэрэгслийг зогсоож шалгах явцад үндэслэл бүхий сэжиг илэрсэн тохиолдолд энэ хуулийн 25, 32, 33, 34 дүгээр зүйлд заасан ажиллагаа явуулна.	31.1 Цагдаагийн алба хаагч дараах тохиолдолд тээврийн хэрэгслийг зогсоож шалгана. (Энэ хуульд 11 заалтыг хуульчилж өгсөн).	Код-214 буюу Бичиг баримтыг үзэж шалгах журам Код-217 буюу Эд зүйл, тээврийн хэрэгсэл, баримт бичиг түр хураан авах журам Код-220 буюу Согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх, хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах журам
10.	Согтуурсан, мансуурсан байдлыг шалгах	Хуульд зааснаар цагдаагийн алба хаагч нь согтуурсан, мансуурсан байдлыг шалгах 3 төрлийн арга байх бөгөөд согтуурсан, мансуурсан жолоочид 4 төрлийн арга хэмжээ авна.	32.1 Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэх үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд хүнийг согтуурсан, мансуурсан эсэхийг дараах аргаар шалгана.	Код-220 буюу Согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх, хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах журам

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд дүн шинжилгээ хийх үндсэн шалтгаан нь:

- цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагааг журамлахдаа тухайн ажиллагааг явуулах процессыг нарийн заасан эсэх;
- алба хаагчийн эрх, үүргээ хэрэгжүүлэх эрх зүйн баталгаа болж чаддаг эсэхийг тодруулан судлах;
- тухайн журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цагдаагийн алба хаагч болон иргэдийн хооронд үүсэж болох зөрчил, түүний үр дагаврыг тодорхойлох зэрэг ач холбогдолтой бөгөөд энэ нь хууль зүйн судалгааны баримт бичигт дүн шинжилгээ хийх аргад хамаарна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд хийсэн дүн шинжилгээг тодорхой ажиллагаа тус бүрд шигтгэн дүгнэлт болгон оруулав.

Судалгааны хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсээс түүвэрлэн ирүүлсэн 22 төрлийн ЦБҮАЖ нь 2017 онд батлагдсан бөгөөд үүнээс 1 нь 2019 онд, 6 нь 2020 онд, мөн 1 нь 2021 онд тус тус шинэчлэгджээ.

2.2. Цагдаагийн албаны тухай хуулиар зохицуулсан тодорхой ажиллагаа тус бүрийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ

2.2.1. Шаардлага тавих

23 дугаар зүйл. Шаардлага тавих

23.1. Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зөрчлийг арилгуулах, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх зорилгоор хүн, хуулийн этгээдэд тодорхой үйлдлээс татгалзах, эсхүл үйлдэл хийх шаардлага тавьж болно.

23.2. Нийтийн хэв журмыг зөрчсөн, зөрчиж болзошгүй согтуурсан, мансуурсан хүнийг олон нийтийн газрыг тодорхой хугацаанд орхин явахыг шаардаж болно.

23.3. Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа гэмт хэрэг, зөрчлийн ул мөрийг бэхжүүлэх, бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, хуулийн этгээдийн хэвийн үйл ажиллагааг хангах, тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөнд учирсан саадыг арилгах зорилгоор хүнийг тодорхой байр, газрыг орхин явахгүй байх, эсхүл өөр газар шилжин байрлахыг шаардаж болно.

23.4. Цагдаагийн алба хаагч гэмт хэрэг, зөрчлийн тухай гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхэд шаардлагатай хуулиар хориглосноос бусад баримт, эд зүйлийг гаргаж өгөхийг шаардаж болно.

23.5. Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа нь хоёр болон түүнээс дээш тооны хүнд шаардлага тавих тохиолдолд хүн тус бүрд хэлэх үүрэг хүлээхгүй.

23.6. Цагдаагийн алба хаагчийн шаардлагыг тухайн хүн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй.

23.7. Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаагийн шаардлагыг биелүүлээгүй, эсэргүүцсэн, эсхүл хуулийн дагуу явуулж байгаа ажиллагаанд нь саад учруулсан бол албадан гүйцэтгэж, гэм буруутай этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Цагдаагийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйл буюу “Шаардлага тавих”¹⁰ нь цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаагийн өдөр тутам, хамгийн түгээмэл хэрэглэж буй тодорхой ажиллагаа юм. Цагдаагийн байгууллагаас энэ тодорхой ажиллагаатай холбоотой тоон мэдээллийг нарийвчлан гаргадаггүй бөгөөд нийтийн хэв журам хамгаалах болон тээврийн цагдаагийн албаны чиг үүрэг гүйцэтгэж буй нэг алба хаагчийн зүгээс өдөрт дунджаар 30-аас дээш удаа¹¹ хэрэглэдэг байж болох тооцоолол гарч байна.

Харин энэхүү шаардлага тавих явцад цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа болон иргэдийн хооронд хамгийн их зөрчил үүсдэг болохыг судалгаанд оролцогчдын хариулт харуулж байна. Тухайлбал, энэхүү судалгаанд оролцсон цагдаагийн 1035 алба хаагчийн 884 нь “Иргэд бидний үйл ажиллагаанд сөрөг хандлагатай байдаг” гэж хариулжээ.

Цагдаагийн алба хаагч тодорхой ажиллагаа хэрэгжүүлэхдээ үндэслэл, шалтгаанаа тодорхой тайлбарладаг эсэхийг лавлахад судалгаанд

¹⁰ Цагдаагийн албаны тухай хууль (Шинэчилсэн найруулга). “Төрийн мэдээлэл эмхэтгэл”. 2017, №06.

¹¹ Санал асуулгад оролцсон алба хаагчдаас илэрхийлсэн тоон утгыг дундчилж гаргав.

хамрагдсан 153 иргэний 95 буюу 62.09 хувь нь “Тийм, тодорхой хэмжээнд тайлбарлаж өгдөг” гэж хариулсан бол “Тайлбарладаггүй” гэж 38 иргэн буюу 24.8 хувь нь хариулжээ. Мөн “Тайлбарлаж хэлж өгдөггүй, дарамталдаг” гэж 1, “Сайн мэдэхгүй байна” гэж 9, “Янз бүр байдаг” гэж 1 иргэн тус тус хариулжээ.

Үүний зэрэгцээ нэг сар орчмын хугацаанд facebook, twitter-т байршуулсан 8500 орчим пост, контентод анализ хийхэд “Цагдаагийн байгууллагын алба хаагчид хандан гомдол гаргахад “Арга хэмжээ авсан”, “Хуульд заасны дагуу арга хэмжээ авсан” гэхээс өөр тодорхой хариу, мэдээлэл өгдөггүй” гэсэн агуулга бүхий пост, коммент 2800 орчим байх бөгөөд иргэд ямар хууль, журамд заасан зөрчил гаргасан болох, үүнд хүлээлгэх шийтгэлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах сонирхолтой байгаа нь ажиглагдсан.

Жишээ 2. Цагдаагийн алба хаагч Ц.

Иргэд “Шаардлага тавих”-ыг ямар нэгэн байдлаар буруутгаж, шийтгэл оногдуулах гэж байна, эсвэл өөрийгөө гэмт хэрэг, зөрчлийн холбогдогч болчихлоо гэж ойлгодог. Хууль, эрх зүйн мэдлэгийг нь дээшлүүлж, энэ талаар мэдээлэл өгөх, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулж, ЦАТХ-ийг сайтар сурталчлах шаардлагатай юм болов уу гэж боддог.

Мөн 102 тусгай дугаарт 2018 оны 4 дүгээр сараас 2021 оны 11 дүгээр сар хүртэлх хугацаанд цагдаагийн алба хаагч, түүний үйл ажиллагаатай холбоотой гомдлын шинжтэй 3442 дуудлага, мэдээлэл ирсэн байна.¹² Эдгээр дуудлагын 287 тохиолдол буюу 8.3 хувь нь цагдаагийн алба хаагч, техник хэрэгсэл хохирсонтой холбоотой бол 2450 буюу 71.2 хувийг цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой гомдол, мэдээлэл эзэлж байна.

¹² Сүүлийн гурван жил (2018-2021 он)-ийн хугацаанд Цагдаагийн ерөнхий газрын 102 тусгай дугаарт ирсэн цагдаагийн алба хаагчидтай холбоотой гомдол, мэдээллийн судалгаа.

График 9. ЦЕГ-ын 102 тусгай дугаарт ирсэн гомдол, мэдээллийн судалгаа



Нийт дуудлагын 234 нь цагдаагийн алба хаагч дуудлагаар очих үед үүссэн асуудалтай холбоотой бол үүний 11 тохиолдолд цагдаагийн алба хаагч өөрөө хохирчээ. Цагдаагийн алба хаагч, техник хэрэгсэл хохирсон нийт 287 тохиолдлын 141-ийг замын цагдаагийн алба хаагчийн биед халдсан, хэл амаар доромжилсон тохиолдол эзэлж байна. Харин замын цагдаагийн болон нийтийн хэв журам хамгаалах чиглэлийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг хүлээж авалгүй эсэргүүцэл үзүүлсэн тохиолдол 45 удаа бүртгэгджээ.

Эндээс дүгнэвэл цагдаагийн алба хаагч шаардлага тавих үед иргэд, цагдаагийн алба хаагчийн хооронд зөрчил үүсэх эрсдэл хамгийн өндөр байгаа бөгөөд “хараал хэлсэн”, “заналхийлсэн”, “сүрдүүлсэн”, “хууль бус шаардлага тавьсан”, “дарамталсан” гэсэн агуулга бүхий гомдол, мэдээлэл давамгайлжээ.¹³ Алба хаагчид иргэдтэй харилцаа тогтоох анхны үе шатанд ёс зүйн шинжтэй зөрчил нийтлэг гаргадаг бөгөөд энэ нь даамжирч хүний эрхийн зөрчил гарах суурь нөхцөл болдог гэж дүгнэхээр байна.

Аливаа нөлөөллийн аян, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний үеэр цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа идэвхэждэгтэй холбогдуулан тухайн үйл ажиллагааны тайлан, мэдээлэлд дүн шинжилгээ хийлээ. Учир нь нөлөөллийн аян, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний үеэр

¹³ Сүүлийн гурван жил (2018-2021 он)-ийн хугацаанд Цагдаагийн ерөнхий газрын 102 тусгай дугаарт ирсэн цагдаагийн алба хаагчидтай холбоотой гомдол, мэдээллийн судалгаа.

энэхүү шаардлага тавих арга хэмжээг түлхүү авдаг болох нь судалгаанд оролцсон алба хаагчдын хариулт, ярилцлагаас ажиглагдсан. Цагдаагийн ерөнхий газраас дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын үед авч хэрэгжүүлсэн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг буюу “Улбар шар” түвшинд иргэдээр халдвар хамгааллын дэглэм сахиулах, баяр, амралтын өдрүүдэд цагдаагийн байгууллагад хуулиар харьяалуулсан чиг үүргийн хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхийн тулд эргүүл, харуулыг эрчимжүүлэн ажиллажээ. Тухайлбал, “Эргүүл, хяналт шалгалт” хэсэгчилсэн арга хэмжээг 2021 оны 7 дугаар сард зохион байгуулсан байна. Хэсэгчилсэн арга хэмжээний үеэр архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд шалгалт хийж, хууль зөрчин үйл ажиллагаа явуулсан үйлдэлд хариуцлага тооцох, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хариуцсан нутаг дэвсгэрийн гудамж талбай, аж ахуйн нэгж, байгууллагуудын хяналтын камерын үйл ажиллагааг шалгаж, мэдэгдэл, шаардлага өгч, зөрчил арилгуулах үндсэн чиглэл баримтлан ажиллажээ. Энэ хүрээнд хэв журам сахиулах чиглэлээр давхардсан тоогоор эргүүлийн 5255 чиглэлд 10022, гудамж, замын хөдөлгөөн зохицуулалтын 1835 чиглэлд 3649 алба хаагч 1835 автомашинтай үүрэг гүйцэтгэж, 5 гэмт хэрэг, 3969 зөрчил илрүүлж, архидан согтуурсан үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн 2419 хүнийг эрүүлжүүлэх байранд, 1159 хүнийг ар гэрт нь хүлээлгэн өгч, зөрчил гаргасан 4093 хүнийг 117,272,000 төгрөгөөр торгосон гэх тайлан мэдээллээс үзэхэд урьдчилан сэргийлэх бус, зөрчил илрүүлэх зорилгоор энэ арга хэмжээг авч хэрэгжүүлжээ хэмээн дүгнэж болохоор байна.

Цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагааны үндсэн баримт бичиг болох Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам кодод энэхүү “Шаардлага тавих”-тай холбоотой журмыг код-921 буюу “Албан үүрэг гүйцэтгэх үед алба хаагч хүнтэй харилцах, биеэ авч явах байдал” гэсэн журамд заасан нийтлэг шаардлагад тусгаснаар зохицуулж байна. Шаардлага тавих талаар тусгайлан гаргасан үйл ажиллагааны журам байхгүй боловч уг код-921-д цагдаагийн алба хаагчийн хүнтэй харилцах, биеэ авч явах байдлыг дэлгэрэнгүй тусгаж өгчээ.¹⁴

¹⁴ Одоогийн байдлаар ЦЕГ-аас гаргасан “Police SOP” аппликейшнийг цагдаагийн алба хаагчдын гар тусанд суурилуулан ашиглаж байгаа ба түүнд бүх үйл ажиллагааны кодыг тусгаж өгсөн байна.

Уг журамд “иргэдэд шаардлагатай хууль, эрх зүйн мэдлэг, мэдээллийг тайлбарлахаас цааргалах”, “тухайн иргэний хувийн байдлыг шууд дүгнэх боломжгүй тул харилцаандаа залхсан, төвөгшөөсөн байдал үзүүлэх”-ийг хориглосон агуулга бүхий нэмэлт оруулах боломжтой болох нь харагдаж байна. Учир нь цагдаагийн алба хаагчдын зүгээс иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг дутмаг гэдэг шалтгаанаар хууль тайлбарлахаас цааргалах, эсвэл тухайн иргэний эрүүл мэндийн байдал сайнгүй байх гэх мэт тодорхой шалтгаан байгаа тохиолдолд эерэг харилцах агуулгыг ЦБҮАЖ-д тусгаж өгөх нь зүйтэй. Судалгаанд оролцсон 1035 алба хаагчийн 725 буюу 70 хувь нь “Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг дутмаг байгаагаас иргэд болон цагдаагийн алба хаагчдын хооронд үл ойлголцол үүсдэг” гэх нэмэлт тайлбар ирүүлснийг анхаарахгүй орхих аргагүй. Тиймээс ЦБҮАЖ-д иргэдтэй харилцахдаа анхаарах зарим зүйл, заалт нэмж оруулах шаардлагатай гэж судалгааны багийнхан үзсэн.

Цаашид “шаардлага тавих” тодорхой ажиллагааг тусгайлан зохицуулсан код шинээр боловсруулах шаардлагатай бөгөөд Цагдаагийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан дараах асуудлыг тусгах боломжтой. Үүнд:

1. Нийтийн хэв журам зөрчсөн, зөрчиж болзошгүй согтуурсан, мансуурсан хүнийг олон нийтийн газрыг тодорхой хугацаанд орхин явахыг шаардах;
2. Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа гэмт хэрэг, зөрчлийн ул мөрийг бэхжүүлэх, бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, хуулийн этгээдийн хэвийн үйл ажиллагааг хангах, тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөнд учирсан саадыг арилгах зорилгоор хүнийг тодорхой байр, газрыг орхин явахгүй байх, эсхүл өөр газар шилжин байрлахыг шаардах;
3. Цагдаагийн алба хаагч гэмт хэрэг, зөрчлийн тухай гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхэд шаардлагатай хуулиар хориглосноос бусад баримт, эд зүйлийг гаргаж өгөхийг шаардах.

Алба хаагчийн хувьд “Шаардлага тавих” тодорхой ажиллагаа нь алба хаагчийн харилцааны соёл, хууль, эрх зүйн мэдлэг чадвар, мэргэжлийн ур чадвараас шууд хамаарч байна. Мөн өмнө хийсэн судалгаануудад алба хаагчдыг мэргэшүүлэх, давтан сургалтад хамруулах шаардлагатай болохыг зөвлөсөн ч хэрэгжилтэд нь ахиц гараагүй, цар тахлын нөхцөлд энэ асуудал

орхигдсон, ор нэр төдий болсон, үр дүнд хүрээгүй гэж алба хаагчид өөрсдөө дүгнэжээ.

Харин цагдаагийн алба хаагчийн буруутай үйл ажиллагаатай холбоотой гомдол, мэдээллийн хувьд тодорхой аж ахуйн нэгж, албан газар, орон байранд дуудлагаар очих үедээ зүй бус харилцдаг, энгийн хувцастай, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ албаны үнэмлэхээ хэрэглэн бусдыг айлгадаг, төвөг уддаг гэсэн тохиолдлууд давамгайлж байна.¹⁵

Эндээс дүгнэхэд “Шаардлага тавих” тодорхой ажиллагааг хэрэгжүүлэх үед нэгдүгээрт, цагдаагийн алба хаагч болон иргэд хоорондын харилцаанаас хамааран үл ойлголцол үүсэж байна. Үүнийг цагдаагийн алба хаагчийн зүгээс иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг дутмаг байгаатай холбон тайлбарлах хандлага түгээмэл ажиглагдсан. Хоёрдугаарт, аливаа нөлөөллийн аян, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж байж л цагдаагийн байгууллагын ажилд ахиц, үр дүн гардаг гэх ойлголтыг нийтэд төрүүлсэн нь арга хэмжээ зохион байгуулаагүй үед цагдаагийн байгууллага ажлаа хангалтгүй хийдэг гэх ойлголт бий болгож байгааг анхаарах нь зүйтэй.

2.2.2. Тайлбар авах

24 дүгээр зүйл. Тайлбар авах

24.1. Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл өгч чадна гэсэн хангалттай үндэслэл байгаа тохиолдолд хүнээс тайлбар авна.

24.2. Цагдаагийн алба хаагч гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг шалгахдаа тайлбар авах зорилгоор хүн, хуулийн этгээдийн төлөөллийг цагдаагийн байгууллагад дуудаж болно.

Цагдаагийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйл болох “Тайлбар авах” арга хэмжээг цагдаагийн алба хаагч нь тухайн гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл өгч чадна гэсэн хангалттай үндэслэл байгаа тохиолдолд хэрэгжүүлдэг. Үүнийг “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код-218” буюу “Иргэн, албан

¹⁵ ЦЕГ-ын Хуулийн хэлтсээс ирүүлсэн хүснэгтэн мэдээллээс түүвэрлэн авав.

тушаалтнаас тайлбар авах, гаргуулах журам”-аар зохицуулдаг. Тайлбар авах тодорхой ажиллагаа нь цагдаагийн алба хаагчийн хууль буруу хэрэглэх, эсхүл эрхээ хэтрүүлэн хэрэглэх нэг шалтгаан, нөхцөл байж болох талтайг доорх иргэний өгүүлсэн жишээ харуулж байна¹⁶.

Жишээ 3. Иргэн А.

Намайг ямар ч шалтгаангүйгээр хоёр цаг саатуулсан бөгөөд түүнийгээ “Тайлбар авах хэрэгтэй байна” хэмээн тайлбарласан. Гэвч тухайн үед ямар ч эрүү, зөрчлийн хэрэг нээгээгүйгээр барахгүй, миний хувьд гэмт хэрэг, эсвэл зөрчлийн хэргийн хохирогч, холбогдогч эсэхээ мэдэхгүй байсаар байгаад цагдаагийн байгууллагаас явсан.

Цагдаагийн алба хаагч тухайн иргэнээс тайлбар авах явцдаа эрх, үүргийг нь танилцуулах, ямар зорилготой болох, үр дагаврын талаарх мэдээллийг ойлгомжтой, тодорхой тайлбарлаж өгөх нь чухал юм. Судалгаанд оролцсон 255 алба хаагч “Гэмт хэрэг, зөрчлийн газар дээр, эсвэл дуудлага, мэдээллийн үед зайлшгүй тайлбар авах шаардлага гардаг” гэж хариулсан. Уг судалгаанд оролцсон нийт алба хаагчдын 406 нь буюу 39.2 хувь нь “гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор” хуульд заасан тодорхой ажиллагаа явуулдаг гэсэн бөгөөд дээрх 255 алба хаагч нь тэдгээрийн 63 хувь болно.

Энэ нь “Тайлбар авах” ажиллагааг ихэвчлэн “Гэмт хэрэг, зөрчлийн газар дээр, эсвэл дуудлага, мэдээллийн үед” хийдэг болохыг харуулж байна. Үүнд холбогдох тоон судалгаа гаргах боломжгүй байсан бөгөөд цагдаагийн байгууллагад “тайлбар авах” гэсэн шалтгаанаар иргэдийг саатуулж, хүний халдашгүй эрхийг хязгаарладаг гэсэн хариултыг судалгаанд оролцсон иргэдийн 75 хувь нь өөрсдийн жишээн дээр тулгуурлан өгсөн.¹⁷ Судалгааны дүн өндөр гарсан нь нэг талаас судалгаанд хамрагдсан иргэдийн 75 орчим хувь нь Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан

¹⁶ Судалгааны явцад нэг сар орчмын хугацаанд facebook, twitter-т байршуулсан 8500 орчим пост, контентод анализ хийхдээ “Цагдаагийн байгууллагад тайлбар авна гэж дуудчихаад зүгээр явуулчихсан, ямар шалтгаанаар цагдаад дуудагдсанаа ойлгоогүй, цагдаа нар тайлбар авах нэрийдлээр өрөөндөө зүгээр суулгаж эрүүдэн шүүж байна” гэх мэт агуулга бүхий 630 пост, комменттой давхардуулан дүгнэв.

¹⁷ Судалгаанд санамсаргүй түүврийн аргаар иргэдийг сонгон авахдаа Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх дээр хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж буй иргэдээс хамруулсан болно.

шатны шүүхэд эрүүгийн болон зөрчлийн хэрэгт холбогдон шалгагдаж буйтай холбоотой байж болох юм.

Иргэдээс авсан асуулгад “Тодорхой бус байдлаар саатуулж, хязгаарлалт хийсний дараа гэмт хэрэг, зөрчилд буруутгахыг оролдсон, эсхүл шийтгэл оногдуулсан уу?” гэсэн асуулт байсан бөгөөд судалгаанд хамрагдсан 153 иргэний 21 буюу 13.7 хувь нь “Тийм, буруутгахыг оролдож байсан” гэж хариулжээ. Мөн 2 иргэн “Шийтгэл авч байсан”, 1 иргэн “Яллах байр суурьтай буруутгаж байсан” гэж тус тус хариулсан. Тайлбар авах нэрийн дор дуудан ирүүлээд зөрчлийн хэрэг, гэмт хэрэгт холбогдуулан мэдүүлэг авсан 11, түр саатуулсан 8, үзлэг хийсэн 2 тохиолдол тус тус байсан нь иргэдийн дээрх таамгийг бататгаж байна. Мөн тодорхой бус байдлаар буюу үндэслэл, шалтгаанаа ойлгомжтой тайлбарлалгүйгээр саатуулах арга хэмжээ авсны дараа “Тайлбар авахдаа буруутгахыг оролдсон” гэж 21 иргэн буюу 13.7 хувь нь хариулсан бол “Яллах байр суурьтай буруутгаж тайлбар авсан” гэж 1 иргэн хариулжээ.

Жишээ 4. Цагдаагийн алба хаагч Б.

Иргэдийн цагдаагийн байгууллагад хандах хандлага үндсэндээ сөрөг талдаа байгаа. Олон нийтийн сүлжээнд цагдаагийн албаны нэр хүндэд халдаж, буруутгах байр суурь их болсноос “хүний эрх зөрчигч” гэж шууд дүгнэдэг болсон. Хуульд зааснаар тайлбар авахад хүртэл эрхээ эдэлнэ гэсэн шалтгаанаар иргэд тайлбар бараг өгдөггүй. Өдөр тутмын үйл ажиллагаандаа иргэдийн зүгээс хууль биелүүлэхгүй гэсэн хандлагыг байнга мэдэрдэг. Иргэдтэй харилцахад өөр арга барил шаардагдаж байгаа нь илэрхий байсаар байтал удирдах албан тушаалтан, байгууллагаас дорвитой шинэчлэл хийж, иргэдтэй таатай харилцаанд шилжих талаар санаачилгатай ажиллаж, манлайлал үзүүлэхгүй байна.

Жишээ 5. Иргэн Ц.

Цагдаагийн алба хаагчид жагсаалд оролцсоны төлөө намайг ирж тайлбар өгөхийг шаардсан ба мэдүүлэг өгөх явцад намайг дарамталж, элдвээр хэлсэн. Ямар нэгэн хэрэгт холбогдуулан шалгаж байгаа юм шиг байсан боловч миний эрх, үүргийг ерөөсөө тайлбарлаагүй. Энэ бүхний дараа би эрхээ зөрчигдсөн гэж үзсэн боловч хаана хандахаа мэдээгүй.

Цагдаагийн алба хаагч тухайн тодорхой ажиллагааг хэрэгжүүлэхдээ иргэдэд тодорхой, ойлгомжтой байдлаар тайлбарлаж өгдөггүй тул иргэд хэрэгт сэрдэж “мэдүүлэг авах”-тай ижил хэмээн ойлгох тохиолдол цөөнгүй байгаа нь тэднээс авсан судалгаанаас харагдаж байна. Өөрөөр хэлбэл, “тайлбар авах” ажиллагааг иргэд эрүүгийн, эсхүл зөрчлийн хэрэг үүсгэж мэдүүлэг авч байна гэж ойлгодог ажээ. Судалгаанд хамрагдсан иргэдийн хариулт болон судалгааны явцад нэг сар орчмын хугацаанд *facebook, twitter*-т байршуулсан 8500 орчим пост, контентод анализ хийсэн дүгнэлтүүдэд “тайлбар авах” тодорхой ажиллагааг шаардлагагүй үед хэрэгжүүлж иргэдэд хүндрэл учруулан, хүний эрх зөрчдөг талаарх пост 3700 орчим удаа давтагдаж байгаагаас үүнийг харж болохоор байна. Мөн тайлбар авахдаа зүй бус харилцах, албадах, айлган сүрдүүлэх нь түгээмэл гэж иргэд хариулсан нь анхаарал татсан.

Харин ЦБҮАЖ код-218-д “тайлбар авах” гэдэг нэр томъёоны тайлбарыг “гэмт хэрэг, зөрчлийн талаар гаргасан гомдол, мэдээллийг шалгах явцад иргэн, албан тушаалтнаас хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар мэдүүлснийг бэхжүүлэн авсан ...” гэж тусгасан байх бөгөөд энэ нь Цагдаагийн албаны тухай хуульд “Тайлбар авах” тодорхой ажиллагааг “Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл өгч чадна гэсэн хангалттай үндэслэл байгаа тохиолдолд хүнээс тайлбар авна” хэмээн зүйлчилснээс агуулгын хувьд бага зэргийн зөрүү гарч байна. Тиймээс ЦБҮАЖ-даа энэхүү хуульд заасан агуулга бүхий тайлбарыг нэмж оруулах, эсхүл өөрчлөн найруулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, хуульд цагдаагийн алба хаагч шууд хэрэгжүүлж болох тодорхой ажиллагаа хэлбэрээр заасан байтал ЦБҮАЖ-д зөвхөн гомдол, мэдээллийг шалгах явцад хэрэгжүүлэх байдлаар тусгасан нь учир дутагдалтай.

2.2.3. Хүний бичиг баримт шалгах

25 дугаар зүйл. Хүний бичиг баримт шалгах

25.1. Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа дараах тохиолдолд хүний нэр, хаяг, тодорхой үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг тодруулах зорилгоор бичиг баримтыг шалгана:

25.1.1. гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн цаг хугацаанд тухайн газар, эсхүл түүний ойролцоо байсан, эсхүл гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл өгч чадна гэх үндэслэлтэй;

25.1.2. гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, завдсан, эсхүл гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр төлөвлөж байгаа гэх үндэслэлтэй;

25.1.3. гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн газар, хамгаалалтын бүсээс тээврийн хэрэгсэл, хүнийг гаргах, эсхүл нэвтрүүлэх;

25.1.4. эрх нь хязгаарлагдсан, эсхүл албадлагын арга хэмжээ авагдсан хүн хүлээсэн үүргээ зөрчсөн гэх үндэслэлтэй;

25.1.5. эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр албадан ирүүлэхээр даалгасан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, түүнчлэн гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа гэх үндэслэлтэй;

25.1.6. хууль тогтоомжид заасны дагуу хамгаалалтад байгаа объектод нэвтрэх хүнийг бүртгэх;

25.1.7. согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн, химийн хорт бодист хордсоны улмаас өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй болсон хүний нэр, хаягийг тогтоох;

25.1.8. гэмт хэрэг, зөрчлийн газарт үйлдэл дээрээ баригдсан этгээдийн нэр, хаягийг тогтоох;

25.1.9. хуульд заасан журмын дагуу тээврийн хэрэгслийг түр зогсоосон бол тээврийн хэрэгслийг жолоодож яваа хүний жолоодох эрхийн үнэмлэх, зөвшөөрлийг шалгах;

25.1.10. хуульд заасан насны хязгаарт хүрсэн эсэхийг тогтоох.

25.2. Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа хүний бичиг баримтыг шалгахдаа нүүр болон нийтэд ил харагдах биеийн бусад хэсгийг хаасан зүйлийг авах, халхлах аливаа үйлдэл хийхгүй байхыг шаардах, нэр, хаяг, зөвшөөрөл, бүртгэлийг шалгах, бичиг баримт нь гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашигласан, эсхүл үйлдэх замаар олж авсан, эрэн сурвалжлагдаж байгаа эсэхийг тодруулах зорилгоор бичиг баримт шалгах үндэслэлийн хүрээнд хэрэгжүүлбэл зохих ажиллагааг явуулна.

25.3. Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа хүний бичиг баримтыг шалгахдаа нэгээс хоёр алхмын зайтай зогсоож, ажиллагааг дуустал түүнийг гарын алгаа ил харагдахаар байрлуулж, тухайн газраас явахыг хориглох, эсхүл эрх бүхий байгууллагад очиж шалгуулах шаардлага тавьж болно.

25.4. Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа шаардсан бол тухайн хүн бичиг баримтаа шалгуулах, эцэг, эхийн болон өөрийн нэр, төрсөн огноог хэлэх үүрэгтэй.

25.5. Хүний бичиг баримтыг шалгасан цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа шаардлагатай бол дараах ажиллагааг явуулна:

25.5.1. амиа хорлохыг завдсан, өөртөө болон нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй сэтгэцийн эмгэгтэй, эсхүл сэтгэцийн эмнэлгээс оргосон хүнийг эмнэлгийн байгууллагад хүлээлгэн өгөх;

25.5.2. оргон зайлсан болон эрэн сурвалжлагдаж байгаа, эсхүл тухайн хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэх баримт, үндэслэл бүхий сэжиг байгаа бол баривчлах, цагдаагийн байгууллагад хүргэх;

25.5.3. хараа хяналтгүй, оршин суугаа газрын хаяг, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь тодорхойгүй, эсхүл согтуурсан, мансуурсны улмаас өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй болсон хүнтэй хамт яваа бага насны хүүхэд, эрх зүйн чадамжгүй хүнийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгөх;

25.5.4. согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсний улмаас өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй болсон хүнийг хамгаалах хүнд, эсхүл гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэх үндэслэлтэй бол холбогдох байгууллагад хүлээлгэн өгөх, эсхүл Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд заасан журмын дагуу арга хэмжээ авах;

25.5.5. зөрчил үйлдсэн хүний нэр, хаяг тодорхойгүй бол нэр, хаягийг тогтоох, зөрчлийг шалгаж шийдвэрлэх зорилгоор түр саатуулах;

25.5.6. эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр албадан ирүүлэхээр даалгасан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, түүнчлэн гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа гэх үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд баривчлах, эсхүл эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүлээлгэн өгөх;

25.5.7. гэмт хэрэг, зөрчил үйлдсэн бол зөрчлийг газар дээр нь шалгаж шийдвэрлэх, эсхүл хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллагад хүргэх;

25.5.8. зөрчлийг гарсан газарт нь шуурхай шийдвэрлэх боломжгүй, эсхүл хүний бичиг баримтыг шалгах болсон бусад үндэслэлийг тухайн газарт шалгаж тогтоох боломжгүй бол цагдаагийн байгууллагад хүргэх.

25.6. Цагдаагийн алба хаагч хүний бичиг баримтыг биечлэн шалгаж болно.

25.7. Цагдаагийн алба хаагч хүний бичиг баримтыг шалгах явцад дараах үндэслэл бүхий сэжиг илэрсэн тохиолдолд энэ хуулийн 24, 26, 29, 30 дугаар зүйлд заасан ажиллагааг явуулна:

25.7.1. гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, гэмт хэрэг үйлдэхээр завдсан, бэлтгэсэн гэх;

25.7.2. эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр албадан ирүүлэхээр даалгасан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, түүнчлэн гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа гэх;

25.7.3. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн гэх;

25.7.4. хүний амь нас, эрүүл мэндэд шууд хохирол учруулах эд зүйл, эсхүл хуулиар хязгаарласан, хориглосон, хууль бусаар олж авсан эд зүйлийг биедээ авч яваа, бусдад дамжуулсан, худалдсан гэх;

25.7.5. бичиг баримт, эд зүйл нь гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашигласан, эсхүл үйлдэх замаар олж авсан, эрэн сурвалжлагдаж байгаа гэх.

Цагдаагийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлд “Хүний бичиг баримт шалгах” тодорхой ажиллагааг хүний нэр, хаяг, тодорхой үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг тодруулах зорилгоор хэрэглэхээр зохицуулсан. Мөн Тээврийн цагдаагийн албаны алба хаагчдын хувьд энэхүү зохицуулалт нь өдөр тутам хэрэглэдэг үйл ажиллагааны үндсэн заавар болдог байна. Үүнийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код-214 буюу “Бичиг баримтыг үзэж шалгах журам”-аар зохицуулдаг.

Уг журмын зорилгод “Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчил үйлдэж байгаа болон үйлдсэн тухай үндэслэлтэй сэжиг байгаа тохиолдолд хүний нэр, хаягийг тодруулах” гэж заасан бөгөөд ЦАТХ-аар энэ эрхийг олон нийтийн цагдаад давхар олгосон боловч ЦБҮАЖ-аар зөвхөн цагдаагийн алба хаагчид олгожээ. Цаашид энэ тодорхой ажиллагааг олон нийтийн цагдаа хэрэгжүүлж болох эсэхэд дүн шинжилгээ хийж, улмаар хууль, эсвэл журамдаа өөрчлөлт оруулан нэг мөр болгох нь зүйтэй.

Энэхүү заалттай холбоотойгоор “Удирдах албан тушаалтнаас бичиг баримт, тээврийн хэрэгсэл шалгах, торгох тоо хэмжээ тогтоож өгдөг үү?” гэсэн асуултад 171 алба хаагч “Тийм” гэж хариулсан бол 15 алба хаагч “Үүнийг ажил дүгнэх үзүүлэлт болгодог тул хэмжээ тогтоож өгөөгүй ч аль болох олон тээврийн хэрэгсэл зогсоох, хүний бичиг баримт шалгах шаардлага гардаг” хэмээн дурджээ. Харин 7 алба хаагч “Заримдаа болон

сараар тоо тогтоодог” гэж хариулсныг нэгтгэвэл нийт 193 алба хаагч буюу судалгаанд оролцсон нийтийн хэв журам хамгаалах болон тээврийн хөдөлгөөн зохицуулах чиглэлээр ажилладаг 832 алба хаагчийн 23.1 хувь нь “Удирдлагаас бичиг баримт, тээврийн хэрэгсэл зэргийг шалгах, торгох тоо хэмжээ тогтоож өгдөг” гэж хариулжээ. Ярилцлагад хамрагдсан 15 алба хаагч үүнд хариулахаас татгалзсан ба ажил дүгнэх үзүүлэлтийн талаар ярих дургүй байгаа нь анхаарал татсан юм.

Харин нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр ажилладаг 699 алба хаагчийн 438 нь дээрх асуултад дараах нэмэлт тайлбар бүхий хариулт өгсөн. Үүнд:

- “эрэн сурвалжлагдаж байгаа этгээдтэй төстэй болон үндэслэл бүхий сэжигтэй тохиолдолд зөрчил гаргаагүй иргэний бичиг баримтыг шалгах үүрэгтэй” гэж 160 алба хаагч;
- “гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зөрчил гаргаагүй иргэний бичиг баримтыг шалгах шаардлагатай” гэж 159 алба хаагч;
- “нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний үеэр, эсхүл гэмт хэрэг, зөрчил илрүүлэх зорилгоор” гэж 119 алба хаагч тус тус хариулсан.

Тээврийн цагдаагийн 133 алба хаагчийн хувьд зөрчил гаргаагүй тээврийн хэрэгслийг зогсоож, бичиг баримт шалгаж буй зорилго нь “урьдчилан сэргийлж, мэдээлэл өгөх” гэж 32, “зарлан мэдээлсэн тээврийн хэрэгсэлтэй ижил төстэй болон илт сэжигтэй тохиолдолд” гэж 45 алба хаагч тус тус хариулжээ. Харин үлдсэн 56 алба хаагчийн хувьд “зөрчил илрүүлэх, таслан зогсоох” гэсэн хариулт өгсөн байна.

“Та дээрх шалтгаанаар зөрчигдсэн эрхээ хамгаалуулах, сэргээлгэхээр төрийн болон төрийн бус байгууллагад хандан гомдол, хүсэлт гаргаж байсан уу?” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан 153 иргэний 151 нь буюу 98.6 хувь нь “Үгүй” гэж хариулсан бол “Гомдол гаргасан” 1, “Зөрчлийн дараа аав маань өнгөрсөн учир эрхээ сэргээлгэхээр гомдол гаргаж чадаагүй” гэж 1 иргэн тус тус хариулжээ. Үйл ажиллагааны журам болон бусад зүйлийг шалгахдаа түр хураан авах болон ямар хугацаанд өөртөө байлгах талаар ямар нэг зохицуулалт байдаггүй байна. Үүнийг дурдсаны учир нь санал асуулгад оролцсон иргэдийн 35 хувь нь “Цагдаагийн алба хаагчид шалгуулсан бичиг баримтаа 1-3 удаа хураалгаж байсан бөгөөд

торгуулиа төлсний дараа, эсхүл биечлэн болон бусдаар дамжуулан гуйлгаж байж олж авдаг” гэж хариулжээ.

Жишээ 6. Иргэн А.

Олон нийтийн газар хогийн савны дэргэд утаат тамхи татаж байхад ирж зөрчил гаргасан гэж дарамталсан. Тухайн газар тамхи татахыг хориглосон бичиг байгаагүй ч зөвхөн тэнд хүлээж байгаад гэнэт гараад ирсэн юм шиг санагдсан. Гол нь тухайн үед торгоно гэж байснаа “Хэн юм ер нь чи? Бичиг баримтаа шалгуул” гэсэн. Тэгснээ бичиг баримт хурааж аваад “50 мянган төгрөгийн торгуулийн мөнгөө авч ирээд бичиг баримтаа аваарай” гэсэн. Гуйгаад ч нэмэр болоогүй “Тавьсан шаардлага эсэргүүцсэн гээд ахиад торгоно шүү” гэж айлгасан. Сүүлд нь таньдаг хүнээр нь гуйлгаж авсан.

Өөрөөр хэлбэл, бичиг баримт шалгахдаа биш түүнийг барьцаалах хэлбэрээр хураан авдаг нь хүний эрхийн зөрчил гэж үзсэн 12 иргэний хариулт бодитой, үндэслэлтэй байж болох юм. Ийнхүү хариулсан 12 иргэн 5-12 хоногийн хугацаанд бичиг баримтаа олж авсан байх бөгөөд бүх тохиолдолд бичиг баримтыг нь яагаад хураан авснаа тайлбарлаагүй байна.

Жишээ 7. Цагдаагийн алба хаагч З.

Зөрчил гаргасан иргэн болон цуг яваа иргэдийг шалгах шаардлагатай. Мөн сэжиг бүхий эд зүйл, ачаа тээш яваа тохиолдолд шалгадаг. Тодорхой дотоод итгэл үнэмшил төрсөн болоод л шалгах хэрэг гарна. Заримдаа энэ ажиллагаа нь дадал зуршил болсон байх нь ч элбэг. Иргэд бичиг баримтаа шалгуулах дургүй. Яагаад гэхээр алба хаагчид хурааж авчхаад өгдөггүй, чирэгдэл учруулдаг гэж үздэг гэж миний зүгээс дүгнэж байгаа.

Жишээ 8. Цагдаагийн алба хаагч С.

Зөрчил үйлдсэн этгээдүүд уурлаж уцаарладаг. Шалгах шаардлагатай талаар тайлбарлаж өгөхөөр гэмгүй иргэд зүгээр шалгуулдаг. Цаанаа учир шалтгаантай хүмүүс л бичиг баримтаа үзүүлдэггүй, бичиг баримтгүй явж байх нь элбэг.

Хүний бичиг баримт шалгах явцад иргэд болон цагдаагийн алба хаагчийн хооронд харилцааны асуудал ихэвчлэн үүсдэг бөгөөд бичиг баримтыг хураан авснаас хойш хэд хоногийн дотор, эсхүл хэдэн цагийн дотор

буцаан өгөхийг Цагдаагийн албаны тухай хууль болон ЦБҮАЖ-д тусгаж зохицуулаагүйгээс хүний эрх зөрчигдөх шалтгаан болж байна.

Санал асуулгад оролцсон иргэдийн 5 буюу 3.3 хувь нь “Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар болон ажлын үзүүлэлтээ нэмэхэд чиглэсэн хуучирсан арга барилтай удирдлагатай холбоотой” гэж, 3 буюу 2.0 хувь нь “Үзэмжээр ханддаг” гэж, 17 буюу 11.1 хувь нь “Мэдэхгүй байна” гэж, 5 буюу 3.3 хувь нь “Шалгах нь зөв” гэж, 23 буюу 15.0 хувь нь “Тэмдэглэлт баярын үед “Согтуу” арга хэмжээ гэж зарлаж байгаад замынхан өндөржүүлснээр гарч харагддаг, ер нь торгох, хэрэг хүлээлгэхээр гэж бодож байна” гэж, 20 буюу 13.1 хувь нь “Цагдаагийн байгууллагаас уралдаан зарласан үед илүү зогсоодог” гэж, 14 буюу 9.7 хувь нь “Өмнө нь ижил төрлийн машин хулгайд алдагдсан гэсэн шалтгаанаар зогсоож бичиг баримт шалгаж байсан” гэж тус тус хариулжээ.

Мөн цагдаагийн байгууллагаас зарласан төрөл бүрийн аян, арга хэмжээний үеэр тоон үзүүлэлтийг ахиулах зорилгоор энэхүү тодорхой ажиллагааг ашигладаг гэж судалгаанд оролцсон алба хаагчдын 42.5 хувь нь үздэг болохыг өмнө дурдсан. Эдгээрээс дүгнэхэд цагдаагийн байгууллагаас зарласан аян, арга хэмжээний үеэр зогсоож, бичиг баримт шалгах нь огцом нэмэгддэг болох нь харагдаж байна.

Мөн “Хүний бичиг баримт шалгах” энэхүү тодорхой ажиллагааг “Эд зүйл, баримт бичиг түр хураан авах” тодорхой ажиллагаатай андуурах, эсвэл зөвхөн “шалгах” ёстой байтал эрхээ хэтрүүлэн хэрэглэсний улмаас иргэд хохирох, үл ойлголцол үүсэх зэрэг асуудал тохиолддог байна. Тиймээс хууль, дүрэм журамдаа энэхүү хоёр төрлийн тодорхой ажиллагааг нэгтгэх, эсвэл ялгаа заагийг илүү нарийвчлан тодруулах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, ЦБҮАЖ код-214-ийн 6-д “үндэслэлгүйгээр бусдын бичиг баримтыг шалгах, хураан авах, барьцаанд байлгахыг хориглох” гэж заасан байтал судалгаанд хамрагдсан иргэд бичиг баримт шалгах гэж аваад хурааж авах тохиолдол гардаг тухай өмнө дурдсан.

2.2.4. Түр саатуулах

26 дугаар зүйл. Түр саатуулах

26.1. Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа хүний нэр, хаягийг тодруулах, гэмт хэрэг, зөрчилд холбогдуулан шалгах, албадан саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоох зорилгоор хүнийг 6 цаг хүртэл хугацаагаар түр саатуулж болно.

26.2. Энэ хуулийн 26.1-д заасан хугацааг түр саатуулах байранд хүргэснээс эхлэн тооцно.

26.3. Цагдаагийн алба хаагч хүнийг түр саатуулсан даруй тухайн хүний талаар 18 насанд хүрсэн гэр бүлийн гишүүн, өмгөөлөгч, ойр дотны хүнд нь мэдэгдэж, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.

26.4. Энэ хуулийн 26.3 дахь хэсэг нь цагдан хорих, баривчлах байр, эмнэлэг, хорих байгууллагаас оргон зайлсан ялтан, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид хамаарахгүй.

26.5. Хүнийг түр саатуулах үндэслэл арилсан тохиолдолд түүнийг даруй суллана.

26.6. Түр саатуулах байрны дэглэм, журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйл буюу түр саатуулах арга хэмжээ нь сэжиг бүхий үндэслэл байгаа тохиолдолд зөвхөн цагдаагийн алба хаагчийн авч хэрэгжүүлэх тодорхой ажиллагаа юм. Уг заалтыг хэрэгжүүлэхдээ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам 225 буюу “Түр саатуулах” журмыг баримтална. Энэ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан шүүхийн зөвшөөрөл шаардахгүй, 6 цаг хүртэл саатуулах ажиллагаа юм. Мөн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.1, 5.2 дугаар зүйлд заасан саатуулах арга хэмжээтэй ижил болохыг дурдах нь зүйтэй.

Түр саатуулах тодорхой ажиллагаа нь нэр хаяг тодруулах, эсхүл албадан саатуулах буюу баривчлах албадлагын арга хэмжээ авах үндэслэл байгаа

эсэхийг тогтоох зорилгоор хэрэгжүүлж, шаардлагатай тохиолдолд шүүгчийн захирамжаар баривчлах ажиллагаагаар үргэлжилдэг. Цагдаагийн алба хаагчдын зүгээс тус ажиллагаатай холбоотой анхаарал татахуйц хариулт ирүүлээгүй бөгөөд 50 алба хаагч “Зөрчил гаргасан этгээдүүд хүний эрх зөрчиж байна хэмээн унтууцаж эсэргүүцдэг” гэх хариулт өгсөн байна.

Жишээ 9. Цагдаагийн алба хаагч А.

Иргэдийн эрх зүйн мэдлэг хангалтгүй, мөн сошиалаар хуулийг илт улс төржүүлэн гуйвуулж байгаагаас болоод хуульд заасны дагуу саатуулах арга хэмжээ авсан тохиолдолд өөрийн гэм бурууг ухамсарлахгүйгээр шууд цагдаагийн алба хаагч руу дайрч давилах үзэгдэл байнга гарах болсон.

Түр саатуулах явцад гардаг хүний эрхийн зөрчил нь цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн ур чадвар сул байгаатай холбоотой бөгөөд ихэвчлэн иргэдэд үндэслэл, шалтгаанаа тодорхой, ойлгомжтой байдлаар тайлбарлаж өгөөгүйгээс шалтгаалж байна. Нөгөө талаас иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг дутмаг байгаа нь алба хаагч хуулиар хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэхэд саад болж байна гэж цагдаагийн алба хаагчид үзэж байгаа нь анхаарал татлаа. Учир нь иргэдэд шаардлагатай мэдлэг, мэдээлэл өгөх, ойлгуулах нь тухайн тодорхой ажиллагааг хэрэгжүүлж байгаа цагдаагийн алба хаагчийн хийх ёстой ажил, хүлээсэн үүрэг билээ.

Санал асуулгад оролцсон иргэдийн 81,6 хувь нь хүний эрхийн зөрчил хамгийн их дагуулдаг арга хэмжээ бол “түр саатуулах” гэж үзсэн. Тэдний 14 буюу 11.2 хувь нь удаан хугацаагаар цагдаагийн хэлтэст саатуулагдаж байсан ч ямар нэг тогтоол, шийдвэр харуулаагүй, танилцуулаагүй байна. Тодорхой баримт бичиг, хууль зүйн үндэслэл танилцуулалгүй түр саатуулсан тохиолдлыг иргэд эрх зөрчигдсэн гэж дүгнэжээ.

“Түр саатуулах” тодорхой ажиллагааны талаар facebook, twitter-т байршуулсан 8500 орчим пост, контентод анализ хийхэд журмаар зөвшөөрсөн 6 цагаас хэтрүүлдэг (560 хариулт), тухайн хугацаанд тодруулбал зохих ажиллагаа хийдэггүй (900 хариулт), үндэслэл, шалтгаанаа тодорхой тайлбарладаггүй (4650 хариулт) зэргээр шүүмжлэн бичжээ. “Түр саатуулах” тодорхой ажиллагааны үеэр үүсдэг зөрчил, үл ойлголцлын талаар иргэдээс ирүүлсэн хариулт, facebook, twitter-т

байршуулсан пост, контентуудад хийсэн анализыг нэгтгэн дүгнэвэл цагдаагийн алба хаагч тухайн тодорхой ажиллагааг явуулахдаа хууль, журам зөрчиж байгааг баталж байна.

2.2.5. Хуулийн этгээдийн баримт бичиг шалгах

27 дугаар зүйл. Хуулийн этгээдийн баримт бичиг шалгах

27.1. Цагдаагийн алба хаагч дараах тохиолдолд хуулийн этгээдийн бүртгэл, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, холбогдох бусад баримт бичгийг шалгана:

27.1.1. хууль тогтоомж зөрчсөн үйл ажиллагаа явуулж байгаа гэх үндэслэл байгаа;

27.1.2. хууль тогтоомж зөрчсөн үйл ажиллагаа явуулж байгаа талаар гомдол, мэдээлэл хүлээн авсан.

27.2. Баримт бичиг нь хууль ёсны эсэхийг шалгах шаардлагатай бол баримт бичгийн хуулбарыг авах, хуулбарлах боломжгүй бол эх хувийг 72 цаг хүртэлх хугацаанд түр хураан авч болно.

27.3. Цагдаагийн алба хаагч хуулийн этгээдийн баримт бичгийг биечлэн шалгаж болно.

27.4. Цагдаагийн алба хаагч хуулийн этгээдийн баримт бичиг шалгах явцад дараах нөхцөл байдал илэрсэн тохиолдолд энэ хуульд заасан ажиллагааг явуулна:

27.4.1. эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр албадан ирүүлэхээр даалгасан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, түүнчлэн гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа хүн тухайн хуулийн этгээдийн байр, агуулах сав, эзэмшил газарт байгаа гэх;

27.4.2. хүний амь нас, эрүүл мэндэд шууд хохирол учруулах эд зүйл, эсхүл хуулиар хязгаарласан, хориглосон эд зүйлийг хууль бусаар хадгалсан, үйлдвэрлэсэн, худалдсан гэх;

27.4.3. хууль тогтоомж зөрчсөн үйл ажиллагаа явуулж байгаа гэх.

Цагдаагийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйл буюу хуулийн этгээдийн баримт бичиг шалгах арга хэмжээ нь тухайн явуулж байгаа үйл ажиллагаа зөвшөөрөлтэй эсэх, хууль тогтоомжоор хориглосон бусад асуудал байгаа эсэхийг тодруулах зорилготой. Цагдаагийн алба хаагч нь хуульд заасан

энэхүү эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ код-921 буюу “Албан үүрэг гүйцэтгэх үед алба хаагч хүнтэй харилцах, биеэ авч явах байдал” гэсэн журамд заасан нийтлэг шаардлагад тусгаснаар зохицуулж байна. Цагдаагийн байгууллагаас “Эмзэг цэг-Хяналт шалгалт”-ын арга хэмжээ тогтмол зохион байгуулдаг бөгөөд энэ нь цаг хэтрүүлэн ажилласан болон тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан байгууллага, аж ахуйн нэгжийг илрүүлэх зорилготой.

Судалгаанд оролцсон 284 алба хаагч “Зарим төрлийн нөлөөллийн аян, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний үед гадагш буюу иргэд рүү чиглэсэн хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлдэг, энэ нь сайн нөлөөтэй” гэж үзжээ. Аливаа нөлөөллийн аян, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний үеэр хуулийн этгээдэд чиглэсэн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт, баримт бичиг шалгах ажиллагаа, үүнд тулгуурласан зөрчлийн хэрэг, хэрэг бүртгэлтийн ажиллагаа 25 хувиар нэмэгддэг гэсэн тооцоолол судалгааны явцад гарсан. Гэвч цагдаагийн байгууллагын үр нөлөө сайтай гэж үзсэн энэ арга хэмжээ хуулийн этгээдийн хувьд “толгойн өвчин” болж хувирсан байна.

Цагдаагийн ерөнхий газар Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.2.2, 7.3.1, 7.4 дэх заалтын хэрэгжилтийг хангах, хүүхэд залуучууд, олон нийтийн дунд нөлөөллийн ажил өрнүүлэх зорилгоор “Хуулиа мөрдье-21” арга хэмжээг 2018, 2019 онд зохион байгуулжээ. Уг арга хэмжээг аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, хүүхэд залуучуудад архины хор хөнөөлийг сурталчлан таниулах, урьдчилан сэргийлэх хэлбэрээр зохион байгуулснаар 2018 онд хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр давхардсан тоогоор нийт 952 алба хаагч ажиллаж, 5546 аж ахуйн нэгж, 4105 иргэнийг шалгаж, үүнээс согтууруулах ундаа худалддаг 1106, түүгээр үйлчилдэг 2647, дэн болон зочид буудал 842, цахим тоглоомын газар 394, саун, массажны газар 104-ийг шалган 179 зөрчил илрүүлж, 7 шил архи, 471 хайрцаг утаат тамхи хураан авч, 21 нас хүрээгүй хүнд үйлчилсэн 15 аж ахуйн нэгж, 3 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 6.5-ын 13 дахь хэсэгт заасны дагуу 3,600,000 төгрөгөөр, мөн хуулийн 6.5-ын бусад заалтаар 24 иргэн, аж ахуйн нэгжийг 3,180,000 төгрөгөөр, бусад хуулийн заалтаар 6 иргэн, аж ахуй нэгжийг 660,000 төгрөгөөр тус тус торгожээ. 2019 онд архи, согтууруулах төрлийн ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг нийт

6468 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах 732 мэдэгдэл, шаардлага хүргүүлж, 13,220,000 төгрөгийн мөнгөн торгууль оногдуулжээ.

Саун, массажны газрын үйл ажиллагаа, эрх зүйн орчин, цаашид анхаарах асуудлын талаар холбогдох байгууллагуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулах, хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх, илэрсэн зөрчилд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах, иргэд, олон нийтийг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилгоор “Саун, массаж” нэгдсэн арга хэмжээг 2018 онд зохион байгуулсан байна. Уг арга хэмжээний хүрээнд зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулж байсан 55 саун, массажны газар илрүүлжээ.

Жишээ 10. Цагдаагийн алба хаагч М.

Гэнэтийн байдлаар, эсхүл гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн газарт тухайн аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн бичиг баримтыг шалгах шаардлага гардаг. Ихэвчлэн хуулбар хувиа байлгадаг нь эх хувийг нь хурааж авдгаас болдог байх. Уг нь бичиг баримтыг хураан авах ёсгүй. Хуулийн этгээдийн бичиг баримтыг цахимаар шалгах, бүртгэлийн сангаас үзэх зэрэг олон арга бий. Гэтэл заавал бичиг баримтаа өлгөхийг шаардаж байгаа нь хоцрогдсон арга гэж үздэг.

Хуулийн этгээдийн баримт бичгийг шалгах явцад тухайн байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдийн эрх зөрчигдөж байгаад цагдаагийн байгууллага анхаарал хандуулдаггүй байна. Тухайлбал, цаг хэтрүүлэн ажилласан, эсвэл зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдийн зураг, бичлэгийг олон нийтийн сүлжээнд тавьж байгаа нь хүний эрхийн зөрчил юм. Хэрэв гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гэж үзвэл зөвхөн тухайн хуулийн этгээдэд хариуцлага тооцох ёстой байтал үйлчилгээ авч буй иргэдийн хувийн халдашгүй байдалд бүдүүлгээр халдаж байгаа нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг таагүй харагдуулдаг гэж асуулгад оролцсон иргэд үзжээ.

2.2.6. Орон байр, бусад газарт нэвтрэн орох

28 дугаар зүйл. Орон байр, бусад газарт нэвтрэн орох

28.1. Цагдаагийн алба хаагч хуулиар харьяалуулсан гэмт хэрэг, зөрчил, тэдгээрийн талаарх гомдол, мэдээллийг шалгахдаа бусдын орон байр, тээврийн хэрэгсэл, ажлын байр, агуулах сав, эзэмшил газарт нэвтрэн орох, ач холбогдол бүхий баримт, мэдээллийг гаргуулан авах эрхтэй.

28.2. Цагдаагийн алба хаагч доор дурдсанаас бусад тохиолдолд бусдын орон байранд оршин суугч, эзэмшигчийнх нь зөвшөөрөлгүйгээр нэвтрэн орохыг хориглоно:

28.2.1. гэмт хэргийг таслан зогсоох, гэмт хэрэг үйлдсэн хүнийг мөрдөн хөөж баривчлах, эсхүл гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдал үүссэн гэх үндэслэл бүхий сэжиг байгаа;

28.2.2. хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах бодит аюул байгаа;

28.2.3. эрэн сурвалжлагдаж байгаа хүн, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, хоригдлыг мөрдөн хөөж баривчлах;

28.2.4. сэжиг бүхий этгээд оргон зайлах, гэмт хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, үрэгдэх бодит аюул тулгарсан.

28.3. Энэ хуулийн 28.2-т зааснаас бусад тохиолдолд цагдаагийн алба хаагч бусдын орон байранд нэвтрэн орохдоо оршин суугч, эзэмшигчийн зөвшөөрлийг заавал авсан байна.

28.4. Тухайн орон байранд хамтран оршин суугч, эсхүл хамтран эзэмшигч этгээдийн аль нэг нь зөвшөөрөл өгсөн бол энэ хуульд заасан бусдын орон байранд нэвтрэх үндэслэл болно.

28.5. Орон байранд нэвтрэх зөвшөөрөл өгсөн этгээдийг оршин суугч, эзэмшигч биш гэж мэдэх боломжгүй байсан бол энэ хуулийн 28.2-т заасныг зөрчсөн гэх үндэслэл болохгүй.

28.6. Цагдаагийн алба хаагчийн өөрийн санаатай үйлдлийн улмаас энэ хуулийн 28.2.4-г заасан нөхцөл үүсгэсэн нь бусдын орон байранд оршин суугч, эзэмшигчийнх нь зөвшөөрөлгүй нэвтрэх үндэслэл болохгүй.

28.7. Цагдаагийн алба хаагч орон байр, бусад газарт нэвтрэн ороходоо хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд аюулгүй арга, хэрэгсэл ашиглаж, хүний нэр төрд хүндэтгэлтэй хандана.

28.8. Нэвтрэн ороход оршин суугч, эзэмшигч саад учруулбал эсэргүүцлээ зогсоохыг шаардах, шаардлагыг үл биелүүлбэл албадлагын арга хэмжээ хэрэглэхийг анхааруулна.

28.9. Цагдаагийн алба хаагч орон байр, бусад газарт нэвтрэн ороходоо энэ хуулийн 22.2, 22.6-д заасныг баримтлах үүрэгтэй бөгөөд энэ хуулийн 28.2-т заасан тохиолдолд орон байр, бусад газарт нэвтрэн орох бол энэ хуулийн 22.2, 22.6, 28.8-д заасныг баримтлахгүй байж болно.

28.10. Нэвтрэн ороход эд зүйл, цоож, түгжээ, байгууламжийн хэсгийг эвдэх, дохиолол, хяналтын систем, цахилгааныг салгах, нохой, бусад амьтныг номхотгох техник, хэрэгсэл ашиглах зэргээр учрах саадыг арилгаж болно.

28.11. Оршин суугч, эзэмшигчийн эзгүйд орон байр, бусад газарт нэвтрэн орсон бол тэдгээрт даруй мэдэгдэх, боломжгүй бол 24 цагийн дотор мэдэгдэх арга хэмжээ авна.

28.12. Энэ хуулийн 28.11-д заасны дагуу оршин суугч, эзэмшигчид мэдэгдэх боломжгүй бол түүний оршин суугаа газрын баг, хорооны Засаг даргад мэдэгдэнэ.

28.13. Энэ хуулийн 28.10-т заасан арга хэмжээ авсан, эсхүл эзэмшигчийнх нь эзгүйд нэвтрэн орсон бол эвдэрсэн эд хөрөнгийн хэвийн байдлыг сэргээх, түр хугацаагаар хамгаалах арга хэмжээ авна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйл буюу орон байр, бусад газарт нэвтрэн орох арга хэмжээний хүрээнд цагдаагийн алба хаагч оршин суугч, эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр тухайн орон байр, бусад газарт нэвтрэн орох дөрвөн тохиолдлыг зохицуулсан. Үүнийг код-222 буюу “Байгууллага, иргэний орон байранд нэвтрэн орох журам”-аар зохицуулж байгаа бөгөөд орон байр, байгууллага, бусдын эзэмшил газарт прокурорын зөвшөөрөлгүй нэвтрэн орох тохиолдлыг ойлгомжгүй байдлаар зохицуулсан нь хуульд нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл, журмын 222.2-т уг журмын хамрах хүрээг:

222.2.1. Иргэний орон байр нь халдашгүй байх бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар гагцхүү хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, түүнийг үйлдсэн этгээдийг мөрдөн хөөх, баривчлах үед энэхүү эрхэд халдах үндэслэлийг тодорхойлон өгсөн байна:

а/ нэгжлэг хийх тухай прокурорын зөвшөөрөлтэйгөөр;

б/ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хойшлуулшгүй тохиолдолд.

222.2.2. Нэгжлэг хийх тухай прокурорын зөвшөөрөлгүйгээр орон байр, байгууллага, бусдын эзэмшил газар нэвтрэн орох хойшлуулшгүй дараах тохиолдлууд байдаг:

а/ гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээр бэлтгэж, завдаж болон үйлдэж байгаа тухай үндэслэл бүхий гомдол, мэдээлэл ирсэн, тухайлбал, бусдын амь насыг хохироох, биед гэмтэл учруулж болзошгүй шууд аюул учирсан;

б/ оргон зугтсан гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээд тухайн орон байр, эзэмшил газар байж болзошгүй мэдээ, мэдээлэл байгаа, түүнчлэн гэмт хэрэгтэн, зөрчлийн нотлох баримтыг устгах эрсдэл бий болсон үед.

222.2.3. Цагдаагийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу орон байр, бусад газарт нэвтрэн орно.

Дээрх заалтуудаас харахад прокурорын зөвшөөрөлгүйгээр нэвтрэх эрх олгосон гэж үзэх боломжгүй байна. Харин ч журмын 222.4.1-д “Гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг мөрдөн хөөх, отолт хийж баривчлах үед байгууллага, иргэний орон байр, эзэмшил газарт цагдаагийн алба хаагч нэвтрэн орох асуудлыг прокурорын зөвшөөрлөөр шийдвэрлэнэ” гэж заасан нь дээрх агуулгыг бүхэлд нь үгүйсгэж байгаа юм. Үндсэндээ уг журмыг хойшлуулшгүй тохиолдолд хэрэгжүүлэхээр эрх олгосон боловч журмын 222.4.6-д “Цагдаагийн алба хаагч нь байгууллага, иргэний орон байр, эзэмшил газарт нэвтрэн орох шаардлагын талаар боломжтой тохиолдолд өмчлөгч, эзэмшигчид тайлбарлан өгч, уг ажиллагааг явуулах боломжийг хангах нөхцөл бүрдүүлэх хүсэлт тавина” гэж зааснаас үзвэл тухайн ажиллагаа үр дүнгүй

болох, гэмт хэрэгтэн оргон зайлах, эд мөрийн баримтыг устгах зэрэг эрсдэл шууд үүсэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, хууль болон журмын агуулгаараа зөвхөн прокурорын зөвшөөрлөөр бусдын орон байранд нэвтрэн орохоор зохицуулсан байх бөгөөд тодорхой ажиллагааг түргэн шуурхай явуулах нөхцөл бүрдээгүй гэж хэлж болно.

Судалгаанд хамрагдсан эргүүлийн цагдаа, офицер, ахлагч нар дараах асуудлуудыг онцолсон. Үүнд:

- Орон байранд ердийн явцад нэвтрэн орох тийм хэцүү биш харин дуудлага, мэдээллийг шалгах явцад (гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэх мэт) аль хуульд зааснаар орон байранд нэвтрэн орох нь тодорхойгүй;
- Орон байранд нэвтрэн оруулаагүй тохиолдолд цаашид хэрхэх нь тодорхойгүй (эвдлэх, саадыг арилгах гэх мэт);
- Ихэнх тохиолдолд оруулаагүй шалтгаанаар буцдаг, эсхүл гаднаас харилцдаг;
- Энэ ажиллагааг зохицуулсан журмыг илүү сайжруулах шаардлагатай, зөрчил, гэмт хэрэг шалгах ажиллагаанаас ялгах хэрэгтэй.

Жишээ 11. Цагдаагийн алба хаагч Д.

Цар тахлын бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед орон байранд нэвтрэн орох боломжгүй нөхцөл үүссэн. Ердийн нөхцөлд ч ийм асуудал тулгардаг. Өөрөөр хэлбэл, тухайн айл, тухайн орчинд байгаа хүнтэй харилцаа үүсгэж асуух шаардлага гардаг. Үүнээс зарим хүн төвөгшөөж, халдвар хамгааллын дэглэм шаарддаг.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 26 буюу 20 хувь нь цагдаагийн байгууллага орон байранд нэвтрэх үедээ эрх бүхий бусад албан тушаалтан, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтардаг нь хүний хувийн нууцад халдах, нийтэд зөвшөөрөлгүй цацах үндсэн нөхцөл болдог гэж хариулсан нь сонирхол татсан. Тухайлбал, алба хаагч баар, саун, зочид буудалд шалгалт хийх үедээ хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж, иргэний дүрс, дууны бичлэгийг олон нийтэд цацдаг нь хувь хүний нууц, нэр төр, эрхэмсэг оршихуйд халдсан үйлдэл хэмээн дүгнэж байгааг цаашид үйл ажиллагаандаа анхаарах шаардлагатай.

2.2.7. Үзлэг хийх

29 дүгээр зүйл. Үзлэг хийх

29.1. Цагдаагийн алба хаагч энэ хуульд заасан үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд хүний бие, тээврийн хэрэгсэлд үзлэг хийнэ.

29.2. Үзлэгийг гадна талаас нь харах, гараар тэмтрэх, тусгай багаж ашиглах, эсхүл далд байгаа зүйлийг ил гарган шалгах замаар энэ хуульд заасан үндэслэлийн хүрээнд хийж гүйцэтгэнэ.

29.3. Үзлэг хийхэд саад болж байгаа эд зүйл, тээврийн хэрэгслийг шилжүүлэн байрлуулж болно.

29.4. Эд зүйл, баримт бичиг, ачаа тээш, мал, амьтан, тээврийн хэрэгсэлд үзлэг хийхэд эзэмшигчийг оролцуулна. Эзэмшигчийг оролцуулах боломжгүй бол хөндлөнгийн гэрчийг байлцуулж, эсхүл дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлнэ.

29.5. Үзлэгийг эзэмшигчийн эзгүйд хийсэн тохиолдолд даруй эзэмшигчид, боломжгүй бол баг, хорооны Засаг даргад мэдэгдэнэ.

29.6. Үзлэг хийх үед хуульд заасан үндэслэл илэрсэн тохиолдолд хэв загвар, дээж авах, битүүмжлэх, хураан авах ажиллагаа явуулна.

29.7. Тээврийн хэрэгсэлд үзлэг хийхэд шаардлагатай бол эд ангийг салгаж болно.

29.8. Хүний биед үзлэг хийхэд өмссөн хувцас, биедээ авч яваа эд зүйлийг хамтад нь үзнэ.

29.9. Хүний биед үзлэг хийх үед уг этгээдийг нүцгэлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд үзлэгийг ижил хүйсийн эрх бүхий албан тушаалтан хийнэ. Шаардлагатай бол хүний эмч, сувилагчийг оролцуулж болно.

29.10. Нүцгэлж үзлэг хийх ажиллагааг эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан, бусдаас тусгаарлагдсан орчинд явуулна.

29.11. Нүцгэлж үзлэг хийх ажиллагааны үед энэ хуулийн 29.9-д зааснаас бусад хүнийг байлцуулахыг хориглоно.

29.12. Цагдаагийн байгууллага, алба хаагч нийтийг хамарсан арга хэмжээ, онц чухал объектын хамгаалалтын үүрэг гүйцэтгэх үед тухайн объект, арга хэмжээ болж байгаа газарт нэвтрүүлэхийг хориглосон эд зүйл байгаа эсэхийг тогтоох зорилгоор тухайн газарт нэвтрэх хүний бие, биедээ авч яваа эд зүйлд биечлэн болон тусгай техник, хэрэгсэл ашиглан үзлэг хийж болно.

29.13. Үзлэгийн зорилгод харшлахааргүй бол цагдаагийн алба хаагч үзлэгт хамрагдаж байгаа эд зүйл, тээврийн хэрэгслийн эзэмшигчийг өөрийн биед болон тээврийн хэрэгсэлд агуулагдаж байгаа шаардлагатай эд зүйлийг харуулах, ил гарган шалгуулахыг санал болгож, шаардлагатай тохиолдолд өөрийн биеэр уг ажиллагааг гүйцэтгэнэ.

29.14. Цагдаагийн алба хаагч хүний бие, тээврийн хэрэгсэл, хуулийн этгээдийн байрлаж байгаа газарт хуулиар хориглосон эд зүйл байгаа эсэхийг тогтоох зорилгоор эд зүйлсийн байршлыг өөрчлөх болон далд байгаа эд зүйлийг ил гаргахгүйгээр албаны нохой, тусгай техник ашиглан шалгасныг үзлэг хийсэнд тооцохгүй.

29.15. Хүнийг баривчлах, түр саатуулах үед тухайн хүний болон цагдаагийн алба хаагчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учрахаас урьдчилан сэргийлэх, нотлох баримтыг олж илрүүлэх, бэхжүүлэх зорилгоор хүний бие болон түүний зорчиж байгаа тээврийн хэрэгсэлд үзлэг хийнэ.

29.16. Хүний бие, эд зүйлд үзлэг хийхдээ үүрэн холбооны хэрэгсэл, цахим төхөөрөмж зэрэг мэдээллийг цахим хэлбэрээр хадгалах хэрэгсэлд прокурорын зөвшөөрөлгүйгээр үзлэг хийхийг хориглоно.

Цагдаагийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйл буюу үзлэг хийх тодорхой ажиллагааг код-215 буюу “Хүний бие, тээврийн хэрэгсэл, ачаа тээшинд үзлэг хийх журам”-аар зохицуулж байна. Гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хийдэг энэхүү арга хэмжээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд тус тус заасан үзлэгээс ялгаатай болохыг тухайн иргэнд тодорхой тайлбарладаггүй учраас энэ талаар иргэд ташаа ойлгоход хүрдэг ажээ. Иргэд энэ арга хэмжээг хүний эрхэд шууд халддаг, эсхүл зөрчил илрүүлэх зорилгоор ашигладаг гэж үзэх нь түгээмэл байна.

“Тодорхой ажиллагаа хэрэгжүүлэх үндэслэл үүсээгүй байхад явуулж байгаа эдгээр арга хэмжээ нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилго агуулдаг гэдэгтэй санал нийлэх үү?” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан 153 иргэний 63 буюу 41.2 хувь нь “Тийм”, 75 буюу 49.0 хувь нь “Үгүй”, 6 буюу 3.9 хувь нь “Магадгүй, зарим тохиолдолд санал нийлнэ”, 4 буюу 2.6 хувь нь “Тодорхой хэмжээнд санал нийлнэ” гэж хариулсан. Харин “Эрүүдэн шүүлт тулгаж, хэрэг хүлээлгэхэд урьтал нөхцөл болдог гэж миний хувьд үздэг, зөвлөн тусалдаггүй, торгохоо урьтал болгодог, хүний эрх зөрчиж буй үйлдэл, удирдлагаас ажлын үр дүнг хиймэл байдлаар нэмэгдүүлэх гэсэн агуулгатай, урьдчилан сэргийлэх ажлаа хурдан дуусгах л зорилготой” гэж 1 хүн хариулжээ.

Жишээ 12. Иргэн М.

Олон нийтийн сүлжээнд “Тэр өвсийг нь татахыг зөвшөөрчхөөч” гэсэн агуулга бүхий пост бичсэний төлөө Хар тамхитай тэмцэх газраас дуудан ирүүлж биеэс шинжилгээ авч, нүцгэлсэн тохиолдол гарсан. Ингэхдээ тухайн үед “Хар тамхи” аян зарласантай холбоотойгоор гэж тайлбарласан бөгөөд ямар нэгэн мэдүүлэг, тайлбар аваагүй, биед үзлэг, нэгжлэг, шинжилгээ хийх зөвшөөрөлгүйгээр түр саатуулсан гэдгээ хэлсэн.

Иргэдийн хувьд үзлэгийг шууд нэгжлэг гэж ойлгодог ба “Хуульд заасан үндэслэл үүсээгүй байхад үзлэг хийж болохгүй” гэж судалгаанд оролцогчдын 81.3 хувь нь үзжээ. Энэ ажиллагааг үйл ажиллагааны код журамд заасны дагуу биш, нэгжлэг гэж ойлгогдохуйц байдлаар хийж байгаагаас эрх нь зөрчигдсөн гэж үзэх нөхцөл байдал иргэдэд үүсдэг байж болзошгүй байна.

“Үзлэгийг зөрчил, гэмт хэрэг илрүүлэх зорилгоор ашигладаг” гэж ярилцлагад оролцсон 100 алба хаагчийн 60 нь дурдсан бол “Урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэдэг” гэж 32, “Үндэслэл тодорхой бус ямар ч зорилгоор ашиглаж болно” гэж 8 алба хаагч үзжээ. Үүнээс үзвэл судалсан 10 төрлийн үйл ажиллагаанаас хамгийн эрсдэлтэй бөгөөд эмзэг байж болох ажиллагаа нь үзлэг бөгөөд тухайн ажиллагааны мөн чанарыг ойлгоогүйгээс нэгжлэг хэлбэртэй хийх, эсхүл биеийн эмзэг хэсэгт хүрэх, хувийн орон зайд халдах, эсрэг хүйсийн хүн хийх зэрэг хүний эрхийн зөрчлийн шинжтэй маргаан гардаг байна.

Цагдаагийн байгууллагад иргэдээс ирүүлсэн алба хаагчтай холбоотой гомдол, мэдээллийн түүвэрлэлтээс үзэхэд нэгжлэг, үзлэг хийхдээ эрхэд халдсан гэх агуулгатай мэдээлэл тодорхой ажиллагаатай холбоотой нийт гомдол, мэдээллийн 3.5 хувийг эзэлж байна. Нэгдсэн арга хэмжээний үед үзлэг хийх тоон үзүүлэлт 30 дахин өсдөг ба энэ нь ихэвчлэн тээврийн хэрэгслийг зогсоож шалгах ажиллагаатай давхар хийгддэгтэй холбоотой гэж тээврийн цагдаагийн алба хаагчид дүгнэсэн. Харин хэв журмын цагдаагийн алба хаагчид овор ихтэй эд зүйл авч яваа, эсхүл сэжигтэй байдлаар биеэ авч яваа тохиолдолд үзлэг хийдэг гэж хариулсан бөгөөд бусад тохиолдолд үзлэг хийхээс аль болох татгалздаг гэж хариулжээ.

Үндсэндээ энэхүү тодорхой ажиллагааг хэрэгжүүлэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед хийгддэг үзлэг, нэгжлэгийн адил хэрэгжүүлж байгаа мэт сэтгэгдэл, ойлголтыг иргэдэд төрүүлдэг байж болзошгүй хандлага ажиглагдсан бөгөөд шалтгаан нь алба хаагчид үндэслэл, шалтгаан, хуулийн гаргалгааг хангалттай сайн тайлбарлаж чадахгүй байгаатай шууд холбоотой байж болно.

2.2.8. Эд зүйл, баримт бичиг түр хураан авах

30 дугаар зүйл. Эд зүйл, баримт бичиг түр хураан авах

30.1. Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ үүрэн холбооны хэрэгсэл, бусад шаардлагатай эд зүйл, тээврийн хэрэгсэл, цахим төхөөрөмж, баримт бичгийг шүүхийн зөвшөөрөлгүйгээр түр хураан авч болно.

30.2. Хураан авах ажиллагааг эхлэхийн өмнө хураан авах эд зүйл, баримт бичгийг сайн дураар гаргаж өгөх, байгаа газрыг нь зааж өгөх боломжийг тухайн хүнд олгоно.

30.3. Цагдаагийн алба хаагч хураан авсан эд зүйлийн төрөл, шинж байдал, тоо ширхгийг тусгасан жагсаалт үйлдэнэ.

30.4. Энэ хуулийн 30.3-т заасан жагсаалтыг эд зүйл, баримт бичгээ хураалгасан, эсхүл ажиллагаанд байлцсан хүний гарын үсэг, эсхүл хурууны хээгээр баталгаажуулж, хувийг эд зүйлийн эзэмшигч, эсхүл түүний өмгөөлөгчид даруй гардуулна.

30.5. Хураан авах ажиллагаанд тухайн эд зүйл, баримт бичиг, ачаа тээш, мал, амьтан, тээврийн хэрэгслийн эзэмшигчийг оролцуулна. Эзэмшигчийг оролцуулах боломжгүй бол хөндлөнгийн гэрчийг байлцуулж, эсхүл дуудүрсний бичлэгээр бэхжүүлнэ.

30.6. Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшиж байгаа албан байр, дипломат төлөөлөгчийн газрын ажилтан, түүний гэр бүлийн гишүүний оршин сууж байгаа орон байранд хураан авах ажиллагааг гүйцэтгэх бол дараах журмыг баримтална:

30.6.1. дипломат төлөөлөгчийн газрын эрх бүхий албан тушаалтан, эсхүл орон байр, эзэмшил газрыг эзэмшиж байгаа дипломат төлөөлөгч, түүний гэр бүлийн гишүүний хүсэлтээр, эсхүл тэдгээрийн зөвшөөрснөөр хийх;

30.6.2. энэ хуулийн 30.6.1-д заасан хүсэлтээ Монгол Улсын гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан гаргасан байх;

30.6.3. прокурор болон Монгол Улсын гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллийг байлцуулах.

Цагдаагийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйл буюу эд зүйл, баримт бичиг түр хураан авах арга хэмжээ нь шаардлагатай тохиолдолд шүүхийн зөвшөөрөлгүйгээр эд зүйл, баримт бичиг зэргийг хураан авахыг цагдаагийн алба хаагчид зөвшөөрсөн эрх зүйн зохицуулалт юм. Уг тодорхой ажиллагааг код-217 буюу “Эд зүйл, тээврийн хэрэгсэл, баримт бичиг түр хураан авах журам”-аар зохицуулдаг.

Уг журмын 217.3.1-д заасан түр хураан авах эд зүйл, баримт бичгийг тодорхойлохдоо ЦАтХ-ийн 30 дугаар зүйлийг баримтална гэсэн ч хуульд заагаагүй эд зүйлийг журамд тусгажээ. Харин тухайн журмаар тээврийн хэрэгслийг түр хураан авах зохицуулалттай бөгөөд энэ нь согтуурсан, мансуурсан үед тээврийн хэрэгслийг хураан авахаас хэрхэн ялгагдах нь тодорхойгүй, энэ төрлийн асуудлыг зохицуулсан журамгүй байна.

Жишээ 13. Иргэн Г.

Би согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ машин жолоодож явсан бөгөөд тухайн үед миний хажууд жолоодох эрхийн үнэмлэхтэй дүү (жирэмсэн) хамт явсан. Замын цагдаа зогсоогоод намайг эрүүлжүүлэх байранд хүргэхээр болж харин машиныг ачих шийдвэр гаргасан. Би хамт яваа жолооны эрхтэй хүндээ машинаа өгч явуулахыг хүссэн ч тийм зохицуулалт байхгүй хэмээн бидний дунд маргаан үүссэн. Дүүг харанхуй гудамжинд үлдээгээд явсан.

Цагдаагийн алба хаагчтай холбоотой дуудлага, мэдээлэлд “Цагдаагийн алба хаагч бичиг баримт авчхаад өгөхгүй байна” гэх утгатай гомдол хэд хэдэн удаа дурдагдсан бөгөөд цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн ур чадвартай холбоотойгоор дээрх маргаан үүсдэг байж болзошгүй байна. Алба хаагчийн зүгээс бичиг баримт шалгах ажиллагааг хийсний дараа, эсхүл зөрчил болон гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй гэж үзээд бичиг баримтыг нь хураан авдаг эсэх талаар тодруулахад ярилцлагад хамрагдсан 100 алба хаагчийн 55 нь “Илэрхий зөрчил гаргасан нь тодорхой, дараа нь алга болж болзошгүй тохиолдолд бичиг баримтыг хураан авдаг” гэсэн хариулт өгсөн.

“Таны бодлоор цагдаагийн алба хаагч тодорхой ажиллагаа хэрэгжүүлэх үндэслэл үүсээгүй байхад түүнийг хэрэглэж, хүний эрх зөрчиж байгаа шалтгаан нөхцөл юу вэ?” гэсэн асуултад 69 иргэн буюу 45.1 хувь нь “Тухайн нөхцөл байдлыг үнэлж мэдэхгүй байна”, 5 буюу 3.3 хувь нь “Тийм байдалд орж байгаагүй”, мөн 5 буюу 3.3 хувь нь “Дарамт шахалт, эсвэл цаг хугацаанд баригдан хурдан ажиллаж өөрөөсөө холдуулахыг боддог”, 5 буюу 3.3 хувь нь “Албан шаардлагын улмаас”, мөн 5 буюу 3.3 хувь нь “Үл ойлголцлоос болж” гэж хариулжээ. “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хуулиа мэддэггүй” гэж 6 буюу 3.9 хувь нь, “Дээд шатны дарга, удирдлагаас шалтгаалж байж магадгүй” гэж 3 буюу 2.0 хувь нь, “Хуулийг сурталчлан танилцуулахаас илүү яллах, шийтгэх өнцгөөс бүх зүйлд ханддаг”, “Хүний эрхийг хамгаалах чиг үүргээ мэддэггүй, эрх мэдлээ хэтрүүлдэг”, “Мөнгө олох гэж, өөрийн ажлын амрыг хардаг” гэж тус тус 1 иргэн буюу 0.7 хувь нь, “Эрх мэдэл, хуулиар түрий барьдаг, шууд тулгадаг”, “Янз бүрийн шалтгаан байж болно” гэж тус тус 3 иргэн буюу 2.0 хувь нь хариулсан бол “Албадлага, хязгаарлалтын арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэл үүсээгүй байхад хэрэглэсэн тохиолдол ховор гэж бодож байна” гэж 4 иргэн буюу 2.6 хувь нь тус тус хариулсан байна.

Энэ төрлийн тодорхой ажиллагааны явцад тээврийн хэрэгслийг зогсоож шалгасны дараа жолооч нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн бол тухайн тээврийн хэрэгслийг журмын хашаанд хүргэж, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхийг нь шууд хураан авч байгаатай холбоотойгоор иргэдийн дунд бухимдал үүсдэг нь нэг сар орчмын хугацаанд *facebook*, *twitter*-т байршуулсан 8500 орчим пост, контентод хийсэн анализ болон судалгаанд оролцсон иргэдийн хариултаас тодорхой ажиглагдсан. Замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн тохиолдолд тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхийг нь хураан авах зохицуулалт нь Цагдаагийн албаны тухай хууль болон ЦБҮАЖ-д тусгагдаагүй, үүнийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам” (2019 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/101 тушаал)-ын хавсралтад заасан эрхийн дагуу хэрэгжүүлж байгаа бөгөөд зөвхөн энэ арга хэмжээний улмаас иргэдийн бухимдал өндөр хэмжээнд хүрснийг *facebook*, *twitter*-т байршуулсан 2000 орчим сэтгэгдэл нотолж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт заасныг үндэслэн гаргасан Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам”-ын 4.2.1 дэх хэсгийн “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.6, 6.8 дахь хэсэгт заасны дагуу илэрсэн зөрчлийг хялбаршуулсан журмаар газар дээр нь шийдвэрлэх, хэрэв шийдвэрлэх боломжгүй бол зөрчлийг баримтжуулан, шаардлагатай бичиг баримт, эд зүйлийг хураан авч, холбогдох албан тушаалтанд шилжүүлэх” гэсэн заалтаар жолоодох эрхийн үнэмлэх хураан авсан тохиолдол хамгийн их гэж судалгаанд оролцогчид үзсэн ба энэ нь Цагдаагийн албаны тухай хуулиас давсан хэм хэмжээ гэж үзэх үндэслэлтэй байна.

2.2.9. Тээврийн хэрэгслийг зогсоож шалгах

31 дүгээр зүйл. Тээврийн хэрэгслийг зогсоож шалгах

31.1. Цагдаагийн алба хаагч дараах тохиолдолд тээврийн хэрэгслийг зогсоож шалгана:

31.1.1. жолооч замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн, эсхүл зам тээврийн осол гаргасан;

31.1.2. стандартын шаардлага хангаагүй, хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй бүрэн бус тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцсон;

31.1.3. жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодож яваа байдал нь бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд аюул учруулж болзошгүй;

31.1.4. тусгай дуут болон гэрэл дохио хэрэглэх журам зөрчсөн;

31.1.5. тээврийн хэрэгсэл нь эрэн сурвалжлагдаж байгаа, эсхүл тээврийн хэрэгслийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашигласан, эсхүл хууль бус, хуулиар хязгаарласан эд зүйл тээвэрлэж байгаа гэх үндэслэлтэй;

31.1.6. эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр албадан ирүүлэхээр даалгасан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, түүнчлэн гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа хүн тээврийн хэрэгслийг жолоодож, эсхүл түүгээр зорчиж яваа гэх үндэслэлтэй;

31.1.7. согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүн жолоодож яваа гэх үндэслэлтэй;

31.1.8. хүний амь нас, эрүүл мэндэд шууд хохирол учруулах эд зүйлийг хууль бусаар тээвэрлэсэн, эсхүл жолооч, зорчигч ийм зүйлийг биедээ авч яваа гэх үндэслэлтэй;

31.1.9. тээврийн хэрэгслийг жолоодож яваа хүн зам тээврийн ослын талаар ач холбогдол бүхий мэдээлэл өгч чадна гэх үндэслэлтэй;

31.1.10. эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр тодорхой газар нутаг, бүс дэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарласан, хориглосон;

31.1.11. цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр тодорхой төрлийн зөрчлийг илрүүлэх, онц аюултай гэмт хэрэгтэн, эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлийг олж илрүүлэх зорилго бүхий нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний үед.

31.2. Цагдаагийн алба хаагч тээврийн хэрэгслийг зогсоох дохиог жолоочид ойлгомжтой байдлаар өгнө.

31.3. Цагдаагийн алба хаагч энэ хуулийн 31.1-д заасан аль нэг үндэслэлээр тээврийн хэрэгслийг зогсоож шалгах тохиолдолд жолоодох эрхийн үнэмлэх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, бусад холбогдох бичиг баримтыг нягталж, зөвхөн тухайн үндэслэлийг шалгаж тогтооход шаардлагатай арга хэлбэрээр шалгана.

31.4. Цагдаагийн алба хаагч тээврийн хэрэгслийг зогсоож шалгах явцад дараах үндэслэл бүхий сэжиг илэрсэн тохиолдолд энэ хуулийн 25, 32, 33, 34 дүгээр зүйлд заасан ажиллагааг явуулна:

31.4.1. тээврийн хэрэгсэл нь эрэн сурвалжлагдаж байгаа гэх, эсхүл тээврийн хэрэгслийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашигласан, эсхүл хууль бусаар олж авсан эд зүйл тээвэрлэж байгаа гэх;

31.4.2. эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр албадан ирүүлэхээр даалгасан, эд зүйл болон эрэн сурвалжлагдаж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, түүнчлэн гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа хүн тухайн тээврийн хэрэгсэлд байгаа гэх;

31.4.3. согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүн жолоодож яваа гэх;

31.4.4. хүний амь нас, эрүүл мэндэд шууд хохирол учруулах, хуулиар хязгаарласан, эсхүл хориглосон эд зүйлийг хууль бусаар тээвэрлэсэн, эсхүл жолооч, зорчигч ийм зүйлийг биедээ авч яваа гэх.

31.5. Энэ хуулийн 31.1.5, 31.1.6, 31.1.7, 31.1.8-д заасан үндэслэлээр тээврийн хэрэгслийг зогсоож шалгах тохиолдолд цагдаагийн алба хаагч тээврийн хэрэгсэлд үзлэг хийх хүрээ нь эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйл, хуулиар хориглосон зүйлийг нуун далдлах боломж бүхий эд зүйл, агуулах саванд үзлэг хийхээр хязгаарлагдана.

31.6. Цагдаагийн алба хаагчийн зогсох дохио, шалгуулах шаардлагыг биелүүлээгүй, эсхүл эсэргүүцсэн бол хуульд заасан албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

31.7. Цагдаагийн алба хаагч энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу тээврийн хэрэгслийг зогсоож шалгах үед зорчигчийг тухайн газарт үлдэхийг шаардаагүй, эсхүл энэ хуульд заасан ажиллагааг гүйцэтгээгүй бол зорчигчийг саатуулсанд тооцохгүй.

31.8. Цагдаагийн алба хаагч тээврийн хэрэгслээс илэрсэн эрэн сурвалжлагдаж байгаа, эсхүл хуулиар хориглосон эд зүйлийг авч яваа этгээд нь тодорхойгүй тохиолдолд жолооч, зорчигчийг хамтад нь түр саатуулах, эсхүл эрх бүхий байгууллагад хүргэх эрхтэй.

Цагдаагийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйл буюу тээврийн хэрэгслийг зогсоож шалгах тодорхой ажиллагаа явуулах 11 төрлийн үндэслэлийг хуульчилж өгсөн. Цагдаагийн алба хаагч тээврийн хэрэгслийг зогсоож шалгах явцад дараах үндэслэл бүхий сэжиг илэрсэн тохиолдолд энэ хуулийн 25, 32, 33, 34 дүгээр зүйлд заасан ажиллагааг явуулах эрх зүйн зохицуулалттай. Энэхүү тодорхой ажиллагааг хэрэгжүүлэхдээ код-214 буюу “Бичиг баримтыг үзэж шалгах журам”, код-217 буюу “Эд зүйл, тээврийн хэрэгсэл, баримт бичиг түр хураан авах журам”, код-220 буюу “Согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх, хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах журам”-ыг тус тус баримталж байна.

Мөн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт заасныг үндэслэн гаргасан Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар баталсан (2019 оны А/101 тоот тушаал) “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам”-ын 1.2.3-т “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсгийн 8.2.1, 8.2.2, 8.2.3, 8.2.4 дэх заалт, Цагдаагийн албаны тухай хуулийн 27-37 дугаар зүйлд заасан эрхийн хүрээнд цагдаагийн байгууллага буюу алба хаагч тээврийн хэрэгслийг түр саатуулах, зөөж шилжүүлэх шийдвэр гаргаж, хэрэгжүүлэхэд энэхүү журмыг баримтална” гэсэн бөгөөд тус журмын Гуравдугаар бүлэг, Дөрөвдүгээр бүлэг, Долоодугаар бүлэг, Есдүгээр бүлэгт тээврийн хэрэгслийг зогсоож шалгах, албадан зогсоох, түр саатуулж, зөөж шилжүүлэх журмыг тусгажээ.

Судалгаанд оролцсон тээврийн цагдаагийн 133 алба хаагчийн хувьд тээврийн хэрэгслийг зогсоож бичиг баримт шалгаж буй зорилго нь “урьдчилан сэргийлж, мэдээлэл өгөх” гэж 32 буюу 24.0 хувь нь, “зарлан мэдээлсэн тээврийн хэрэгсэлтэй ижил төстэй болон илт сэжигтэй тохиолдолд” гэж 45 буюу 33.8 хувь нь хариулсныг дахин дурдах нь зүйтэй.

Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн тайлан мэдээллээс дурдвал, гарцаар гарч буй явган зорчигчдын аюулгүй байдлыг хангах, жолооч нарын хариуцлагыг өндөржүүлэх, арга хэмжээ тооцох зорилгоор “Гарцаар гарцгаая” арга хэмжээг 2020 оны 6, 7 дугаар сард зохион байгуулсан байна. Уг арга хэмжээний хүрээнд ажил эрчимжүүлэх үүрэг, ажлын чиглэлийг Тээврийн цагдаагийн албаны харьяа нэгжүүдэд хүргүүлж ажилласнаар явган зорчигчийг гарцаар гарахад зам тавьж өгөөгүй зөрчлөөр 2019 онд 419 жолоочид арга хэмжээ тооцсон бол 2020 онд энэхүү арга хэмжээний үеэр 12532 жолоочид арга хэмжээ тооцсон нь өмнөх оны мөн үеийнхээс 90 орчим хувиар өссөн байна.

Жишээ 14. Цагдаагийн алба хаагч Б.

Хэдийгээр өдөрт, эсвэл сард тээврийн хэрэгсэл зогсоож шалгах, торгох талаар ямар нэгэн тоо, лимит тогтоож өгдөггүй боловч сарын ажил дүгнэх гол үзүүлэлт болгодог бөгөөд хамгийн бага үзүүлэлтийг хангасан тохиолдолд цалин хасах тохиолдол ч бий. Үүнд алба хаагчид дургүй ч илэрхийлж чаддаггүй. Арга хэмжээ авхуулахаас эхлээд дарамт шахалтад орно гээд тэгдэг байх.

Жишээ 15. Цагдаагийн алба хаагч Ц.

“Яараад яах вэ” гэх мэт нөлөөллийн аян, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний үед ажил эрчимжүүлэх үүрэг, ажлын чиглэл ихээр ирдэгтэй холбоотойгоор тухайн цаг үед зогсоож шалгах тээврийн хэрэгслийн тоо өсдөг гэж хэлж болно. Иймэрхүү үүрэг даалгаврууд бидний хувьд иргэдтэй таагүй харилцаа үүсгэх гол хүчин зүйл болдог. Ердийн байдлаар ажлаа хийж, иргэдтэй ойлгоцож ажиллах нь уг нь зүгээр. Гэтэл цаг үеийн шинжтэй арга хэмжээ багахан хугацаанд үр дүнтэй гэхээс урт хугацаандаа үр дүнгүй, эргээд л нөгөө байдалдаа очдог гэдгийг удирдлагууд ойлгохгүй байна.

Судалгаанд хамрагдсан 153 иргэнээс “Ямар ч үндэслэлгүйгээр тээврийн хэрэгслийг зогсоож, бичиг баримт хураан, түр саатуулах зэрэг тохиолдолд танд учруулсан хохирол, эсхүл дарамт шахалт нь таны эрхийг зөрчсөн эсэх?” гэсэн асуултад 34 буюу 22.2 хувь нь “Тийм, миний эрхийг зөрчсөн” гэж хариулсан бол “Удаан хугацаагаар чирэгдэл учруулдаг” гэж 2 буюу 1.3 хувь нь, “Дүрэм зөрчвөл” гэж 2 буюу 1.3 хувь нь, “Үгүй” буюу “Миний эрхийг зөрчиж байгаагүй” гэж 114 буюу 74.5 хувь нь, “Сэхээнд орсон

аавынхаа эмийг хүргэж өгөхөөр явж байх үед зогсоож шалгаснаас хожимдож амь насыг нь аварч чадаагүй, миний эрх зөрчигдсэн” гэж 1 буюу 0.7 хувь нь тус тус хариулсан байна.

Зөрчил гаргаагүй тээврийн хэрэгслийг зогсоож шалгадаг талаар иргэдийн гомдол олонтоо давтагддаг бөгөөд иргэд үүнийг хүний эрхийн ноцтой зөрчил гэж үздэг байна. Гэвч нөгөө талаас цагдаагийн алба хаагч нь хуульд заасан чиг үүргийн дагуу албан үүргээ гүйцэтгэж байдаг. Харин тодорхой аян, арга хэмжээний үеэр тээврийн хэрэгслийг зогсоож шалгах тоо, давтамж, тохиолдол ихэсдэг нь иргэдийг хамгийн ихээр бухимдуулдаг байна.

Ер нь цагдаагийн алба хаагч хэдийд ч, хаана ч гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дурын тээврийн хэрэгслийг зогсоож, шалгах нь зөв гэсэн үзэл, хандлага дийлэнх улс оронд хүлээн зөвшөөрөгддөг. Харин зөрчил илрүүлэх зорилгоор үүнийг ашиглаж болохгүй гэсэн үзэл, хандлага байдаг.

Тухайн тээврийн хэрэгслийг зогсоож шалгахдаа ямар үндэслэлээр, юу тодруулахын тулд зогсоож шалгаж байгаагаа эхлээд танилцуулж, тайлбарлах ёстой. Тэр хүрээнд шалгах ажиллагаагаа явуулж дууссан бол өөр зөрчил илрүүлэх үүднээс бусад зүйлсийг тодруулах шаардлагагүй.

2.2.10. Согтуурсан, мансуурсан байдлыг шалгах

32 дугаар зүйл. Согтуурсан, мансуурсан байдлыг шалгах

32.1. Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэх үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд хүнийг согтуурсан, мансуурсан эсэхийг дараах аргаар шалгана:

32.1.1. харилцан ярилцах аргаар сэтгэцийн байдал, хэл ярианы өөрчлөлт, нүдний хүүхэн харааны хэвийн байдлыг магадлах;

32.1.2. өөрийнх нь зөвшөөрснөөр шулуун шугамын дагуу алхуулж, тэнцвэрээ олж байгаа эсэхийг магадлах;

32.1.3. зориулалтын тусгай хэрэгслээр шалгах.

32.2. Энэ хуулийн 32.1-д заасны дагуу шалгуулахаас татгалзсан тохиолдолд шаардлагатай гэж үзвэл тухайн хүнээс шинжилгээнд зориулж дээж авч болно.

32.3. Цагдаагийн алба хаагч нь согтуурсан, мансуурсан байдалтай байгаа жолоочид дараах арга хэмжээг авна:

32.3.1. тээврийн хэрэгслийг түр саатуулах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ул мөрийг бэхжүүлэх, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг баримтжуулах зорилгоор тээврийн хэрэгсэлд үзлэг хийх;

32.3.2. хуульд заасан үндэслэл байгаа бол эрүүлжүүлэх, түр саатуулах, эсхүл баривчлах;

32.3.3. жолоочийн бичиг баримт, тээврийн хэрэгслийн гэрчилгээг түр хураан авах;

32.3.4. тээврийн хэрэгслийг шилжүүлэн байрлуулах, эсхүл түүний хөдөлгөөнийг хязгаарлах.

Цагдаагийн албаны тухай хуулийн 32 дугаар зүйл буюу согтуурсан, мансуурсан байдлыг шалгах тодорхой ажиллагааны хүрээнд согтуурсан, мансуурсан байдлыг шалгах гурван төрлийн арга, согтуурсан мансуурсан жолоочид авах дөрвөн төрлийн арга хэмжээ байна. Уг тодорхой ажиллагааг хэрэгжүүлэхдээ код-220 буюу “Согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх, хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах журам”-ыг баримтална.

Тухайн журмын 220.3.4-т “идэвхтэй хяналт” тавих талаар дурдсан боловч энэ нь яг ямар үйлдэл, эс үйлдэхүйгээр хэрэгжүүлж болохыг тодорхой заалгүй, “мэдрэмжийг нь шалгах, сэргээх гэх мэт” гэж тодотгоод орхисон нь учир дутагдалтай.

Судалгаанд хамрагдсан иргэдээс “Ямар нэгэн замын хөдөлгөөний дүрмийн зөрчил, эсхүл санамсаргүй байдлаар зогсоож согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг шалгадаг, орон нутгийн замд шалгадаг”, “Онцын шаардлагагүй бол зогсоох хэрэггүй, мөн драгер үлээлгэхдээ хамгаалалт хийгээгүй байж үлээлгэх гэж дайрдаг” гэж тус тус 3.0 орчим хувь нь хариулжээ. Судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдын зүгээс “Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ зөрчил гаргаж байгаа иргэд цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг хүлээж авдаггүй” талаар 170 удаагийн давтамжтай хариулсан байна. Иргэдийн хувьд “Согтуурсан буюу мансуурсан байдлыг шалгахдаа зөрчил гаргаагүй хэвийн явж байхад энэ ажиллагааг явуулдагт илэрхий дургүйцдэг” гэж хариулсан.

Жишээ 16. Иргэн Д.

Баар, ресторанд үйлчлүүлээд алхаад харьж явахад цагдаагийн алба хаагчид тааралдвал согтуу гэж үзээд эрүүлжүүлэх гэж оролддог. Гэтэл эрүүлжүүлэх ажиллагаа нь эхлэхдээ үзлэгээс авхуулаад саатуулах өрөө нь хүртэл хүний эрх зөрчих нөхцөлтэй. Зүгээр явж байгаа иргэний согтуурлын зэргийг шалгаж, заавал хэрүүл маргаан, улмаар зөрчил үүсгэж эрүүлжүүлдэг нь хүний эрхийн маш том зөрчил гэж үзэж байна. Гэрт нь хүргээд өгч, гэр бүлийнхэнд нь мэдэгдэж болдоггүй юм аа гэхэд анхааруулж, зөвлөөд явуулж болдоггүй юм уу? “Хэдэн хүнийг эрүүлжүүлбэл...” гэхчлэн ажлынх нь үр дүнд нөлөөлдөг гэж би дуулсан.

Өөрөөр хэлбэл, “Согтуугаар үйлдсэн байж болзошгүй зөрчлийг нотлохын тулд, эсхүл тухайн нөхцөл байдлыг тогтоохын тулд хийх ёстой ажиллагаа” гэж асуулгад оролцсон бүх иргэн үзжээ. Иргэдийн дээрх хариултаас харахад цагдаагийн алба хаагчдын үзэж байгаа “Иргэдийн эрх зүйн мэдлэг тааруу, мэдээлэлгүйгээс зөрчил гаргаж, эрхийг нь хязгаарлахад хүрдэг” гэсэнтэй зөрчилдөж байна.

Судлаачдын зүгээс өмнө нь цагдаагийн албаны чиглэлээр хийгдсэн бүхий л судалгаанд “Иргэдийн эрх зүйн мэдлэг сул” гэдгийг зөвхөн нэг талын буюу цагдаагийн алба хаагчаас авсан асуулгын дүгнэлтээр тодорхойлсон нь учир дутагдалтай бөгөөд харин эсрэгээрээ иргэдийн эрх зүйн мэдлэг сайжирсан учир эрхээ хамгаалуулах, зөрчигдсөн гэж үзэн эрхээ сэргээлгэхээр гомдол гаргах, түүнийгээ цахим орчинд илэрхийлэх явдал нэмэгдсэн гэж дүгнэж болох юм.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Судалгааны хүрээнд Цагдаагийн албаны тухай хуулийн хүний эрхийн зөрчлийг баримтжуулах, эдгээр тохиолдлын шийдвэрлэлтийг судлах зорилго агуулаагүй бөгөөд хууль хэрэгжүүлэх явцад хүний эрхийн зөрчил гарч болзошгүй эрсдэлийг тодорхойлохыг эрмэлзсэн гэдгийг дурдах нь зүйтэй. Судалгааны үр дүнд дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

1. Судлагдсан хуулийн зүйл, хэсэг буюу Цагдаагийн албаны тухай хуулийн 23-32 дугаар зүйл, хэсгүүд өдөр тутам, байнга хэрэглэгддэг бөгөөд түүнийг хэрэгжүүлэх алба хаагчийн мэдлэг, хандлага, тодорхой төрлийн ажиллагаа явуулахдаа гаргаж байгаа харилцааны шинжтэй зөрчил, сөрөг хандлага, ур чадваргүй байдал зэрэг нь хүний эрхийн зөрчил үүсэхэд нөлөөлж буй гол хүчин зүйл болж байна. Дурдсан 10 төрлийн тодорхой ажиллагаанаас шаардлага тавих, түр саатуулах, баримт бичиг шалгах, хураан авах, үзлэг хийх ажиллагаанд иргэд шүүмжлэлтэй хандаж, эрх зөрчигдсөн гэж үзэн гомдол гаргажээ.
2. Иргэд цагдаагийн алба хаагч нь тухайн арга хэмжээг авахдаа ойлгомжтой тайлбарлаж өгдөггүй, эсхүл хэрэгжүүлэхдээ эрхээ хэтрүүлдэг, таагүй ханддаг, хууль бус шинжтэй үйлдлүүд гаргадаг гэж үзсэн ба үндэслэл, шалтгаан тодорхойгүй байгаа нь тухайн арга хэмжээг үзэмжээр хэрэгжүүлж, хүний эрхийн зөрчил гаргах суурь нөхцөл болдог гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, цагдаагийн алба хаагч, иргэд хоорондын харилцааны явцад алдаа дутагдал гарч, зөрчилдөөн үүсдэг, цагдаа-олон нийтийн хамтын ажиллагаа хэлбэрийн төдий болсон гэж дүгнэхэд хүргэв.
3. Цагдаагийн байгууллагын дээд шатны албан тушаалтан, хяналт шалгалтын нэгж нь “иргэдтэй зүй бус” харилцсан, хүний эрх зөрчсөн гэж үзсэн гомдол, мэдээллийг хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг иргэнд тодорхой өгдөггүйгээс энэ үйл ажиллагаа хууль ёсны дагуу явагдсан эсэхэд эргэлзээ үүсгэж, “Хүний эрхийн зөрчил

их байна” гэсэн дүгнэлтэд хүрэх шалтгаан болжээ. Энэ нь тус байгууллагын олон нийтэд чиглэсэн мэдээлэл хангалтгүй, ил тод биш байгааг илтгэж байна.

4. “Цагдаагийн байгууллагаас урьдчилан сэргийлэх аливаа нөлөөллийн аян, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхдээ зөвлөх, анхааруулах, сэргийлэх бус, зөрчил илрүүлэх, таслан зогсоох зорилгоор дээрх 10 төрлийн тодорхой ажиллагааг явуулж байгаа нь алба хаагч болон иргэд хооронд үл ойлголцол үүсгэдэг” гэж иргэд дүгнэж байна. Харин цагдаагийн алба хаагчид “Цаг үеийн шинжтэй, гэнэт зохион байгуулдаг дээрх арга хэмжээнүүд нь ажлын ачаалал нэмдэг, шинжлэх ухааны үндэслэлгүй, иргэдэд чиглэсэн хэлбэртэй байж чаддаггүй нь бэрхшээл учруулдаг” гэсэн хариулт өгсөн.
5. Төрөл бүрийн аян, арга хэмжээний хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх нэрийдлээр хуулийн этгээдийн байранд нэвтрэн орох, тухайн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдийн зургийг дарах, телевиз, сайтын сэтгүүлч дагуулан очиж мэдээ, дүрс дамжуулах зэргээр хүний эрх зөрчсөн үйлдлүүд түгээмэл гаргаж байна. Өөрөөр хэлбэл, цагдаагийн алба хаагч хуульд заасан эрхээ эрх бүхий өөр албан тушаалтан, хэвлэл мэдээллийн байгууллагад “ашиглуулж” хүний эрх зөрчихөд хүргэжээ. Цаашид алба хаагчаас мэргэжлийн бөгөөд хүний эрхийн мэдрэмжтэй байх гэсэн чадварыг нийгэм, иргэд шаардаж байгаа ба “Иргэдийн эрх зүйн мэдлэг тааруугаас тухайн арга хэмжээг ойлгож хэрэгжүүлдэггүй” гэсэн алба хаагчийн төсөөлөл, дүгнэлт бодит байдлаас эрс зөрүүтэй байна.
6. Цагдаагийн алба хаагчийн ажил дүгнэх үзүүлэлтийг сарын эцэст тооцож, ажлын үр дүнгээр цалин нэмэх, хасах тохиолдол “хэвшмэл” болсон нь алба хаагчдыг зөрчил илрүүлэх, шийтгэл оногдуулахад үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлэхэд хүргэжээ. “Цагдаагийн байгууллагын зүгээс алба хаагчийн ажлын байранд тавигдах шаардлагад хүний эрхийн шалгуур үзүүлэлт тусгаж өгөөгүйгээс үндсэн арга барил өөрчлөгдөхгүй байна” хэмээн алба хаагчид үзэж байгаа бөгөөд санал асуулгын үр дүн ч энэ дүгнэлтийг баталгаажуулсан.

7. Мэдлэг, ур чадварын асуудал нь харилцаанд нөлөөлж, иргэд болон цагдаагийн алба хаагчдын хооронд үл ойлголцол үүсгэж байгаа нь хүний эрхийн зөрчил гарах үндсэн шалтгаан болж байна. Цагдаагийн байгууллагаас сургалтын чанарт анхаардаггүй, сургалтын орчин, сургалтын хэрэглэгдэхүүн тааруу, удирдах албан тушаалтнууд нь сургалтад ач холбогдол өгдөггүй, алба хаагчид тухайн орчноосоо хөндийрөхгүй байгаагаас сургалтад идэвхгүй, анхааралгүй, нэр төдий оролцдог нь сургалтын үр нөлөөг бууруулах үндсэн шалтгаан болсон гэж алба хаагчид өөрсдөө дүгнэсэн. Тиймээс цагдаагийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг тогтвортой, үр дүнтэй хэлбэрээр зохион байгуулах нь зүйтэй.
8. Цагдаагийн алба хаагчид иргэдтэй зүй бус харилцах, хүний эрхийн зөрчил гаргах зэрэг асуудал нь цагдаагийн зарим алба хаагч Цагдаагийн албаны тухай хууль болон ЦБҮАЖ, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, Цагдаагийн албан хаагчийн сахилгын дүрэмд заасан цагдаагийн алба хаагчид тавигдах нийтлэг шаардлага, ёс зүйн бусад хэм хэмжээг хэрэгжүүлэхгүй байгаагаас хамаардаг. Иргэд дээрх тодорхой арга хэмжээг дэлгэрэнгүй, тодорхой хуульчилж өгөх ёстой гэж үзэж байхад алба хаагчид код, журам эрх зүйн баталгаа болж чаддаггүй, хууль сахиулах ажиллагааг хуульчлах нь (Цагдаагийн албаны тухай хуулиас тусдаа) зүйтэй гэж нийтлэг байдлаар хариулжээ. Өөрөөр хэлбэл, эндээс Цагдаагийн албаны тухай хуульд байгууллагын бүтэц, зохион байгуулалт, бусад эрх, хэмжээний талаарх зохицуулалт давамгайлснаас бус, цагдаагийн алба хаагчид тодорхой ажиллагаа явуулах, цаашлаад албадлагын арга хэмжээ хэрэглэх эрх зүйн зөв орчин бүрдүүлж чадахгүй байгаа тул Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийг тусад нь салгаж хуульчлах шаардлагатай гэж дүгнэж байна.
9. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам кодоод хийсэн дүн шинжилгээний хүрээнд цагдаагийн байгууллага нь тухайн баримт бичигт шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг тухай бүр хийхийг эрмэлзэж байгаа нь сайшаалтай юм. Харин журмыг алба хаагчийн өдөр тутмын хэрэглээ болгосон эсэх, хангалттай

сайн мэддэг эсэх, POLICE SOP аппликейшн хэрэглэж хэвшсэн эсэх зэрэг асуудлыг судалгаанд оролцсон алба хаагчид, удирдах албан тушаалтнууд хангалттай сайн дурдаагүй. Энэ нь ЦБҮАЖ-ын хэрэглээ, мэдлэгт “сайн” гэсэн дүгнэлт өгөх боломжгүй байгааг илтгэж байна.

10. ЦБҮАЖ-д байгаа нийтлэг дутагдал нь цагдаагийн алба хаагчид эрүүл мэндийн хувьд хүндэтгэн үзэх шалтгаантай (аутизм, дауны синдром, хүнд өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй гэх мэт) иргэдтэй хэрхэн харилцах талаар огт тусгаагүй байх бөгөөд энэ нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад салбар хуулиудад тусгалаа олсон хүнлэг энэрэнгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх зарчимд нийцэхгүй байна.

ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Судалгаанд тулгуурлан ЦБҮАЖ-д дараах өөрчлөлт оруулах саналтай байна. Үүнд:

№	Журмын нэр	Өөрчлөлт оруулах санал
		Цагдаагийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйл буюу “Шаардлага тавих”-тай холбоотой үйл ажиллагааны журмыг шинээр боловсруулах нь зүйтэй. Тус журмаар шаардлага тавих үндэслэл, арга хэлбэр, дараагийн арга хэмжээнд шилжих, албадлага хэрэглэх тухай сануулга, хууль сахиулагчийн шаардлагыг үл биелүүлэхээс үүдэх үр дагаврыг тайлбарлах зэрэг цагдаагийн алба хаагчаас хэрэгжүүлэх шаардлагатай тодорхой зан үйлийг тусгах саналтай байна.
1.	Код-921 буюу “Албан үүрэг гүйцэтгэх үед алба хаагч хүнтэй харилцах, биеэ авч явах байдал” гэсэн журамд заасан нийтлэг шаардлага	Уг журмын алба хаагч, ажилтанд хориглох зүйл хэсэгт “иргэдэд шаардлагатай хууль, эрх зүйн мэдлэг, мэдээллийг тайлбарлахаас цааргалах”, “тухайн иргэний хувийн байдлыг шууд дүгнэх боломжгүй тул харилцаандаа залхсан, төвөгшөөсөн байдал үзүүлэх” гэх агуулга бүхий нэмэлт оруулах.
2.	Код-218 буюу “Иргэн, албан тушаалтнаас тайлбар авах, гаргуулах журам”	ЦБҮАЖ код-218-д “тайлбар авах” гэдэг нэр томъёоны тайлбарыг “гэмт хэрэг, зөрчлийн талаар гаргасан гомдол, мэдээллийг шалгах явцад иргэн, албан тушаалтнаас хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар мэдүүлснийг бэхжүүлэн авсан...” гэж тусгасан байх бөгөөд энэ нь Цагдаагийн албаны тухай хуульд “Тайлбар авах” тодорхой ажиллагааг “Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл өгч чадна гэсэн хангалттай үндэслэл байгаа тохиолдолд хүнээс тайлбар авна” хэмээн зүйлчилснээс агуулгын хувьд бага зэргийн зөрүүтэй байх тул хуульд заасан агуулга бүхий тайлбарыг ЦБҮАЖ-д нэмж оруулах, эсхүл өөрчлөн найруулах шаардлагатай.

Өөрчлөлт оруулах саналын үргэлжлэл

3.	Код-214 буюу “Бичиг баримтыг үзэж шалгах журам”	“Хүний бичиг баримт шалгах” тодорхой ажиллагааг “Эд зүйл, баримт бичиг түр хураан авах” тодорхой ажиллагаатай андуурах, эсвэл зөвхөн “шалгах” ёстой байтал эрхээ хэтрүүлэн хэрэглэсний улмаас иргэд хохирох, үл ойлголцол үүсэх зэрэг асуудал тохиолддог байна. Тиймээс хууль, дүрэм журамд эдгээр тодорхой ажиллагааг нэгтгэх, эсвэл ялгаа заагийг нь нарийвчлан боловсруулах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, ЦБҮАЖ код-214.6-д “в/үндэслэлгүйгээр бусдын бичиг баримтыг шалгах, хураан авах, барьцаанд байлгахыг хориглох” гэж заасан бөгөөд бичиг баримтыг шалгах гэж авчхаад хурааж авах тохиолдол байнга давтагдаж байгааг иргэдийн судалгаанд өмнө дурдсан.
4.	Код-222 буюу “Байгууллага, иргэний орон байранд нэвтрэн орох журам”	Орон байр, байгууллага, бусдын эзэмшил газарт прокурорын зөвшөөрөлгүй нэвтрэн орох тохиолдлыг ойлгомжгүй байдлаар зохицуулсан нь хуульд заасан тодорхой ажиллагааны үндсэн агуулгад нийцэхгүй байна.
5.	Код-217 буюу “Эд зүйл, тээврийн хэрэгсэл, баримт бичиг түр хураан авах журам”	Уг журмын 217.3.1-д заасан түр хураан авах эд зүйл, баримт бичгийг тодорхойлохдоо ЦАТХ-ийн 30 дугаар зүйлийг баримтална гэсэн ч хуульд заагаагүй эд зүйлийг тусгажээ.
6.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал (2019 оны А/101 тоот тушаал)-аар баталсан “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам”	“Цагдаагийн албаны тухай хуулийн 27-37 дугаар зүйлд заасан эрхийн хүрээнд цагдаагийн байгууллага буюу алба хаагч тээврийн хэрэгслийг түр саатуулах, зөөж шилжүүлэх шийдвэр гаргаж, хэрэгжүүлэхэд энэхүү журмыг баримтална” гэсэн бөгөөд тус журмын Гуравдугаар бүлэг, Дөрөвдүгээр бүлэг, Долоодугаар бүлэг, Есдүгээр бүлэгт заасан заалтыг тухайн үйл ажиллагаанд хамаарах кодтой уялдуулан шинэчлэх шаардлагатай.

2. Судалгаанд хамрагдсан 10 төрлийн тодорхой ажиллагааны явцад хүний эрхийн зөрчил үүсэх эрсдэл, үүссэн тодорхой тохиолдлууд нь цагдаагийн алба хаагчийн ур чадвар дутмаг, харилцааны шинжтэй зөрчлөөс үүдэж байгаа тул сургалтын чанарт ахиц гаргаж, алба хаагчийг жилд нэгээс доошгүй удаа, долоо хоногоос дээш хугацаагаар ажлын байрнаас нь хөндийрүүлж, сургалтад хамруулах нь зүйтэй байна. Сургалтын чанар, агуулга, хэлбэр, сэдвийн талаар судалгааны зорилгод тусаагүй тул нэмж зөвлөмж өгөх боломжгүй. Асуулгаас үзвэл харилцаа, ажлын байрны стресс, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцах зэрэг сэдвээр нэмэлт ур чадварт суралцах хэрэгтэй гэж дүгнэснийг анхаарах нь зүйтэй. Өмнө хийгдсэн хэд хэдэн судалгаанд дурдагдсан сургалтыг сайжруулах талаарх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд мөн анхаарах;
3. Тодорхой төрлийн 10 арга хэмжээг явуулахад хуулийн зохицуулалтаас гадна үйл ажиллагааны журмууд нь үе шатыг нарийвчлан журамлаагүй, эрх зүйн хамгаалалт болж чаддаггүй учраас шат дарааллаар хэрэглэх боломжгүй гэж цагдаагийн алба хаагчид үзэж байх тул үүнийг анхаарч тодорхой төрлийн ажиллагаа, түүний үндэслэл, журмыг илүү тодорхой, ойлгомжтой зохицуулах. Мөн хууль сахиулах ажиллагааны тухай хуулийг шинэчлэн боловсруулж батлах;
4. Цагдаагийн үйл ажиллагаанд нийтийн сүлжээг ашиглах, албаны үйл ажиллагааг сурталчлах, цагдаагийн олон нийттэй харилцах арга барилыг (“Цагдаа-олон нийтийн хамтын ажиллагаа” гэж нэрлэсэн нь оновчгүй санагдсан) хөгжүүлэх ажиллагаанд ахиц гаргаж, иргэдтэй таатай харилцаа үүсгэх талаар идэвхтэй алхмууд хийх;
5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа аян, нэрлэсэн тодорхой арга хэмжээг гэмт хэрэг, зөрчил илрүүлэх зорилгоор зохион байгуулахгүй байх, гэмт хэргийн илрүүлэлт, зөрчлийн шийтгэл, шийдвэрлэлт, түүнд хамаарах ажлуудыг дүгнэх үзүүлэлтийг өөрчлөх, хүний эрхэд суурилсан үзүүлэлтийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;
6. Тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулснаар хүний эрх зөрчсөн гэж үзсэнтэй холбоотой гомдол, мэдээллийг хэрхэн шийдвэрлэсэн

талаар иргэнд хариу өгч байх, энэ тухай нээлттэй мэдээлэх;

7. Цагдаагийн алба хаагчийн эрх, үүргийг хэрэгжүүлж, эрх бүхий бусад албан тушаалтан, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллахдаа хүний нэр төрийг хүндэтгэх, хувийн орон зайд нь халдахгүй байх талаар тусгайлсан зааварчилгаа батлан хэрэгжүүлэх;
8. Цагдаагийн байгууллагад хандах иргэдийн хандлага, зан төлөвийн (Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээнээс өөр агуулгаар) судалгааг хөндлөнгийн судалгааны байгууллагаар гүйцэтгүүлэх;
9. Цагдаагийн байгууллагаас зохион байгуулж буй аливаа нөлөөллийн аян, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ нь урьдчилан сэргийлэх, илрүүлэх зэрэгт өндөр ач холбогдолтой боловч иргэдийн дунд зөвхөн аяны хүрээнд л цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа идэвхэждэг гэсэн түгээмэл ойлголт, хандлага нэгэнт бий болсон байна. Тиймээс эдгээр үйл ажиллагааг шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулах, эсвэл өдөр тутмын хэвшмэл үйл ажиллагаагаа сайжруулж идэвхжүүлэх.

---oOo---

ХАВСРАЛТ 1. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДААС АВСАН САНАЛ АСУУЛГЫН ХАРИУЛТ

Асуулт 1. Цагдаагийн албаны тухай хуульд заасан тодорхой ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой (24 дүгээр зүйл. Тайлбар авах, 25 дугаар зүйл. Хүний бичиг баримт шалгах, 26 дугаар зүйл. Түр саатуулах, 27 дугаар зүйл. Хуулийн этгээдийн баримт бичиг шалгах, 28 дугаар зүйл. Орон байр, бусад газарт нэвтрэн орох, 29 дүгээр зүйл. Үзлэг хийх, 30 дугаар зүйл. Эд зүйл, баримт бичиг түр хураан авах, 31 дүгээр зүйл. Тээврийн хэрэгслийг зогсоож шалгах, 32 дугаар зүйл. Согтуурсан, мансуурсан байдлыг шалгах) зохицуулалтыг ямар зорилгоор хэрэглэдэг вэ?

Хариултыг тоймлосон байдал	Хариултын тоо
Хэв журам сахиулах	11
Зөрчил гаргасан тохиолдолд.	9
Албан үүргийн дагуу.	22
Иргэний нэр, хаяг, хэн болохыг тодруулах зорилгоор	1
Ямар нэгэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилготой.	83
Дуудлага, мэдээлэл	7
Шаардлагатай тохиолдолд.	6
Урьдчилсан байдлаар	3
Албаны зорилгоор	4
Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн иргэд болон танхайрсан иргэнд	4

Үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор	10
Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээд, сэжиг бүхий тээврийн хэрэгсэл, иргэдийг шалгахад хэрэглэдэг.	1
Зөрчил гаргасан, тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодсон иргэдийн согтолтын зэргийг шалгах гэж багаж үлээлгэдэг.	1
Илрүүлэх зорилгоор	4
Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах үедээ.	17
Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зөрчлийг арилгуулах, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх зорилгоор	1
Албаны шугамаар ажил үүрэг гүйцэтгэх үедээ.	20
Гэмт хэрэгтэй тэмцэх, хөдөлгөөний аюулгүй байдал	1
Хүн, хуулийн этгээдийг шалгах, зөрчил, гэмт хэрэг илрүүлэх, таслан зогсоох	5
Хуульд заасан, хууль хэрэгжүүлэх	23
Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор шаардлага тавина. Гэмт хэрэг, зөрчилд сэрдэгдэж байгаа иргэний нэр, хаягийг тодорхойлох зорилгоор 6 цаг хүртэл хугацаагаар саатуулна. Уг албадлагын арга хэмжээнүүдийг гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг олж тогтоох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор хэрэглэнэ.	1
Хувь хүний аюулгүй байдал	3
Гэмт хэрэгтэй тэмцэх	24
Чиг үүргийн дагуу.	7
Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх	45
Иргэний хэн болохыг тогтоох	1

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэдэг.	8
Хэрэг шалгах зорилгоор	1
Гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор	61
Нотлох баримт бүрдүүлэх	9
Нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх. Урдчилан сэргийлэх, таслан зогсоох гэх мэт.	26
Зөрчил шалгахад.	18
Шаардлага тавих, бичиг баримт шалгах	10
25 дугаар зүйл	17
Ажлын зорилгоор	14
Хойшлуулшгүй ажиллагаа явуулах	41
Хязгаарлах	3
Албадлага	5
Мэдэхгүй.	13
Байхгүй.	4
26, 23	8
Хууль дүрмийг дагаж мөрдүүлэх, бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх	1
Зөрчил илрүүлэх, дуудлага, мэдээлэл хүлээн авсан тохиолдолд.	1
Зөрчилтэй бол хязгаарлалт хийх	9

Зөрчил үйлдэгдсэн эсэх болон биеийн байцаалтыг тогтоох зорилгоор	1
Эргүүл хийхдээ	2
Цагдаагийн зарим алба хаагчид албан тушаалын чиг үүргийн дагуу ажил үүргээ хэрэгжүүлэх зорилгоор өдөр тутам хэрэглэдэг.	1
23 дугаар зүйл. Шаардлага тавих	20
Мэдлэг, мэдээлэлтэй байхын тулд уншиж судалсан.	1
Шалгах	1
Хяналт шалгалт хийх үеэр.	7
Гэмт хэрэг илрүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрэн сурвалжлагдаж буй хүн, эд зүйлийг эрэх, зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээдийн тусгайлан олгосон эрхийг шалгах, хүчин төгөлдөр эсэхийг нь шалгах, зөрчлийн хуулиар арга хэмжээ тооцох зэрэгт.	1
32	24
Цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үүргийг хангах	1
Мөрдөн шалгах ажиллагаа явуулах	12
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг таслан зогсоох, илрүүлэх, шалгах, хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд хийгдэх ажиллагаа.	1
Гэмт хэрэг, зөрчлийг шалгаж шийдвэрлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, илрүүлэх	1
Үүрэг гүйцэтгэхдээ нотлох баримт бүрдүүлэх, тогтоох зорилгоор	1
Согтолтыг үзэх, эрүүлжүүлэх	1

Тээврийн хэрэгслийг согтуурсан үедээ барьж байгаа эсэх, орон байранд орж хулгай хийсэн, цагдаагийн алба хаагчийн шаардлага эсэргүүцсэн үед хэрэглэдэг.	1
Болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх	5
Нийгмийн хэв журам хамгаалах	3
Үгүй.	14
Жолоочийн аюулгүй байдал	1
Алба хаагчийн тодорхой ажиллагаа явуулах журамд зааснаар, мөн албан үүрэг гүйцэтгэх, эргүүл шалгалтын явцад.	1
Олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, өөрийгөө удирдан жолоодох чадваргүй болсон иргэдийг гэмт халдлагаас урьдчилан сэргийлж, төрийн хамгаалалтад авах зорилготой.	1
Сэжигтэй этгээдийг олж тогтоох, гэмт хэрэг, зөрчлийн улмаас алдагдсан эд зүйлийг олж тогтоох, нотлох баримт илрүүлж бэхжүүлэх зорилгоор	7
Сэжигтэн, холбогдогч, хориотой ан агнуур, аллага, эрэн сурвалжилж буй хүн, олон нийтийн болон иргэний аюулгүй байдлыг хангахад.	1
Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зэрэг нийтлэг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор	1
Аливаа гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор	1
Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй байх зорилгоор хүн, хуулийн этгээдэд шаардлага тавьж болно.	1
Иргэн, хуулийн этгээдийг гэмт хэрэг, зөрчил үйлдсэн байх, үйлдэх гэж буй байх гэж сэжиглэж буй тохолдолд шалгахад хэрэглэнэ.	1

97	1
Объектод нэвтрэх үед.	2
23, 25, 27, 31 дүгээр зүйлээр	1
27	1
Хууль тогтоомж зөрчсөн үйл ажиллагаа явуулж байгаа үндэслэл, зөрчил үйлдсэн үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд хүнийг согтуурсан эсэхийг шалгах	1
Цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаа	12
Тухайн иргэний хувийн байдал тогтоох, урьдчилан сэргийлэх зорилгоор	1
Дуудлага, мэдээллийн дагуу шалгах, эргүүлийн үүрэг гүйцэтгэх үед сэжигтэй зөрчил гаргасан үед.	10
Шаардлагатай үед.	18
Эргүүл, хяналт шалгалт хийхэд ихэвчлэн явуулдаг. Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг олж тогтоох, илрүүлэх зорилгоор хэрэглэнэ.	1
Цагдаагийн багууллагын үйл ажиллагаанд шаардлагатай.	1
Орон байр, бусад газар нэвтрэн орох	2
Шалган нэвтрүүлэх	3
23, 24, 25, 26, 27, 31, 32	1
Урьдчилан сэргийлэх	128
Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд.	1
Ямар нэгэн хүнд зайлшгүй эрсдэлтэй байдал бий болсон, тавьсан шаардлага биелүүлээгүй тохиолдолд тусгай мэх, гав хэрэглэх, цагдаагийн байгууллага нь үйлчилгээний байгууллага биш юм.	1

Хувь хүн болон аж ахуйн нэгжийн аюулгүй байдлын үүднээс	1
Нэн шаардлагатай, хойшлуулшгүй ажиллагаа явуулах зорилгоор	1
Зөрчил гаргасан иргэн болон тэдэнтэй цуг яваа иргэдийг шалгах шаардлага гардаг. Мөн сэжиг бүхий эд зүйл, ачаа тээш авч яваа тохиолдолд.	1
Үүрэг гүйцэтгэх хугацаандаа хэрэглэдэг.	1
25	17
Нийгмийн хэв журам сахиулах	1
Улсын онц чухал объектод иргэн тээврийн хэрэгсэл болон явганаар зөвшөөрөлгүй нэвтэрсэн, шалган нэвтрүүлэх цэг дээр зөвшөөрөлгүй нэвтрэхийг оролдсон үед, хамгаалж буй объектын ажилчид архи, согтруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн бол.	1
Аюул, ослоос урьдчилан сэргийлэх	1
Гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа хүн, эсхүл оргон зайлсан сэжигтэн, ялтанд албадлагын арга хэмжээ авч ажиллана.	1
Гэмт хэрэг гарсан нь тодорхой болсон үед орон байранд нэвтрэх, иргэнд үзлэг хийх, тээврийн хэрэгсэл шалгах гэх мэт.	1
Буруутай үйл ажиллагааг таслан зогсооход.	1
Түр саатуулах	1
Гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, мөн хойшлуулшгүй ажиллагаа	1
Хэрэглэх шаардлагагүй.	1
Мөрдөн шалгах ажиллагаа явуулах, эргүүл, хяналт шалгалт хийх, албаны шалгалт явуулах үед ихэвчлэн хэрэгжүүлж байна.	1

<p>32.1.1. харилцан ярилцах аргаар сэтгэцийн байдал, хэл ярианы өөрчлөлт, нүдний хүүхэн харааны хэвийн байдлыг магадлах;</p> <p>32.1.2. өөрийнх нь зөвшөөрснөөр шулуун шугамын дагуу алхуулж, тэнцвэрээ олж байгаа эсэхийг магадлах;</p> <p>32.1.3. зориулалтын тусгай хэрэгслээр шалгах.</p> <p>32.2. Энэ хуулийн 32.1-д заасны дагуу шалгуулахаас татгалзсан тохиолдолд шаардлагатай гэж үзвэл тухайн хүнээс шинжилгээнд зориулж дээж авч болно.</p> <p>32.3. Цагдаагийн алба хаагч нь согтуурсан, мансуурсан байдалтай байгаа жолоочид дараах арга хэмжээг авна:</p> <p>32.3.1. тээврийн хэрэгслийг түр саатуулах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ул мөрийг бэхжүүлэх, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг баримтжуулах зорилгоор тээврийн хэрэгсэлд үзлэг хийх;</p> <p>32.3.2. хуульд заасан үндэслэл байгаа бол эрүүлжүүлэх, түр саатуулах, эсхүл баривчлах;</p> <p>32.3.3. жолоочийн бичиг баримт, тээврийн хэрэгслийн гэрчилгээг түр хураан авах;</p> <p>32.3.4. тээврийн хэрэгслийг шилжүүлэн байрлуулах, эсхүл түүний хөдөлгөөнийг хязгаарлах.</p>	1
ЦАТХ-д заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор	2
Зөрчил гаргасан этгээдэд хууль ёсны шаардлага тавих, зөрчлийг шалган шийдвэрлэх , эзэн холбогдогчийг шалгах зэрэгт түгээмэл хэрэглэгдэнэ.	1
Хамгаалалт болон эргүүл, жижүүрт гарах хугацаандаа хуульд заагдсан зохицуулалтаар хэрэглэнэ.	1
Зөрчил илрүүлэх (үндсэн чиг үүрэг соён гэгээрүүлэх тул хамаарал бүхий заалтууд 23, 25, 27, шаардлагатай тохиолдолд 29)	1

Асуулт 2. Дээрх тодорхой ажиллагааг хэрэгжүүлэх нь өдөр тутмын хэвшмэл үйл ажиллагаа мөн үү?

Хариултыг тоймлосон байдал	Хариултын тоо
Мөн.	763
Үгүй.	156
Шаардлагатай тохиолдолд.	14
Эрүүлжүүлэх	1
Зарим нь мөн.	2
Үүрэг гүйцэтгэх хугацаанд гэж бодож байна.	3
Магадгүй.	2
Мэдэхгүй.	9
Заримдаа.	11
Зарим тохиолдолд.	3
Өдөр тутам хэрэглэгддэг.	12
Цагдаагийн үндсэн чиг үүрэг хэрэгжүүлдэг албан хаагчдын хувьд мөн.	1
Зайлшгүй шаардлагатай үед болно.	2
Ажлын байрны чиг үүргээс хамаарна.	1
Өнөөгийн нийгэмд цагдаагийн алба хаагч болгоны өөдөөс дайрч давшилж, хэл амаар доромжлох нь хэвшил болсон, тийм болохоор дээрх албадлагын арга хэмжээг өдөр тутмын хэвшмэл үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг.	1
Янз бүрээр	1
Дан агсан, согтуу тавьсан хүнтэй харилцана, үнэхээр стресстэж байна.	1

Ихэвчлэн тохиолддог.	1
Одоо үед хэвшмэл байхаа больсон.	1
Тодорхой төрлийн ажиллагааг өдөр тутам хэрэглэдэг, жишээ нь, хүн, хуулийн этгээдийн бичиг баримт шалгах.	1
Байх боломжтой.	1
Хэвшмэл.	3
Ажил ажлын онцлогоос хамаарах байх.	1
Тодорхой цаг хугацаанд	1
Өдөр тутмын хэвшмэл ажиллагаа гэх нь өрөөсгөл ойлголт ба тухайн нөхцөл байдалд тохируулж хуулийн дагуу хэрэгжүүлдэг гэж хэлж болно.	1
Тухайн нөхцөл байдлаас хамаардаг.	1
Албадлага, хязгаарлалт	1
Байнга.	1
Зарим нь мөн, зарим нь биш.	1
Хэвийн.	2
Ажил дээр	1
Ажил	1
Тогтоосон дүрэм заавар, хуульд заасны дагуу хийх цагдаагийн байгууллагын хойшлуулшгүй ажиллагаа.	1
Зөвхөн объектод үүрэг гүйцэтгэх үед.	1
Мөрдөн шалгах ажиллагаа явуулах, хойшлуулшгүй ажиллагааны үед эрэн сурвалжлах ажиллагааны үед.	1
Тухай бүрд	1
Томилгоот ажилд бол хэвшмэл.	1

Тайлбар авах, эд зүйлд үзлэг хийх	1
Урьдчилэн сэргийлж ажиллах	1
Хэвшмэл бус.	1
Зарим нь прокуророос зөвшөөрөл авч хэрэгжүүлнэ.	1
Замын цагдаад бол мөн.	1
Асуулгад хариулаагүй.	23

Асуулт 3. Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа төрөл бүрийн аян, нөлөөллийн арга хэмжээ нь дээрх тодорхой ажиллагааг хэрэгжүүлэхэд ямар нөлөө үзүүлдэг вэ?

Хариултыг тоймлосон байдал	Хариултын тоо
Эерэг.	118
Сайн.	147
Нөлөөлнө.	29
Нөлөөгүй.	30
Үзүүлнэ.	7
Үзүүлэхгүй.	16
Хэвийн.	21
Мэдэхгүй.	56
Тийм.	19
Дунд.	14
Нөлөө бага.	25
Үгүй.	79
Чухал.	12
Байхгүй.	28
Тустай.	5
Хэвшмэл.	1
Муу.	9
Сөрөг.	22
Хэвийн.	22

Шууд.	1
Шууд хариулах боломжгүй.	1
Дэмжлэг.	5
Зөв ойлголт өгөх	1
Ачаалал бууруулдаг.	6
Урдчилан сэргийлэх чиглэлээр сайн нөлөө үзүүлдэг.	25
Иргэд идэвхтэй оролцдог, зарим хүмүүс хүлээж авдаггүй.	3
Албадлагын арга хэмжээ авахгүй, эвээр шийдэх нь ихэссэн.	1
Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх	20
Зохион байгуулж буй арга хэмжээг үр дүнд хүргэх	1
Гэмт хэргийн гаралт, илрүүлэлтэд тодорхой хэмжээгээр нөлөөлнө.	4
Ажил төрөл гүйцэтгэхэд дөхөм.	1
Эрх зүйн орчныг бүрдүүлдэг.	4
Эерэг нөлөө үзүүлдэг. Иргэдийн хандах хандлага өөрчлөгдсөн.	6
Соён гэгээрүүлэх	
Урьдчилан сэргийлэх	35
Цагдаагийн албан хаагчийг хамгаалах	2
Санаа нь зөв боловч хэрэгжүүлж байгаа арга нь үр дүн муутай юм шиг санагддаг.	1
Амралтын цагаар дуудаж суулгамааргүй байна, албан хаагчдад дэндүү хүндрэлтэй залхаан цээрлүүлсэн маягаар зохион байгуулдаг болохоор эргээд огтхон ч өгөөжгүй байдаг.	1
Зөрчлийг сааруулдаг.	6

Зарласан аян ямар ч нөлөө үзүүлэхгүй байна.	2
Зөвшөөрөлгүй жагсаал цуглаан	1
Хуулийнхаа дагуу ажилладаг.	3
Арга хэмжээтэй холбогдуулан иргэд хүлээцтэй ханддаг, цөөн тооны иргэд.	1
Алдаагаа ухаарах, засах	1
Мэдлэг болон үйл ажиллагааны дутагдал гаргахаас урьдчилан сэргийлдэг.	2
Иргэдтэй харилцах харилцаанд эергээр нөлөө үзүүлдэг.	6
Бэрхшээлтэй.	1
Иргэдэд хууль, эрх зүйн мэдлэг олгодог.	4
Алба хаагчдад мэдлэг чадвар олгох	5
Иргэдэд ойлгомжтой болгох	2
Иргэдэд цагдаагийн байгууллагын талаар эерэг хандлага төрүүлэх, хууль эрх зүйн мэдлэг олгох	1
Тус аян болон нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явцыг хурдасгах болон сайн үр дүнд нөлөөлж байна.	1
Иргэд төдий л мэддэггүй.	1
Мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлдэг.	1
Дургүйцдэг.	1
Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор ашигладаг,	1
Иргэд цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа төрөл бүрийн аян, нөлөөллийн арга хэмжээнд нааштайгаар ханддаг.	1

Хууль сурталчлах	7
Ажлын өгөөж өгсөн эерэг.	1
Тухайн байдлаас болно.	1
Иргэд хуулиа мэдэж, үүргээ биелүүлэхэд тус болно.	2
Ажлын үзүүлэлт	1
Ямар ч үр дүн, нөлөө байдаггүй шүү дээ, иргэд цагдаад муу болсон.	1
Иргэдийн харилцаа, хандлага өөр болсон байдаг.	1
Эдгээр арга хэмжээ иргэдэд үр дүнтэй хүрснээр цагдаагийн байгууллагын ачаалал, үйл ажиллагаа явуулахад амар хялбар болох талтай.	1
Хүмүүст эрхийг нь зааж өгөхдөө үүргийг нь давхар тайлбарлаж, эрх зүйн мэдлэгийг нь нэмэгдүүлчихвэл илүү дутуу асуудал гардаггүй.	1
Иргэд арай эергээр хүлээн авахад	1
Алба хаагчдын иргэдтэй харилцах харилцааг эрс өөрчилж байгаа.	1
Албаны хандлага	1
Судалгаа, хяналт тогтоох	1
Хүний эрхэд халдаж болохгүй байх талаар нөлөөлж байгаа.	1
Үр нөлөөтэй аяны хүрээнд гэмт хэрэг, зөрчил тодорхой хэмжээнд буурдаг.	1
Иргэдэд эрх зүйн мэдлэг олгож, цагдаагийн алба хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлэхэд	1
Алдаа дутагдал гаргуулахгүй.	1

Иргэдийн орон байр, тээврийн хэрэгсэл, биед үзлэг, шалгалт явуулах, бичиг баримт шалгахад маш том хөшүүрэг болж өгдөг.	1
Дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэх, сэрдэгдсэн этгээд оргон зайлах, хохирсон этгээдийг хамгаалалтад авах, нотлох баримт цуглуулах гэх мэт урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлдэг.	1
Ажил үүрэг гүйцэтгэхэд хялбар, мөн хууль тогтоомжийг иргэдэд түгээх	1
Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд таниулах, иргэдийг тухайн хууль, эрх зүйн талаар тодорхой мэдлэгтэй болгох	1
Хэрэгт ач холбогдол өгөх	1
Хэрэглэхгүй байх ёстой юм шиг харилцахыг шаарддаг.	1
Олон талын ашгаа өгч чаддаг.	1
Иргэдэд албаны ажлыг зөвөөр тайлбарлаж өгөх	1
Амар байдаг. Тухайн арга хэмжээгээ танилцуулж байхдаа нөхцөл байдлаа үнэлж байдаг.	1
Гэр бүлд маань сайн нөлөө үзүүлсэн.	1
Төрөл бүрийн аян, нөлөөллийн арга хэмжээ нь дээрх албадлага, хязгаарлалтыг хэрэгжүүлэхэд нөлөөлөхгүй.	1
Иргэнтэй зөв харилцахад, хуулийг тайлбарлаж өгөхөд	1
Алба хаагчийн эрх, аюулгүй байдлыг хангадаг.	1
Иргэд арга хэмжээний талаар мэдлэгтэй болсон нь арга хэмжээг хэрэгжүүлэхэд сайн нөлөө үзүүлдэг.	1
Нийцдэг.	1
Эрх зүйн орчин муу, алба хаагчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчин муу.	1

Тодорхой нөлөөллийн аянг ойлгосон, үзсэн иргэд хууль, эрх зүйн тодорхой ойлголтод хүрсэн байдаг нь үйл ажиллагааг улам хялбар болгож өгдөг.	1
Сахилга, ёс зүйн зөрчилд холбогдохгүй байх боломж бүрдүүлдэг.	1
Ард иргэд, алба хаагч хоорондын үл ойлголцлыг тодорхой хэмжээгээр бууруулдаг.	1
Иргэд, олон нийтэд цагдаагийн байгууллагыг эерэг харагдуулах	1
Анхааруулах	10
Иргэд, цагдаагийн хамтын ажиллагаанд эерэг хандлага, оролцоог нэмэгдүүлж, эерэг нөлөө үзүүлдэг.	1
Алдаа дутагдалгүй, хууль дүрмийн дагуу ажиллахад эерэг нөлөө үзүүлнэ,	1
Алба хаагчийн сэтгэл зүйг эерэгжүүлж, иргэнтэй харилцах харилцаанд сайнаар нөлөөлдөг гэж үздэг.	1
Зарим иргэдэд их бухимдалтай байдаг учраас цагдаад их дургүй болдог.	1
Нөлөөллийн арга хэмжээнүүд ихэвчлэн дээрх арга хэмжээний эсрэг байдаг.	1
Эрх үүргээ хэрэгжүүлэхэд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх	1
Аян, арга хэмжээ албадлага, хязарлалтад нөлөөлөхгүй.	1
Сайнаар нөлөөлөх хялбар ойлгомжтой.	1
Нөлөө гээд байх юм анзаарагдахгүй байна.	1
Тухайн нөлөөллийн аянг иргэдэд сурталчлах	1
Хойшлуулшгүй ажиллагааны үед.	1
Ажлын хажуугаар үр дүн муутай ажил л болдог.	1

Цагдаагийн албанаас хэрэгжүүлж байгаа төрөл бүрийн аянаас бүх талын дэмжлэгтэй.	1
Зөрчил үйлдэгчийн ухамсар сэтгэхүйд нөлөөлөх	1
Иргэдийн энэ төрлийн эрх зүйн мэдлэг дутмаг, ойлгодоггүй, ойлгохыг хүсдэггүй байдал нь албадлага, хязгаарлалтыг хэрэгжүүлэхэд эсэргүүцэл үзүүлэх байдлаар илэрдэг.	1
Олон нийтэд мэдээлэл хүргэж, үйл ажиллагааг сурталчилснаар цагдаагийн алба хаагч хязгаарлалт, албадлагын арга хэмжээ хэрэглэхэд эерэг нөлөө үзүүлнэ.	1
Нэгэн хэвийн шүү дээ. Байдгаараа л.	1
Ач холбогдолгүй, ажил ихтэй байхад илүүц.	1
Жишээ нь, “Мал мах-2021”, “Зэвсэг-2021” арга хэмжээний хүрээнд ЦАТХ-ийн 31, 32, 25-р зүйлийг үндэслэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж байна, гэмт хэрэг, зөрчлийн тоог багасгах	1
Нөлөө үзүүлдэггүй, иргэдийн ухамсар ихэвчлэн хүлээж авдаггүй.	1
Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэх, албандаа хандах хандлагыг сайжруулах	1

Асуулт 4. Удирдлагаас бичиг баримт, тээврийн хэрэгсэл зэргийг шалгах, торгох тоо хэмжээ тогтоож өгдөг үү?

Хариултыг тоймлосон байдал	Хариултын тоо
Тийм.	158
Үгүй.	639
Заримдаа.	10
Мэдэхгүй.	48
Миний албан тушаалд хамаарахгүй.	7
Үгүй, гэвч сарын ажил дүгнэхдээ хамгийн эхний шалгуур болгодог.	1
Торгууль шахдаг.	1
Ийм чиг үүрэг хэрэгжүүлж ажилладаггүй болохоор мэдэхгүй байна.	5
Байхгүй.	1
Өгдөггүй. Зөрчилтэй тээврийн хэрэгслийг зогсоож, бичиг баримтыг шалган холбогдох арга хэмжээг авдаг.	1
Бусад	1
Үгүй, гэхдээ зөрчлийн хажуугаар зүгээр өнгөрч болохгүй.	1
Өгдөг, заавал зөрчил илрүүл гэж шахдаг.	1
Тээврийн цагдаагийн албаны алба хаагч биш тул хариулт өгөх боломжгүй.	1
Зарим дарга, ахлахууд өгдөг.	1
Тоо хэмжээ заадаггүй боловч ажлын үр дүн дээр торгууль их, бага хийсэн гэж үр дүн тооцдог.	1
Дүүрэгт тоо заадаг.	1

Мэдэхгүй байна, үгүй байх аа, чиглэл өөр учраас мэдэхгүй байна.	1
Тоо хэмжээ заадаг.	2
Тогтоосон хэмжээ байхгүй ч аль болох өндөр байхыг шаарддаг.	1
Тоо заагаагүй ч зөрчил илрүүлэх шаардлага тавьдаг.	2
Тогтоодог.	1
Одоогоор хэчнээн хүн, тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хий гэж тодорхой тоо өгч, норм тогтоосон зүйл байхгүй. Энэ нь алба хаагчийн үүргээ гүйцэтгэх явцад хийх ёстой л ажил, мөн сонор сэрэмж, мэдрэмжтэй байх хэрэгтэй.	1
Өдөр тутам биш, сард хийх торгуулийн хэмжээг заадаг.	1
Өгдөг, ялангуяа тээврийн цагдаагийн алба.	1
Торгуулийн хэмжээгээр ажил дүгнэдэг.	2
Өдөр бүр биш ч тодорхой үүрэг, чиглэл өгдөг.	1
Тийм, явган эргүүлийн үүрэг гүйцэтгэхэд тоо заадаг.	1
Цар тахалтай холбоотойгоор иргэнээс 1,5-2 м зай барих тал дээр анхаарч, аль болох зайлшгүй дүрэм зөрчсөн иргэд дээр арга хэмжээ тооцон ажиллаж байгаа.	1
Зөрчил	1
Тоо заадаггүй.	1
Хуульд заасан заалтаар	1
Ковид-19 гарснаас хойш тийм зүйл үгүй болсон. Гэхдээ ажлын үзүүлэлтийг зөвхөн торгуулиар л дүгнэж байгаа. Ажлаараа доогуур орохгүйн тулд торгуулиар өрсөлдөж байна даа. Уул нь алба хаагчдад харилцаа, хандлага, урьдчилан сэргийлэх ажил, шавьтай болж тухайн шавиа зөв хүмүүжүүлэх, ажилласан цаг гэх мэт олон зүйлээр ажлыг нь дүгнэж болох байтал торгуулийг л чухалчилж байна.	1

Торгууль тасалдаггүй.	1
Хяналт тавьж ажиллах талаар үүрэг, чиглэл өгдөг.	1
Тийм зүйл байхгүй. Өдөр тутмын үйл ажиллагаандаа цагдаагийн алба хаагч бүр тодорхой шаардлага үүссэн үед дээрх арга хэмжээнүүдийг авч ажилладаг.	1
Мэдэхгүй байна, чиг үүргийн хувьд өөр, ер нь бол тогтоодог.	1
Алба хаагч бүр гэмт хэрэгтэй тэмцэх байдлаар тээврийн хэрэгслийг шалгана, тэрнээс үүрэг даалгавар авч, тоо хэмжээнд баригдаж ажил хийнэ гэж байхгүй.	1
Тийм зүйл байхгүй байх...ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нөлөө үзүүлэх байх...	1
Эргүүлд гарахад заримдаа өгдөг.	1
Торгохоос бусдыг нь тогтоож өгнө.	1
Үүрэг, чиглэлийн хүрээнд зөрчлийн хажуугаар дуугүй өнгөрөхгүй байхыг зөвлөн зааварчилдаг.	1
Өдөрт биш, сараар тогтоодог, зүгээр байж байгаад баригдчихлаа гэх	1
Хааяа.	1
Тээврийн цагдаагийн албанаас ажил дүгнэх үзүүлэлтдээ оруулж өгсөн байдаг.	1
Торгох хэмжээ байхгүй, жилийн эцэст ажлын үр дүнгээр дүгнэдэг.	1
1-2 зөрчил илрүүлэх чиглэл өгдөг.	2
Үгүй, учир нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах чиг үүргийн дагуу зөрчилтэй иргэн, тээврийн хэрэгсэл шалгаж, зөрчил илэрвэл торгуулийн арга хэмжээ авдаг.	1
Тасаг тасагтаа өөр өөр байдаг.	1

Өдөрт биш, сард.	1
Торгуулиар ажил дүгнэдэг "хуучин" арга хэмжээг өөрчлөх хэрэгтэй.	1
Энэ бол буруу арга хэмжээ.	1
Чанараар ажил дүгнэх хэрэгтэй болов уу. Цар тахлын үед торгуулиар шахаж болохгүй.	1

Асуулт 5. Хуульд заасан тодорхой ажиллагааг хэрэгжүүлэх үед түгээмэл тохиолддог бэрхшээл болон иргэдийн хандлага

Хариултыг тоймлосон байдал	Хариултын тоо
Эрхээ мэддэг хэрнээ үүргээ мэддэггүй.	1
Эсэргүүцдэг.	137
Иргэд угаасаа дургүй байдаг.	1
Сайн мэдэхгүй.	1
Архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүмүүс шаардлага хүлээж авдаггүй.	1
Иргэдийн хандлага маш муу.	1
“Хүний эрх” гэдэг.	1
Эсэргүүцэлтэй тулгардаг.	1
Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг дутмаг, хуулийн зохицуулалт хэт нуруу.	1
Сайн.	22
Иргэд хүлээж авах нь ховор асуудал.	1
“Хүний эрхэд халдлаа” гэдэг.	1
Зарим иргэд сөргөөр хүлээн авдаг.	1
Ер нь алба хаагч ихэнхдээ бурууддаг тул аль болох энэ аргаас татгалзах болсон. Хэдий аргагүй байдалд хэрэглэсэн ч эцсийн үр дүнд яаж ийж байгаад алба хаагч бурууддаг. Тусгай хэрэгсэл хэрэглээд зөв болсон тохиолдол манай цагдаад бараг байхгүй дээ. Энэ талаар судлаад үзээрэй.	1
Хуулийн цоорхой, хуулийн хэрэгжилт.	1
Эсэргүүцэх хандлагатай байдаг.	1

Дургүй байдаг.	1
Зарим тохиолдолд иргэд цагдаагийн алба хаагчдын хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзах, эсэргүүцэх хандлагатай байдаг. Энэ нь цагдаагийн албаны нэр хүнд иргэд, олон нийтийн дунд унаж байгаатай холбоотой гэж ажиглагддаг.	1
Цагдаагийн алба хаагчид хэт хүндлэлгүй ханддаг.	1
Бичиг баримтаа шалгуулахаас зайлсхийж төвөгшөөдөг.	1
Эсэргүүцдэг, дургүй байдаг.	1
Утсаар бичлэг хийн, өөдөөс зодолдож, хэл амаар доромжилно.	1
Муу.	41
Маш их бухимдал дагуулдаг.	7
Иргэд ихэвчлэн баримт бичгээ шалгуулахаас татгалзаж дургүйцдэг.	1
Иргэдийн харилцаа.	22
Дургуйцэх	60
Иргэд маш түрэмгий болсон, цагдаагийн алба хаагчийн шаардлага биелүүлэх гэж ер нь байхгүй дээ, юм л бол бичлэг хийнэ, хэл амаар доромжилно, биед халдана.	1
Шалгуулахаас зайлсхийх, зугтах	16
Иргэд ер нь сөрөг хандлагатай байдаг.	14

Цагдаагийн байгууллага, алба хаагчийн эрх хэмжээг хуулинд өөрчлөлт оруулах замаар зарим нэгэн албадлагын арга хэмжээг хасах хэрэгтэй байна. Тухайлбал, гудамж талбайд гар дээрээс эд зүйл худалдан борлуулах, ТҮЦ зэргийг шалгах, талбай дээр жагсаал хийж байгаа хүмүүсийг албадан тараах зэрэг үйл ажиллагааг төрийн бусад байгууллагад хуулиар харьяалуулах (Жишээ нь ТҮЦ, гар дээрээс наймаа, худалдаа эрхэлж байгаа асуудлыг мэргэжлийн хяналт, татвар гэх мэт). Бүх юманд цагдаа оролцоод ирэхээр иргэдээс цагдаагийн байгууллага, алба хаагчдад хандах хандлага сөрөг болж байгаад анхаарах зайлшгүй шаардлага үүсэж байна.	1
Үгүй.	26
Иргэд хууль мэддэггүй учир бухимдал их үүсдэг.	12
Цагдаагийн алба хаагчийн шаардлага эсэргүүцэх	3
Сөрөг.	35
Иргэд уур бухимдалтай байдаг.	37
Дургүй байдаг.	60
Гаргасан зөрчлөө хүлээн зөвшөөрөхгүй.	16
Харилцааны асуудлаас болж хэрүүл маргаан үүсгэж болзошгүй.	3
Иргэд харилцааны асуудал гаргадаг.	6
Хүний эрх гэж хуулиас дээгүүр асуудал зөрчилдөөнтэй.	7
Биднийг муулсан.	1
Иргэд уурладаг.	21
Бухимддаг.	7
Үл ойлголцох байдал, тавьж байгаа шаардлагыг эсэргүүцэх зэрэг.	13
Хууль, эрх зүйн ойлгомжгүй байдал.	1

Цагдаагийн алба хаагчийг хэл амаар доромжилдог, өөдөөс гар зөрүүлдэг.	42
Байхгүй.	58
Эрхээ эдэлж байна гэх үүргээ ухамсарлахгүй байдал.	1
Согтууруулах ундаа хэрэглэсэн иргэд дайрч давшлах	1
Дүрсжүүлэх	1
Иргэд дургүй байдаг.	21
Шалгуулахаас татгалздаг.	13
Иргэдийн дургүйцэх хандлага нь давамгай байдаг.	1
Дээрх чиг үүргийг байнга хэрэгжүүлдэггүй болохоор мэдэхгүй байна.	1
Тухайн болж байгаа процессыг ойлгоогүйн улмаас иргэд өөрсдөө бухимддаг.	1
Иргэдийн уур уцаар, цагдаад хандаж байгаа хандлага зэрэг нь хүндрэл учруулдаг. Иргэдийн ухамсар, эрх зүйн мэдлэг дутмаг байна.	1
Мэдэхгүй.	58
Хуулийн мэдлэг муутай байдаг учраас эсрэг байр суурьтай ханддаг.	1
Иргэд хууль зүйн мэдлэг байхгүйгээс зарим тохиолдолд эсэргүүцэл үзүүлдэг.	1
Иргэд хууль, замын хөдөлгөөний дүрмийг бүрэн мэдэхгүй байх, мэдэмхийрэх, мэдээллийг буруу ойлгож нугалаа гаргах зэргээр бидний ажилд саад учруулж, бичиг баримтаа шалгуулахгүй байх, эсэргүүцэх, турхирах, “Үндэслэлгүй торголоо” гэж худал гомдол гаргах зэргээр саад учруулдаг.	1
Цагдаагийн алба хаагчдыг иргэд сөрөг байдлаар хүлээн авч, бухимдаж харилцдаг.	1

Иргэд болон алба хаагчдын харилцаа, хандлага.	1
Өдөр ирэх тутам харилцаа, хандлага нь цагдааг үзэн ядсан шинж ажиглагдах болсон.	1
Худал мэдүүлэх	1
Иргэд цагдааг нохойноос дор үздэг болсон.	1
Иргэдэд тавьж байгаа шаардлагыг үл биелүүлдэг, үл хүндэтгэдэг, цагдаагийн байгууллагын алба хаагчдад тавьж байгаа хангамж бага. Шаардлагатай техник, тоног төхөөрөмж хүрэлцдэггүй.	1
Эсэргүүцэн татгалздаг, цахим болсон болохоор "Цахимаар шалга" гэдэг ч шалгах багаж хомс болохоор хоорондын маргаан гардаг.	1
Иргэд цагдаад хандах хандлага, итгэл үнэмшил бага.	1
Цагдаагийн алба хаагчид ихэнхдээ буруутдаг, алба хаагчдын эрх ашиг зөрчигддөг.	1
Ард иргэд шаардлага огт биелүүлэхгүй, "үйлчилгээний алба" гээд дайрч доромжилдог. Захын хүн цагдааг хэл амаар доромжилдог.	1
Цагдаагийн алба хаагчдын эсрэг байдаг.	1
Архи уусан болон хэн дуртай нь цагдаагийн алба хаагчид руу дайрч давшилж байна.	1
Албадан саатуулах хугацаа бага тул холбогдогчийг алдах тохиолдол гардаг.	1
Миний бодлоор цагдаагийн эрхийг нэмэгдүүлсэн нь дээр гэж бодож байна, иргэд цагдаа нартай муухай харилцдаг, доромжилдог, ихэнх нь "үйлчилгээний байгууллага" гэсэн бодолтой байдаг, энэ маш буруу.	1
Чиг үүрэгт байхгүй.	1

Цагдаагийн алба хаагч шаардлага тавихад эсэргүүцэх нь бэрхшээл болдог.	1
Иргэд үүргээ биелүүлэхгүй байж эрх ярьдаг, иргэдэд албадлагын арга хэмжээний талаарх ойлголт байдаггүй, албадлага хэрэглэх үед хүний эрх ярьдаг.	1
Ноцолдох	1
Эсэргүүцэлтэй их тулгардаг, гэхдээ аль болох иргэдтэй боловсон харилцаад өнгөрдөг дөө.	1
Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг дутмагаас цааргалах хандлага ажиглагддаг.	1
Иргэд зүй бус харилцдаг, биднийг хувийн эрх ашгийн төлөө ажилладаг хэмээн доромжилдог.	1
Тавьсан шаардлагыг зарим хүмүүс хүлээн авдаггүй, биелүүлдэггүй.	1
Үйлчилгээний байгууллага тул үйлчлэх ёстой гэх хандлага гардаг.	1
Иргэд цагдаагийн алба хаагчдад дургүй болсон.	1
Түгээмэл бэрхшээл нь тухайн иргэний эрхэд халдаж буй мэтээр бодож, цагдаагийн алба хаагчийг дарангуйлагч, хүний эрхэд халдагч гэх хандлага байдаг.	1
Маш их бухимдаж, алба хаагчийн тавьсан шаардлагад уурлаж, эсэргүүцэх тохиолдол байнга байдаг.	1
Эрүүлжүүлэх байранд хоногтоо 60-70 согтуу ирдэг, 5-6 цагдаа гарч байна, ядаж 6 иргэн тутамд 1 цагдаа ногддог болмоор байна.	1
Ярьж байгаа шаардлага ойлгодоггүй, тавьсан шаардлага эсэргүүцэх	1
Эсэргүүцэл гомдол их. Иргэд хууль бусаар хийж байгаа гэж ойлгодог.	1

Зарим иргэд шалгуулах шаардлагагүй гээд үл тоомсорлодог.	1
Хүндрэл бэрхшээл байхгүй.	1
Эрхээ ярьдаг, үүргээ үл ухамсарладаг.	1
Бичлэг хийж цахим орчинд түгээдэг ба удирдлага болон ахлах албан тушаалтнууд цаад учир шалтгааныг нь зөв тогтоох	1
Иргэд шаардлага биелүүлдэггүй, эсэргүүцэж тэмцдэг, хэл амаар доромжилдог гэх мэт. Эцэст нь цагдаагийн алба хаагчийг буруутан болгох хандлага удирдлагууд, олон нийт, бүгдэд нь байдаг.	1
Гайгүй.	1
“Ганцхан намайг шалгаж саатууллаа” гэх зэргээр бусадтай барьцсан хандлага гаргадаг.	1
Хүний эрхийн асуудал, цахим орчин.	1
Цагдааг эсэргүүцэж дургүйцдэг.	1
Ковид цар тахлыг далимдуулж шалгуулахаас зайлсхийх, шаардлагыг эсэргүүцэх, хэл амаар доромжлох, биед халдах, бусдыг турхирах	1
“Цагдаа бол бидний мөнгөөр цалинждаг, үхээсэй” гэсэн хандлагатай.	1
Хэвийнээр хүлээж авдаг.	1
Иргэд гаргасан зөрчлөө хүлээн зөвшөөрдөггүй, цагдаагийн алба хаагчийг шууд буруутгаж, хуулиар олгосон эрхийг үгүйсгэдэг, хууль ёсны шаардлагыг эсэргүүцэн доромжилдог.	1
Иргэн бүрийн мэдлэг болон боловсролоос хамаарч үүнд янз бүрийн хариу үйлдэл гаргадаг.	1
Бага.	1

Бүх зүйлийг улс төртэй холбодог учраас өөрийн буруутай үйлдлийг ойлгодоггүй.	1
Нотлох баримтгүй бол гаргасан алдааг хүлээн зөвшөөрдөггүй.	1
Бичиг баримт шалгуулахаас татгалздаг.	1
Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг дутагдалтай учир эсэргүүцэх, дуудсан цаг хугацаанд ирэхгүй байх явдал гардаг.	1
Шаардлага биелүүлэхгүй “Дандаа ингэх юм, тэгэх юм” гэх зэргээр хүлээн авдаг.	1
Сум, орон нутагт хүндрэл бэрхшээл их гардаг.	1
Иргэдийн хандлага маш буруу.	1
Янз янз, ихэнх иргэд алба хаагчидтай хүндлэлгүй харилцдаг.	1
Торгуулийн арга хэмжээ авахад “Мөнгө байхгүй, маргааш өгнө” гэж хэлээд алга болдог, торгуулийн мөнгө авахад ажлын ачаалал ихэсдэг.	1
Цагдаагийн байгууллагын нэр хүнд унаж, иргэд хүндлэлгүй харилцдаг.	1
Цагдаа хэн ч биш болсон.	1
Ихэнх иргэд цагдаагийн алба хаагчийн эсрэг үйлдэл хийхийг эрмэлздэг болсон. Энэ нь цахим орчинд алба хаагчийн эсрэг иргэдийн хандлагыг буруу зүг рүү хандуулж байгаатай холбоотой гэж бодож байна.	1
Иргэд дургүйцэж, бухимдах хандлага гаргадаг.	1
Маш их төвөгшөөдөг, уцаарладаг, цагдаагийн алба хаагчийн эсрэг муу бодол өвөртөлдөг.	1
Иргэд их бухимдалтай хүлээн авдаг.	1
Эсэргүүцэх, бичлэг хийх	1

Заавал цагдаа дээр авчирч согтолтыг шалгадаг.	1
Шалгуулахаас зайлсхийх	1
Хуулиа мэдэхгүй, тайлбарлаад ойлгохгүй.	1
Алба хаагчийн өөрийн хандлагаас шалтгаалж иргэд ханддаг.	1
Алба хаагчийн шаардлагыг биелүүлдэггүй, биед халддаг.	1
Хүмүүс хууль дүрэм дагадаггүй.	1
Эрхээ мэддэг ч үүргээ ухамсарлах эрх зүйн мэдлэг дутуу байдаг, энэ нь дүүрэг дүүргээсээ шалтгаалдаг, хотын төвийн дүүргүүд, захын дүүргүүд гэх мэт.	1
Цагдаагийн алба хаагчийг буруушаах	1
Дургүйцэх, эсэргүүцэх, хэл амаар доромжлох	1
Хууль ёсны шаардлага ойлгохгүй бөгөөд эрх зүйн чадамж муу, тавьж буй шаардлага эсэргүүцэх	1
Олон шат дамжлага, иргэдийг чирэгдүүлэх	1
Албадлага хэрэглэх үндэслэл тайлбарлаж, хууль ёсны шаардлага тавихад хүлээж авдаггүй, мөн иргэд буруутай үйлдлээ ухамсарладаггүй, өөрсдийгөө өмөөрч, цагдаагийн байгууллагын нэр хүндийг унагах хандлага гаргадаг, алба хаагчдыг хэл амаар доромжилдог.	1
Ихэвчлэн иргэдийн дургүйцэлтэй тулгардаг ч зайлшгүй гэж үзсэн тохиолдолд хууль, эрх зүйн үндэслэлийг тайлбарлан ойлгуулахыг хичээдэг.	1
Цагдаагийн алба хаагчийг үл хүндэтгэж, өөрийн буруут ухамсарладаггүй.	1
Иргэд үүргээ мэдэхгүйгээс болж шаардлага эсэргүүцдэг, шалгуулахаас татгалздаг.	1
Иргэд хуулиа мэдэхгүй.	1

Иргэд эрхээ сайн мэддэг хэрнээ үүргээ сайн биелүүлдэггүй нь гол бэрхшээл.	1
Иргэд архидан согтуурсан үедээ шаардлага биелүүлдэггүй, эсэргүүцэл үзүүлдэг.	1
Иргэд эрхээ сайн мэддэг гээд алба хаагчдын тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй, хүч хэрэглэн эсэргүүцэх, хэл амаар доромжлох явдал маш их байдаг. Угтаа тухайн иргэн үүргээ ч мөн адил ухамсарлах хэрэгтэй. Ер нь цагдаагийн алба хаагчийн эрх мэдэл, алба хаагчдын эрх ашгийг хамгаалах тал дээр цагдаагийн байгууллага учир дутагдалтай ажилладаг, үүнээс болж олон алба хаагч хохирдог.	1
Иргэдийн цагдаад дургүй, сөрөг хандлага.	1
Эсэргүүцсэн, уурласан, зандарсан.	1
Согтуу хүмүүст шаардлага тавиад биелүүлдэггүй учир тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх байдал нь бэртээж гэмтээчих гээд бага зэрэг хүндрэлтэй байдаг.	1
Ихэвчлэн өөдөөс эсэргүүцэх, “Хүний эрх зөрчиж байна, цагдаа нар ийм дээрэлхүү” гэх зэргээр хараах, доромжлох зэрэг яриа байдаг.	1
Иргэд хүний эрхээ байнга ярьж, үүргээ ухамсарлаж мэддэггүй.	1
Иргэд цагдаагийн алба хаагчидтай зүй бусаар, дээрэнгүй харилцдаг.	1
Иргэд цагдаад дургүй, уур бухимдалтай.	1
Одоо үед дуртай болгон нь утсаа гаргаад бичлэг хийж, дарамт үзүүлдэг.	1
Иргэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг эсэргүүцэх хандлагатай.	1
Эрх зүйн мэдлэг дутмаг учраас тавьсан шаардлага биелүүлэхгүй байх.	1

Зарим хүмүүс нь шалгуулахаас татгалзаж, үл ойлголцол бий болдог.	1
Иргэд арга хэмжээ авахад дургүйцлээ илэрхийлдэг.	1
Хэл амаар доромжлох, өөрсдийн гаргасан зөрчлөө хүлээн зөвшөөрдөггүй.	1
Иргэд эрхээ мэддэг боловч үүргээ огт мэддэггүй.	1
Иргэд, цагдаагийн алба хаагчдын дунд үл ойлголцол төрөх нь их.	1
Хуулийн үндэс тайлбарлах	1
Бичиг баримт шалгуулах, үзлэг хийхэд төвөгшөөсөн байдлаар хүлээж авдаг. Харилцаа, хандлагын доголдол гаргаж, эрс дургүйцдэг.	1
Жишээ нь, дуудлагын дагуу очиход болон зөрчил гаргасан этгээдэд албан ёсны шаардлага тавихад дургүйцэх, эсэргүүцэх үйлдэл гаргадаг, иргэд энэ төрлийн арга хэмжээний талаарх ойлголт дутмаг байдаг.	1
Эрх зүйн мэдлэг дутуу, ардчилсан байдал хэрээс хэтэрсэн, үүргээ мэддэггүй.	1
Алба хаагч болон иргэдийн эрх зүйн мэдлэг.	1
Зөрчилтэй иргэд зөрчлөө хүлээн зөвшөөрөхгүй, хэл амаар доромжлох таагүй сэтгэгдэл үлдээдэг.	1
Албадлага, хязгаарлалт тавихад хэцүү, шаардлага биелүүлдэггүй.	1
“Сануулах, зөвлөх байдлаар өнгөрөөж болохгүй юу?” гэж ихэнхдээ хэлдэг.	1
Цагдаагийн алба хаагчдын эрх бага байна.	1
Иргэдийн харилцаа түгээмэл дургүйцсэн байдаг.	1
Ихэвчлэн ямар шалтгаанаар шалгаж байгааг асуудаг.	1

Иргэд “Цаг алдуулаа, яах гэж шалгаад байгаа юм бэ? Яараад байна” гэх.	1
Ихэнх иргэд цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцэж, унтууцдаг.	1
Байхгүй.	1
Байхгүй, чадахгүй, ихэнхдээ дургүйцэл илэрхийлдэг.	1
Хууль, дүрмээ тайлбарлахад иргэд ойлгодог.	1
Эсэргүүцэх хандлагатай байдаг, согтуурсан хүнд хууль тайлбарлаад ойлгож, хүлээж авах чадваргүй байдаг учраас хуулийн зохицуулалтаа алба хаагчийнхаа аюулгүй байдлыг хангахад чиглэсэн болгох хэрэгтэй.	1
Иргэд хууль, эрх зүйн актыг санаатай болон болгоомжгүйгээр зөрчиж, түүнийхээ бурууг цагдаагийн байгууллага, алба хаагчид хамааруулдаг.	1
Тандагч багаж байхгүй, иргэд ямар нэгэн асуудалгүй.	1
Ер нь бол гайгүй, зарим ганц нэг иргэд үл ойшоосон байдалтайгаар хандах гээд байдаг.	1
Цагдаагийн байгууллагыг “Иргэдээ хамгаалдаггүй, хууль бус үйлдэл гаргадаг, эрх мэдэлтнүүдэд үйлчилдэг, тэдний эрх ашгийг хамгаалдаг” гэх сөрөг хандлага их болсон.	1
Иргэдийн хуулийн мэдлэг дутуу байдаг, эрх ярихаас цаашгүй.	1
Эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөл.	1
Бэрхшээл байхгүй, хандлага бухимдалтай.	1
Тухайн хүний зан байдал, нөхцөл байдлаас хамаарч янз янз байдаг.	1
Хүн хүн өөр.	1
“Би тийм ч ажилтай, ийм ч ажилтай, би ямар зөрчил гаргасан юм бэ?” гэх, бас бие биетэйгээ барьцах.	1

Иргэд, мэдээж, дуртай биш.	1
Ууртай, уцаартай, зүгээр байхад нь торгож байгаа мэт аашилдаг.	1
Цагдаагийн албаны нэр хүнд маш муу тул хэрүүлтэй уруултай, мөн байнгын л уурлаж уцаарласан иргэд байдаг.	1
Алба хаагчийн мэдлэг чадвар дутмаг.	1
Юм л болбол утсаараа бичлэг хийх, бусдад өөрийгөө зөв болгож харагдуулах гэж дүр зураг үзүүлдэг.	1
Цагдаа, иргэдийн хоорондох ямар нэгэн үл ойлголцол, хүмүүсийн хоорондын сэтгэл хөдлөл, хандлагаас шалтгаалж маргаан үүсдэг.	1
Эсэргүүцэх хандлагатай.	1
Цагдаа дээрэлхүү харилцаатай гэж ойлгодог.	1
Дургүйцдэг, үзэн яддаг.	1
Иргэд үл тоосон, маргаан үүсгэсэн байдал.	1
Иргэд “Хүний эрх, эрх чөлөөнд халдаж байна” гэж хэлдэг.	1
Эсэргүүцэлтэй л их тулгарна даа.	11
Зарим үед иргэд дургүйцэх аястай байдаг.	1
Иргэд өөрсдөөс шалтгаалах зөрчил гаргаж байгаа хэр нь алба хаагчийг буруутгах хандлага түгээмэл байдаг (“Сүртэй юм, хүн болгон ийм, дарга нарыг яаж чадаж байна? Ядарсан иргэдээ дарамталаа” гэх зэрэг тухайн зөрчилд хамаагүй зүйл ярьж, өөрийнхөө гаргасан зөрчлийг жижиг зөрчил мэтээр ярих хандлага их байдаг).	1
Хуулийн ойлголт муу, зөрчил гаргасны үр дагаврын талаар ойлголт байхгүй.	1

Согтуу иргэд бол маш их уур бухимдалтай байдаг, цагдаагийн алба хаагчийн биед халдаж, хэл амаар хүссэнээрээ доромжилж харилцахад маш их хүндрэлтэй байдаг.	1
Ууртай, эсвэл аргацаагаад гялс салах гэсэн хандлага гаргадаг.	1
Цалингийн асуудал.	1
Жолооч нар цагдаагийн ажлыг ойлгодоггүй.	1
Хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын талаар иргэд ойлгодоггүй, мэддэггүй.	1
Зөрчил үйлдсэн этгээдүүд уурлаж уцаарладаг. Гэмгүй иргэд үүргээ биелүүлж шалгах шаардлагатай талаар тайлбарлаж өгөхөд зүгээр шалгуулдаг.	1
Иргэд хууль, эрх зүйн мэдлэг, мэдээлэл дутмагаас үл ойлголцол үүсдэг.	1
Иргэд арга хэмжээ авахуулах маш дургүй, сануулах арга хэмжээ авч өгөх талаар хэлдэг.	1
“Ганц удаа сануулчихаж болдоггүй юм уу?” гэж ихэнх үед хэлдэг.	1
“Хүний эрхэд халдлаа, бэртээж гэмтээлээ” гэх.	1
Цагдаагийн алба хаагчийн тавьсан шаардлагыг үл ойшоосон байдал гардаг.	1
Сайн мэдэхгүй байна.	1
Иргэд хууль, эрх зүйн мэдлэггүй, хууль мэддэг ч хуулийн шаардлага биелүүлэх дургүй, гуйвуулан ярьдаг. Шаардлага биелүүлэх дургүй.	1
Маш их бухимдаж, элдэв үгээр доримжилдог.	1
Үл тоосон байдал гаргадаг.	1

Цагдаагийн алба хаагчийг иргэд ойлгохгүй, сөрөг хандлагатай байгаа.	1
Харилцаа.	1
Зарим иргэдэд шаардлага тавихад биелүүлэхгүй, утсаараа бичлэг хийдэг талтай болсон. Мөн ихэнх иргэд цагдаагийн алба хаагчийг үл тоох хандлагатай болжээ.	1
Бухимдаж уурладаг, дургүйцдэг, эсэргүүцэх тохиолдол цөөнгүй байдаг санагддаг.	1
Замын цагдаагийн хувьд эргүүлийн үүрэг ганцаараа явуулдаг, аюулгүй байдал алдагддаг.	1
1. Иргэд үүргээ биелүүлдэггүй; 2. Замын дуудлагад явж байгаа зохицуулагч нь жолоочтой байх шаардлагатай, ганц алба хаагч тэр болгонд хүрч ажиллахад хүндрэлтэй.	1
Эсэргүүцэл үзүүлдэг.	1
Иргэдийн хуулийн боловсрол хангалтгүй, мөн сошиалаар хуулийг илт улс төржүүлэн гуувиулж байгаа нь үйл ажиллагаа, албадлага явуулах үед ихээхэн зөрчилдөөн үүсгэж, үүнээс алба хаагч буруудах хандлагууд түгээмэл болсон.	1
Шаардлага биелүүлэх үүрэгтэй гэдгээ ухамсарладаггүй.	1
Баталгаа гаргасан ч хүрэлцэн ирдэггүй.	1
Мэдэхгүй.	1
Өвчин, гачигдал дутагдал л ярьдаг.	1
Иргэдийн хандлага хэцүү болсон байна.	1
Агсамж, тусгай хэрэгсэл нь бэлхүүсний харалдаа байдаг учир иргэдтэй ноцолдох, албадлага хэрэглэх үед ташаа, бэлхүүс хэсэг нухагдах, шалбарч гэмтэх эрсдэлтэй. Мөн тусгай хэрэгслээ хаяж гээгдүүлэх магадлалтай байдаг.	1
Удирлагууд өөрсдөө “Явуул” гэдэг.	1

Иргэдийн хандлага маш хэцүү болсон бөгөөд алба хаагчид халдлагад өртөж байна.	1
Иргэд “Та нар тэрийг чадахгүй байж биднийгээ дээрэлхдэг” гэх мэт. Эсэргүүцэн, шаардлага үл биелүүлэх	1
Хуулийн зүйл, заалтаа сайтар тайлбарлаж өгвөл бэрхшээл гарахгүй байх.	1
Хуульд заасан үндэслэлийн дагуу цагдаагийн алба хаагчийн тавьсан зүй ёсны шаардлагыг эсэргүүцэж, биед халдаж байх үед албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх үед иргэд үүнийг цагдаа хүний биед халдаж зодсон мэт ойлголттой байдаг.	1
Иргэд голдуу бичиг баримтгүй явдаг.	1
Эсэргүүцэл, ямар ч хүндэтгэл байхгүй, ёс зүйгүй хүмүүс л байдаг.	1
Иргэд хууль сайн мэдэхгүй, нэг л дээрэнгүй болсон, үл ойшоосон байдалтай харилцдаг байдлаас үл ойлголцол төрдөг.	1
Цагдааг “Хүний муу цагдаа” гэж үздэг иргэдийн хандлага харилцахад саад болдог.	1
Иргэд уурлаж бухимддаг, цагдаагийн алба хаагчийг доромжилдог.	1
Мэдэхгүй.	1
Харилцааны зөрчил болон энгэрийн камер ашиглаагүй.	1
Тийм арга хэмжээ авч байгаагүй учир мэдэхгүй байна.	1
Иргэдийн зүгээс зарим тохиолдолд эсэргүүцсэн хандлага илэрдэг.	1
Албадлага, хязгаарлалтын арга хэмжээг хэрэгжүүлэх үед түгээмэл тохиолддог бэрхшээл нь тухайн этгээдийн хууль, эрх зүйн мэдлэг дутмаг байгаагаас болж бэрхшээл үүсдэг.	1
Сайн мэдэхгүй байна.	1

Хууль ёсны шаардлага биелүүлдэггүй.	1
Албан ёсны нэвтрэх зөвшөөрөл авахгүй ирдэг, тавьсан шаардлага биелүүлдэггүй, дарга, захирагч нараар яриулдаг.	1
Цагдаа биш болохоор сайн мэдэхгүй байна.	1
Цагдаагийн алба хаагчийн үгэнд орохгүй байх.	1
Ойлгомжгүй байдал ихэнхдээ үүсдэг.	1
45-аас дээш насныхан тавьсан шаардлага биелүүлэхгүй зүйл ажиглагддаг, танил талаараа яриулдаг.	1
Бэрхшээл байхгүй.	1
Иргэд эрхээ мэдэх боловч үүргээ ухамсарладаггүй, нэг хүний эрх нөгөө хүний эрхээр хязгаарлагддаг гэж мэддэггүй.	1
Цагдаагийн байгууллагын нэр хүндэд улс төрийн буруу шийдвэр нөлөөлж байна.	1
Цагдаагийн алба хаагчид болон иргэд хоорондын харилцаанаас	1
Харилцааны асуудлууд их гардаг, хэлсэн үг, хуулийг ер ойлгодоггүй.	1
Иргэд хүний эрх, эрх чөлөө ярьдаг, шаардлага тавьж байгаа алба хаагчид нь хууль, дүрэм журмын хувьд тодорхой, зөв, оновчтой хариулт өгч, шаардлага тавьж чаддаггүй.	1
Хууль ёсны шаардлага биелүүлдэггүй, буруу үйлдлээ ухамсарладаггүй.	1
Ер нь дургүйцсэн, үл ойшоосон байдал үзүүлдэг.	1
Иргэд янз бүрээр хүлээж авна.	1
Бэрхшээл байхгүй.	1
Тогтворгүй.	1

Харилцааны соёлдоо анхаар, иргэд ээ!!!	1
Иргэд гар утсаараа их бичлэг хийдэг, алба хаагчийг зөвтгөх талаас нь шалгадаг хүн ховор.	1
Алба хаагч харилцаан дээрээ анхаарах, бүх хүнтэй баян, ядуу гэж ялгахгүй, адил, тэгш шаардлагаа тавиад энгэрийн камераар баталгаажуулахад ямар нэгэн хүндрэл байхгүй байх гэж бодож байна, миний бодол.	1
